



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 6 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-64
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	65-153
<i>1. Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүн 2023.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн/</i>	68-70
<i>2. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	70-107
<i>3. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	107-119
<i>4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	119-123
<i>5. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	123-131
<i>6. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	131-146
<i>7. Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын Чингис хаан банкинд байришиж буй сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар болон Капитал банкны эрх хүлээн авагчийн мэдээлэл</i>	146-153

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 6 дугаар сарын 20-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, С.Ганбаатар, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ц.Туваан.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын эхэнд хэлэлцүүлэх гэсэн горимын санал гаргав. /10.28/

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүн 2023.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодгэрэл, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын П.Анужин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, С.Чинзориг, Н.Учрал, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын П.Анужин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

П.Анужин: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “даатгуулагч” гэсний өмнө “нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор” гэж нэмж, мөн заалтын “заасан хувь хэмжээгээр” гэснийг “заасны дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.15 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 5, 6 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасаж, мөн зүйлийн 7.2.3 дахь заалтын “гадаад орноос Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар” гэснийг “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар” гэж өөрчилж, 7.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсад байрладаггүй өөрийн төлөөний газраар дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтан;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалтын “ганц гишүүнтэй ажил олгогчийн захирал,” гэснийг, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “эсхүл эцэг” гэсний дараа “, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч эх, эсхүл эцэг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалтын “ганц гишүүнтэй ажил олгогчийн захирал,” гэснийг, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “эсхүл эцэг” гэсний дараа “, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч эх, эсхүл эцэг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

П.Анужин: 4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 7.4.10 дахь заалт нэмж, мөн зүйлийн 7.5.1 дэх заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасах.

“7.4.10.өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.10 дахь хэсэг нэмэх:

“7.10.Даатгуулагч сайн дураар даатгуулсан хугацаанд энэ хуулийн 19.1.2-т заасан гэрээгээр ажил гүйцэтгэсэн бол энэ хуулийн 7.9 дэх хэсэг хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 4

Татгалзсан: 5

Бүгд: 9

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.10 дахь хэсэг нэмэх:

“7.10.Даатгуулагч сайн дураар даатгуулсан хугацаанд энэ хуулийн 19.1.2-т заасан гэрээгээр ажил гүйцэтгэсэн бол энэ хуулийн 7.9 дэх хэсэг хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 8, 9, 10, 11 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 8, 9, 10, 11 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4, 12.1.5 дахь заалт нэмэх:

“12.1.4.энэ хуулийн 13.3-т заасан зөвлөлийн гишүүний урамшуулал, үйл ажиллагааны зардал;

12.1.5.нийгмийн даатгалын сангаас төлөх шимтгэлийн төлбөр;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын “Монголбанкнаас тогтоосон системийн ач холбогдол бүхий” гэснийг “Банкны тухай хуулийн

3.1.20-д заасан” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “үүрэг бүхий” гэсний дараа “орон тооны бус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 14, 15, 16, 17 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 14, 15, 16, 17 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “хувь хэмжээ,” гэсний дараа “хэрэглэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын “бүсийн болон хээрийн нэмэгдэл,” гэснийг хасаж, мөн зүйлийн 19.1.4 дэх заалтын “зүйлийн 19.1.1, 19.1.2-г” гэснийг “хуулийн 19.1.1-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 20 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.28 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 21.31 дэх хэсгийг хасах:

“21.28.энэ хуулийн 7.7-д заасан даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуульд заасны дагуу нийгмийн даатгалын зохих санд төлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “4 дүгээр” гэснийг “8 дугаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 23, 24, 25, 26 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 23, 24, 25, 26 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтын “төлсөн” гэсний дараа “тэтгэврийн даатгалын” гэж нэмж, мөн зүйлийн 27.4 дэх хэсгийн “тусгай дансанд” гэснийг “тусгайлан” гэж, 27.7.2 дахь заалтын “системийн ач холбогдол бүхий” гэснийг “Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 28 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийн “орлогыг” гэснийг “орлогын тодорхой хувийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 29.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож зөрүүг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 30, 31, 32, 33 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 30, 31, 32, 33 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.5 дахь заалтын “ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг хуулиар тогтоосон” гэснийг “ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ болон энэ хуулийн 21.1-д заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 34 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 34 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “үйлдвэрчний эвлэлээс” гэснийг “байгууллагаас” гэж өөрчилж, мөн зүйлийн 35.3 дахь хэсэг, 35.16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 35.15, 35.16 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 35.9 дэх хэсгийг хасах:

“35.3.Ажил олгогч болон даатгуулагчийн төлөөллийн байгууллага нээлттэй сонгон шалгаруулах журмаар нэр дэвшигчийг сонгон Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд ирүүлнэ.

35.15.Үндэсний зөвлөлийн дүрэм болон энэ хуулийн 35.3-т заасан нээлттэй сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.

35.16.Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.17 дахь хэсгийн “тогтолцоо, хууль тогтоомж, нийгмийн даатгалын” гэснийг, мөн зүйлийн 35.20 дахь хэсгийн “Энэ зүйлийн 35.14-т заасан” гэснийг тус тус хасаж, 35.17 дахь хэсгийн “аудитын” гэсний дараа “орон тооны бус” гэж, 35.19 дэх хэсгийн “35.17-д заасан” гэсний дараа “мэргэжлийн хорооны ажиллах журам,” гэж тус тус нэмж, 35.17 дахь хэсгийн “ажиллуулж, урамшуулал олгоно” гэснийг “ажиллуулна” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 35.20 хэсэг нэмэх:

“35.20.Энэ хуулийн 35.19-т заасан урамшууллыг мэргэжлийн хорооны гишүүний ажлын үр дүнг харгалзан Үндэсний зөвлөл олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалтын “нормативыг” гэснийг “дээд хязгаарыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.3, 37.9, 37.12 дахь хэсгийн “өвчин судлалын” гэсний дараа “төрөлжсөн мэргэшлийн” гэж, мөн зүйлийн 37.12 дахь хэсгийн “нийгмийн хамгааллын” гэсний дараа “болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 38 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 38 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1.5 дахь заалтын “, хууль тогтоомж зөрчихийг зөвлөх, тулгах, шаардах” гэснийг хасаж, мөн зүйлийн 39.1.7 дахь заалтыг “39.1.7, 39.1.8, 39.1.9” дахь заалт болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 40, 41, 42, 43, 44, 45 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 40, 41, 42, 43, 44, 45 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 дэх заалтын “хорогдуулах” гэснийг “богиносгох” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “үүссэн үүргийн дагуу” гэснийг “тогтоосон” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “343 дугаар зүйлд заасан ажил гүйцэтгэх, мөн хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах” гэснийг “343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх болон хөлсөөр ажиллах гэрээ” гэж, 29 дүгээр зүйлийн 29.5.2 дахь заалтын “тусгай” гэснийг “тухайлсан” гэж, 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “хуулиар тогтоосон” гэснийг “хуулийн 25.1-д заасан” гэж, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 35.6 дахь хэсгийн “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Төв” гэснийг “Магадлалын төв” гэж тус тус өөрчилж, 44 дүгээр зүйлийн 44.6, 44.7 дахь хэсгийг 44.8, 44.9 дэх хэсэг болгон шилжүүлэх.

2.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “(цаашид "Итгэмжит зөвлөх" гэх), (цаашид "Зөвлөх" гэх) (цаашид "Тэргүүлэх" гэх)” гэснийг тус тус хасах гэсэн найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй болон найруулгын саналаар санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн /Шинэчилсэн найруулга/ төслийг дагасан болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

-Нийгмийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Дипломат албан тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хоёр.ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

II.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1 дэх заалтын “0-16” гэснийг “0-18” гэж, 37.2.2 дахь заалтын “16” гэснийг “18” гэж, 37.2.2, 37.2.3 дахь заалтын “эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөл” гэж, 37.3 дахь хэсгийн “комисс” гэснийг “зөвлөл” гэж, 37.4 дэх хэсгийн “37.2.1, 37.2.2-т” гэснийг “37.2.1-д” гэж, 37.5 дахь хэсгийн “37.2.1-37.2.3-т заасан комиссын” гэснийг “37.2.1, 37.2.2-т заасан зөвлөлийн” гэж, 37.9 дэх хэсгийн “комиссоос” гэснийг “зөвлөлөөс” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсгийн “37.2.2” гэснийг, 37 дугаар зүйлийн 37.5 дахь дэх хэсгийн “-37.2.3” гэснийг тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Гурав.БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “татварын өрөө барагдуулаагүй татвар” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өрөө барагдуулаагүй татвар, шимтгэл” гэж, мөн заалтын “татварын” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “73.1.4¹” гэснийг “73.1.4.а” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Дөрөв.ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйл болгох:

“3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн тайлбар хэсгийг хассугай.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 8.2, 8.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Тав.ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалтын “тэтгэвэр, тэтгэмжийн” гэснийг “тэтгэврийн” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 10
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалтын “тэтгэвэр, тэтгэмжийн” гэснийг “тэтгэврийн” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Зургаа.ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсэг,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“**3 дугаар зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Долоо.ТАТВАРЫН ЗАРИМ ХУУЛЬ БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “гарчиг” гэснийг “нэрийн “ДААТГАЛЫН ТУХАЙ” гэснийг “ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ” гэж, мөн зүйлийн “45 дугаар зүйлийн 45.1.3” гэснийг “44 дүгээр зүйлийн 44.1.3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Найм.ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “44 дүгээр зүйлийн 44.6-д” гэснийг “43 дугаар зүйлийн 43.5-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэх үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Татварын өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Эдийн засгийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Анужин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодгэрэл, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

-Төслийн 1 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

П.Анужин: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан 2.1.6 дахь хэсэг нэмэх:

“2.1.6.”хүндэтгэн үзэх шалтгаан” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.41-д заасныг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3

Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийн ”ТОГТОЛЦОО” гэснийг “ТӨРӨЛ” гэж өөрчилж, төслийн 3 дугаар зүйлийг 4 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хувийн нэмэлт тэтгэвэр

4.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.2-т заасан даатгуулагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж нэмэлт тэтгэвэр авч болно.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон дугаарыг өөрчилж зүйлийн гарчгийн “тэтгэвэр” гэснийг “тэтгэврийн төрөл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсгийн “55” гэснийг “50” гэж, “50” гэснийг “45” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.1.4 дэх заалтад хамаарах тайлбарыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Даатгуулагч” гэснийг хасаж, “төрсөн,” гэсний дараа “мөн энэ хуулийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, 5.1.7-д заасан даатгуулагч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 7 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

П.Анужин: 6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн томьёоны “НДс2” гэснийг “НДс3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-г “10” гэснийг “20” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

П.Анужин: 7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 21, 22, 23, 24, 25, 26 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн , 22, 23, 24, 25, 26 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

П.Анужин: 8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “04” гэснийг “01” гэж өөрчлөн, мөн зүйлд доор дурдсан 27.2 дахь хэсэг нэмэх:

“27.2.Энэ хуулийн 27.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлалыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 28 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

П.Анужин: 9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.1.Энэ хуулийн 27.1 дэх хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан 29.3 дахь хэсэг нэмж, 29.3 дахь хэсгийн дугаарыг “29.4” болгож, мөн хэсгийн “25.1-д” гэснийг “25.1, 29.3-г” гэж өөрчлөх.

“29.3.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө дараалсан зургаа, долоон жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний хүсэлтэд үндэслэн энэ хуулийн 20.1-д заасны дагуу нэг удаа өөрчлөн бодно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг суурь болгож, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын гишүүдээс өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгтгэн хэлэлцэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагасан болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсон тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн

тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,” болон “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрөл: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хоёр.ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/”, гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрөл: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, “Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнд өндөр насны тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тогтоож, олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил үг хэлж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр тайлбар хийв.

Зөвшөөрөл: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Гурав.ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар” гэж, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-г” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д” гэж, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж, 24 дүгээр зүйлийн “нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн **“3 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг **“4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин

төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, “Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, “Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Дөрөв.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ
ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/”, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Тав.ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН
ТУХАЙ**

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хуульд” гэснийг “хуулийн” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/”, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Зургаа.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг төсөл санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Долоо.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн холбогдох техникийн засварыг хийж, төслийн 2 дугаар зүйлийн “дараах заалтыг” гэснийг “дараах хэсэг, заалтыг” гэж, “өөрчилсүгэй.” гэснийг “өөрчлөн найруулсугай.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, хуулийг дагаж мөрдөхөөс өмнө дараалсан 6, 7 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний хүсэлтэд үндэслэн хуулийн 20.1-д заасны дагуу нэг удаа өөрчлөн бодож, зөрүүг буцаан олгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Анужин тайлбар хийв.

Зөвшөөрөл: 1
Татгалзсан: 8
Бүгд: 9

11.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодгэрэл, Төв аймгийн

Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Анужин: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрх үүсэх нөхцөл, хэмжээ, хугацаа,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн “хөнгөлөлт” гэсний дараа “, шимтгэлийн төлбөр” гэж нэмж, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн “тэтгэмжийг” гэснийг “тэтгэмж, шимтгэлийн төлбөрийг” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.1.4 дэх заалт нэмэх:

“2.1.4.гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн төлбөр.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

П.Анужин: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, мөн хэсгийн “3-60” гэснийг “3-59” гэж, “61-120” гэснийг “60-119” гэж, “121-180” гэснийг “120-179” гэж, “181” гэснийг “180” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4

Бүгд: 9
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 5, 6 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

П.Анужин: 4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийг хасах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 8 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

П.Анужин: 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Энэ зүйлийн 9.1-д заасан нөхцөлийг” гэснийг хасаж, мөн хэсгийн “нөхцөлийг” гэснийг “эрхийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан” гэснийг “Даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмжийг түүний шимтгэл төлсөн хугацааг харгалзан ажилгүй болохын өмнөх шимтгэл төлсөн” гэж, мөн хэсгийн “24-60” гэснийг “24-59” гэж, “61-120” гэснийг “60-119” гэж, “121-180” гэснийг “120-179” гэж, “181” гэснийг “180” гэж, мөн зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3

Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хүсэлтээ” гэснийг “хүсэлт, ажил идэвхтэй хайж байгаа тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын тодорхойлолт болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 12, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 12, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

П.Анужин: 9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагасан болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

-Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Тэтгэмжийн доод хэмжээг тогтоох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодгэрэл, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

П.Анужин: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дахь хэсэг, мөн зүйлийн 3.1.3, 3.1.5 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Даатгуулагч дараах нөхцөл байдалд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:”

3.1.3.ажлын цагаар ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд ажил үүргээ гүйцэтгэхээр явж байх үед;

3.1.5.ажилдаа ирэх, буцах зам, ажил үүргийн дагуу сургалтад оролцох болон Хөдөлмөрийн тухай хуулийн 93.1.1-д заасан амрах, хооллох завсарлагын үед;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “ноцтой” гэснийг хасаж, 3.1.8 дахь заалтын “зэрэглэлтэй дотоодын спортын тэмцээн, уралдаанд” гэснийг “хэмжээний спортын тэмцээнд” гэж, 3.2 дахь хэсгийн “тохиолдолд үйлдвэрлэлийн осолд тооцохгүй” гэснийг “нь нотлогдсон тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй” гэж, 3.3 дахь хэсгийн “ослыг” гэснийг “осол, хурц хордлогыг” гэж, 3.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

П.Анужин: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас” гэснийг “дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос” гэж, 5.3 дахь хэсгийн “Эрүүл мэндийн магадлалын” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан” гэж, мөн зүйлийн 5.4 дэх хэсгийн, 5.4.1, 5.4.2, 5.4.3 дахь заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, 5.4.1 дэх заалтын “дундаж” гэснийг “нийлбэрийг 12-т хуваасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.5.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд хөдөлмөр эрхэлж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар, 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 0.167 хувиар тооцон тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “6 сарын дотор” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “17.1-д” гэснийг “16.1-д” гэж, мөн зүйлийн 7.3, 7.4 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж, 7.7 дахь хэсгийн-“тэтгэврийн ердийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “6.1.1-д заасан хэмжээтэй” гэснийг “21.1.1, 21.2-т заасан хэмжээтэй тус тус” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсгийн, 9.3.2, 9.3.3 дахь заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, 9.3.1 дэх заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “дундаж цалин хөлс” гэж, мөн заалтын “дундаж” гэснийг “нийлбэрийг 3-т хуваасан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн “Даатгуулагчийн” гэсний дараа “тэтгэмж бодох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 10 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “/байцаагч/-д” гэснийг, 11.2 дахь хэсгийг “/байцаагч/ гэснийг тус тус хасаж, 11.1.3 дахь заалтын “мэргэжлийн” гэснийг “хөдөлмөрийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “Шимтгэлийн” гэснийг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн” гэж өөрчилж, мөн хэсгийн “хэмжээгээр тооцож” гэсний дараа “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “даатгалын” гэсний өмнө “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмж, 13.3 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7, 14.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно:”

14.7.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.9.Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний” гэснийг “сэргээн засах болон” гэж, 14.1.3 дахь заалтын “рашаан,” гэснийг “сэргээн засах төв болон” гэж, мөн зүйлийн 14.2 дахь хэсгийн “Даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг нийгмийн даатгалын” гэснийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж, 14.3 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид протез” гэснийг “Протез” гэж, мөн зүйлийн 14.5 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч” гэснийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч” гэж, 14.6 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид” гэснийг “Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас сэргээн засах төв болон” гэж, мөн зүйлийн 14.8 дахь хэсгийн “Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний” гэснийг “Сэргээн засах болон” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3

Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн” гэснийг “хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан” гэж, мөн хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 15.7 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9
44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн” гэснийг “хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан” гэж, мөн хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 15.7 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бөгөөд” гэсний дараа “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмж, 16.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 16 дугаар зүйлийн 16.3.2 дахь заалтыг хасах:

“16.3.1.ажил олгогчийн шимтгэл төлөлт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон ажил олгогчид үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо, холбогдох бусад мэдээллийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гарсан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3.3 дахь заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “хөдөлмөр, халамж үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, мөн зүйлийн 16.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус өөрчлөх өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 17, 18 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 17, 18 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “биелүүлэх үед” гэснийг “гүйцэтгэх явцад” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “авах өргөдөл гаргахад” гэснийг “тогтоолгоход” гэж, 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийн “авах өргөдөл гаргахад” гэснийг “авахад” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “/байцаагч/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол,

мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай шинэчилсэн найруулгын төслийн дагасан болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

-Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль хүчингүй болсон тооцох тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хоёр.ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “ХУУЛЬД” гэсний дараа “НЭМЭЛТ,” гэж, 2 дугаар зүйлийн ““хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж” гэсний дараа “, ““тахир дугуугийн тэтгэвэр” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр” гэж тус тус” нэмж, 1 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “заасныг хэрэгжүүлнэ” гэснийг “заасан мэдээллийг бүрдүүлнэ” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодгэрэл, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Анужин: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар Т.Доржханд, Ц.Идэрбат, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Монгол

Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг суурь болгож, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нараас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг нэгтгэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хөтөлбөр хэрэгжүүлэх” гэсний дараах “хувийн нэмэлт тэтгэврийн” гэснийг хасаж, “талуудын” гэсний өмнө “оролцогч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль тогтоомжоос” гэснийг “хууль тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “даатгалд хамрагдсан” гэснийг “даатгалын санд шимтгэл төлж, даатгуулсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын “31.1.3-т заасан урт хугацааны даатгал эрхэлж буй этгээдийг” гэснийг “4.1.2-т заасан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан урт хугацааны даатгал эрхэлж байгаа компанийг” гэж, 5.1.10 дахь заалтын “хөрөнгө эзэмших” гэснийг “хөрөнгө өмчлөх” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 5.1.16 дахь заалтын “бүрэн” гэснийг болон 5.1.17, 5.1.18 дахь заалтыг төслөөс тус тус хасаж, 5.1.21 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.21.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн гарчигийн “үйл ажиллагаа” гэснийг “түүнийг” гэж, 6.3 дахь хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагааг” гэснийг “хөтөлбөрийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “хүртэл хувь хүний” гэсний өмнө “нэмэлт тэтгэврийн хөрөнгийг зарцуулж дуусах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “тогтоолгохоор хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох” гэснийг “тогтоолгох” гэж өөрчилж, “хүртэл ажил олгогчийн” гэсний өмнө “нэмэлт тэтгэврийн хөрөнгийг зарцуулж дуусах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “мөнгөн дүн ба төлөх” гэсний дараах “давтамж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “шимтгэл төлөх” гэснийг дараах “давтамж,” гэснийг хасаж, 10.4 дэх хэсгийн “хамрагдсан ажилтны” гэсний дараа “сард” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь хэсгийн “сар бүр тооцож,” гэсний дараа “хагас жил тутамд” гэж, 11.7 дахь хэсгийн “Баталгаат өгөөжийн” гэсний дараа “жилийн” гэж нэмж, “Төв банкны” гэснийг “Төв банк /Монголбанк/-ны” гэж /цаашид тохиолдол бүрд/ өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 12 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “энэ хуулийн 13.1-д” гэсний өмнө “эрх залгамжлагч, өвлөгч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагаа” гэснийг “хөтөлбөрийг” гэж, 14.3 дахь хэсгийн “санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг” гэснийг “санд төвлөрүүлсэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээ, төлбөрийн чадварын эрсдэлийг” гэж тус тус өөрчилж, 14.7.5 дахь заалтын “зүйл” гэснийг болон 14.7.2 дахь заалтыг тус тус хасаж, 14.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 14.2.6 дахь заалт нэмэх:

“14.2.6.Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “сангийн удирдах зөвлөл” гэснийг “сангийн төлөөлөн удирдах зөвлөл, бусад эрх бүхий албан тушаалтан” гэж, 15.6 дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага, холбогдох этгээд” гэснийг “бусад эрх бүхий албан тушаалтан” гэж, 15.9.7 дахь заалтын “үйл ажиллагааг эрхлэх” гэснийг “бүртгэлийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн гарчгийн “олгох” гэсний дараах “, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх эрх бүхий этгээд” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн гарчгийн “зөвшөөрөл олгох үйл ажиллагаа” гэснийг “зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэж, 17.3 дахь хэсгийн “45 хоногийн” гэснийг “21 өдрийн” гэж, 17.4 дэх хэсгийн “баримт бичиг, мэдээллийг” гэснийг “мэдээлэл, баримт бичиг, тодруулга, тайлбар” гэж, “60 хоногийн” гэснийг “45 өдрийн” гэж тус тус өөрчилж, 17.5.4 дэх заалтыг “худал, төөрөгдүүлсэн, алдаатай, эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл тусгасан.” гэж өөрчлөн найруулж, 17.1 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, 17.1.7 дахь заалтыг хасаж, 17.3 дахь хэсгийн “ирүүлэхийг шаардах,” гэсний дараа “тодруулга, тайлбар авах” гэж нэмж, 17.6 дахь хэсгийн “хүсэлт гаргагчид” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан хугацаанд” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.8, 17.9, 17.10, 17.11, 17.12, 17.13, 17.14, 17.15 дахь хэсэг тус тус нэмэх:

“17.8.Хороо дараах тохиолдолд гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

17.8.1.эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн;

17.8.2.баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

17.8.3.хуульд заасан хугацаанд тайланг ирүүлээгүй, эсхүл худал, зөрүүтэй тайлагнасан;

17.8.4.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.

17.9.энэ хуулийн 17.8-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тогтоосноос хойш хувийн тэтгэврийн сан, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 5 өдрийн дотор албан бичгээр болон цахимаар мэдэгдэнэ.

17.10.Хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 17.9-д заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

17.11.Хороо энэ хуулийн 17.10-д заасан тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын 5 өдрийн дотор хувийн тэтгэврийн санд хүргүүлнэ.

17.12.Хороо энэ хуулийн 17.10-д заасан тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн сан, харьяалах татварын алба, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 2 өдрийн дотор бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

17.13.Энэ хуулийн 17.8-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сангийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

17.14.Хороо дараах тохиолдолд хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

17.14.1.хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 5.1.7-д заасан гишүүн болон Хороонд хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг дуусгавар болгохоос ажлын 90 өдрийн өмнө бичгээр, эсхүл цахимаар мэдэгдсэн;

17.14.2.нэмэлт тэтгэврийн бүх хөтөлбөр Хорооны бүртгэлээс хасагдсан;

17.14.3.энэ хууль болон бусад хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн;

17.14.4.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;

17.14.5.Зөвшөөрлийн тухай хуульд заасан бусад.

17.15.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг тогтоосон журмыг Хороо батална.” гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 3

Татгалзсан: 6

Бүгд: 9

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Ажлын хэсгийн гаргасан дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, 18.1.3 дахь заалтын “гэрээний санал” гэснийг “гэрээ” гэж, 18.2 дахь хэсгийн “30 хоногийн” гэснийг “20 өдрийн” гэж тус тус өөрчилж, 18.1.4 дэх заалтын “, бусад баримт бичгийн загвар” гэснийг болон 18.1.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн гарчиг болон 19.1 дэх хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагаа” гэснийг “хөтөлбөрийг” гэж өөрчилж, 19.2 дахь хэсгийн “, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах

20.1.Хороо дараах тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлнэ:

20.1.1.баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

20.1.2.Энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан маркетинг болон зар сурталчилгааны шаардлагыг зөрчсөн;

20.1.3.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тогтоосноос хойш хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 5 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

20.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 20.2-т заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

20.4.Хороо энэ хуулийн 20.3-т заасан тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын 5 өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хүргүүлнэ.

20.5.Хороо энэ хуулийн 20.3-т заасан тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг 1 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 2 өдрийн дотор бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

20.6.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны хүсэлтийг үндэслэн хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг сэргээнэ.

20.7.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хуульд заасан хугацаанд залруулаагүй тохиолдолд Хороо хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хасна.

20.8.Энэ хуулийн 17.12-т заасан шийдвэр гарсан бол хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх үндэслэл болно.

20.9.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “дуусгавар болгох” гэснийг “хүчингүй болгох, бүртгэлээс хасах” гэж, 21.3.1 дэх заалтын “тайлан тэнцлийг” гэснийг “санхүүгийн тайлан” гэж, 21.3.4 дэх заалтын “саналд” гэснийг “шийдвэрт” гэж тус тус өөрчилж, 21.3.2 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрт” гэсний дараа “нэмэлт тэтгэврийн

нэрийн” гэж, 21.3.5 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрийн” гэсний дараа “зарим” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 21.1, 21.2, 21.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан мэдэгдлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хүлээн авснаас хойш шимтгэл авах, гишүүн шинээр элсүүлэхийг хориглоно.

21.2.Хороо энэ хуулийн 21.1-д заасан мэдэгдлийг кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид мэдэгдэж, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн шилжүүлгийг нэн даруй зогсооно.

21.3.3.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн үнэлгээг хараат бус, хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.3.4 дэх заалт, 21.5, 21.6, 21.7 дахь хэсэг тус тус нэмэх:

“21.3.4.гишүүдийн хадгалагдсан эрхийн бүх төлбөрийг бүрэн барагдуулах хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч өөрийн хөрөнгөөр барагдуулах тухай хүсэлтийг санхүүгийн тайлангийн хамт Хороонд хүргүүлж, энэ тухай бүх гишүүдэд мэдэгдэх;

21.5.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан тохиолдолд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь энэ хуулийн 21.3-д заасан арга хэмжээ авна.

21.6.Урт хугацааны даатгагчийн эрхэлж буй нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг хассан тохиолдолд энэ хуулийн 22.1-22.11-д заасан арга хэмжээг авна.

21.7.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассаны дараа авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг Хороо батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн” гэснийг “тэтгэврийн сангийн” гэж, “дуусгавар болгосон” гэснийг “бүртгэлээс хассан” гэж, 22.3 дахь хэсгийн “өмчлөгч болно” гэснийг “өмчлөгч байна”

гэж, 22.4 дэх хэсгийн “зөвшөөрөл авсны дагуу” гэснийг “зөвшөөрөл авсны үндсэн дээр” гэж, 22.5 дахь хэсгийн “биечлэн мэдэгдэл хүргүүлнэ” гэснийг “цахимаар хүргүүлж биечлэн уулзалт зохион байгуулна.” гэж, 22.6 дахь хэсгийн “тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас” гэснийг “тэтгэврийн сангаас” гэж, 22.6.2, 22.7 дахь хэсгийн “тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн” гэснийг “тэтгэврийн сангийн” гэж, 22.12 дахь хэсгийн “дүрэм, төлбөр барагдуулах журмыг” гэснийг “дүрмийг” гэж тус тус өөрчилж, 22.5 дахь хэсгийн “30 хоногийн өмнө” гэсний дараа “мэдэгдлийг” гэж, 22.6.2 дахь заалтын “цалин хөлс,” гэсний дараа “төлөгдөөгүй” гэж, мөн зүйлд “Энэ хуулийн 22.6-д заасан өр төлбөр барагдуулах журмыг Хороо батална.” гэсэн 22.13 дахь хэсэг тус тус нэмж, 22.6.1, 22.10 дахь хэсгийн “бүх” гэснийг, 22.4, 22.10, 22.11, дэх хэсгийн “урт хугацааны даатгагч,” гэснийг, 22.10 дахь хэсгийн “хуваарилах төлөвлөгөө” гэсний өмнөх “гишүүдэд” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Энэ хуулийн 22.1-д заасан комиссын бүрэлдэхүүнд дараах этгээдийг томилохгүй.

22.1.1.хувийн тэтгэврийн сангийн удирдах зөвлөлийн гишүүн;

22.1.2.хувийн тэтгэврийн сангийн бусад эрх бүхий албан тушаалтан;

22.1.3.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлага;

22.1.4.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх бүхий албан тушаалтан;

22.1.5.Хорооноос тогтоосон болон бусад холбогдох этгээд.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “бүх” гэснийг хасаж, 23.3 дахь хэсгийн “удирдамжийг” гэснийг “журмыг” гэж, 23.4 дэх хэсгийн “үнэн зөв бус,” гэснийг “худал,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5

Татгалзсан: 4

Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “олон улсын зээлжих зэрэглэл тогтоож буй байгууллагаас гаргасан үнэлгээний ангилалд үндэслэн” гэснийг “Хороо” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 25 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 25 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “шаардлагыг хангах” гэсний дараа “хөрөнгө оруулалтын” гэж, 26.2 дахь хэсгийн “Бодлогод оруулсан нэмэлт, өөрчлөлтийг” гэсний дараа “Хороо болон” гэж тус тус нэмж, 26.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.1.2.Хорооноос тогтоосон нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн төрөл, дээд хязгаар, тухайн хөрөнгийн ангилал бүрийн нэг этгээд, эсхүл хэд хэдэн этгээдэд хөрөнгө оруулалт хийх дээд хязгаар;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл:	6
Татгалзсан:	3
Бүгд:	9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын “авагдаагүй” гэснийг “аваагүй,” гэж, 27.3 дахь хэсгийн “үнэт цаасанд” гэснийг “үнэт цаас, банкны хадгаламж, хадгаламжийн сертификатад” гэж тус тус өөрчилж, 27.3 дахь хэсгийн “Засгийн газраас гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулахад хязгаар тогтоохгүй.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл:	5
Татгалзсан:	4
Бүгд:	9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “хөрөнгөөр аливаа” гэснийг “хөрөнгөөр бүх” гэж өөрчилж, 28.1.1, 28.1.2, 28.1.3, 28.1.4, 28.1.7 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл:	5
Татгалзсан:	4
Бүгд:	9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлд “Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг кастодианы хөрөнгөөс тусгаарласан байна.” гэсэн 30.8 дахь хэсэг нэмж, 30.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.4.Кастодиан нь нэгээс дээш тооны хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид кастодиан үйлчилгээ үзүүлж болно. Энэ тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүрийн хөрөнгө, үйл ажиллагаа, бүртгэл мэдээллийг тус тусад бүртгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.1.2.хөрөнгө оруулалтын менежментийн компани, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, тэдгээрийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч холбогдох этгээд байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32.1.3 дахь заалтыг төслөөс хасах:

“32.1.Кастодианы гэрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 50.1-д зааснаас гадна доор дурдсан зүйлийг тусгана:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “ноцтой” гэснийг хасаж, 33.1.1 дэх заалтын “мэдэгдлийг” гэснийг “мэдэгдлийг ажлын хоёр өдрийн дотор хүргүүлж” гэж, 33.1.2 дахь заалтын “яаралтай” гэснийг “ажлын хоёр өдрийн дотор” гэж, 33.3 дахь хэсгийн “ноцтой доголдлын” гэснийг “доголдол үүссэн” гэж тус тус өөрчилж, 33.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 33.1.1, 33.1.2-т заасан хугацаанд арга хэмжээг яаралтай аваагүй тохиолдолд Хорооноос кастодианыг өөрчлөхийг даалгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд” гэснийг “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.8, 47.2-т” гэж өөрчилж, 34.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.9.Хороо нэмэлт тэтгэврийн хөрөнгийг удирдах харилцааг зохицуулсан журмыг батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлд “сүүлийн нэг жилээс доошгүй хугацаанд сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу удирдсан байх.” гэсэн 35.1.3 дахь заалт нэмж, 35.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.2.Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь кастодиан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээд, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд ажил олгогчид зээл олгох, тэдгээрээс зээл авахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар 36.1 дэх хэсгийн “дараах агуулгыг” гэснийг “доор дурдсан зүйлийг” гэж, 36.2 дахь хэсгийн “Хөрөнгө оруулалтын менежментийн” гэснийг “Энэ хуулийн 36.1-д заасан” гэж, “зөвхөн сонгогдсон” гэснийг “гэрээ байгуулсан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 4
Татгалзсан: 5
Бүгд: 9

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

П.Анужин: Төслийн 36 дугаар 36.1 дэх хэсгийн “дараах агуулгыг” гэснийг “доор дурдсан зүйлийг” гэж, 36.2 дахь хэсгийн “Хөрөнгө оруулалтын менежментийн” гэснийг “Энэ хуулийн 36.1-д заасан” гэж, “зөвхөн сонгогдсон” гэснийг “гэрээ байгуулсан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн гарчгийн “Нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэснийг хасаж, 37.1.1 дэх заалтын “дундаж үнэд” гэснийг “үнэ ханшид” гэж, 37.1.3 дахь заалтын “болон эдийн засгийн харилцаанд” гэснийг “, үйл ажиллагааны чиглэлд” гэж тус тус өөрчилж, 37.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.2.Хөрөнгө оруулалттай холбоотой зөрчил илэрсэн өдөр, хөрөнгө оруулалтын ангилал бүрт хөрөнгийн үнэлгээ хийж тухайн зөрчил илэрснийг тогтоосон өдрөөс хойш гурван сар хүртэл хугацааны дотор энэ хуульд нийцүүлэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн гарчгийн “зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага” гэснийг хасаж, 38.1 дэх хэсэг, 38.1.1, 38.1.2, 38.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.Хороо хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианд дараах тохиолдолд энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авна:

38.1.1.энэ хууль болон бусад хууль тогтоомж, зааварчилгаа зөрчсөн;

38.1.2.эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хоёр ба түүнээс дээш удаа зөрчсөн;

38.1.3.энэ хуулиар зөвшөөрөөгүй үйл ажиллагаа эрхэлсэн;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.5, 38.1.6 дахь заалт нэмэх:

“38.1.5.хуульд заасан хугацаанд тайланг ирүүлээгүй, эсхүл худал, зөрүүтэй тайлагнасан;

38.1.6.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ТАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрний “ХУВИЙН” гэсний өмнө “ГИШҮҮН” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийн “гишүүн шилжих,” гэсний дараа “хадгалан үргэлжлүүлэх, дуусгавар болгох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 40 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 40 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “зааж болох” гэснийг “заах” гэж өөрчилж, 41.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.7.Гишүүн насан туршийн тэтгэвэр авах бол урт хугацааны даатгагчтай гэрээ байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “нэмэлт тэтгэвэр олгох” гэснийг “хадгалагдсан эрх, хөрөнгийг шилжүүлэх” гэж, 42.3, 42.4 дэх хэсгийн “шилжүүлэх, эсхүл нэг удаагийн тэтгэвэр хэлбэрээр авах сонголт олгоно” гэснийг “шилжүүлнэ.” гэж, 42.5 дахь хэсгийн “тэтгэврийг эрх залгамжлагчид олгоно” гэснийг “хөрөнгийг залгамжлагчийн тэтгэврийн нэрийн дансанд шилжүүлнэ.” гэж, 42.6 дахь хэсгийн “тэтгэврийг даатгалын компанитай байгуулсан гэрээнд тодорхойлсноор олгоно” гэснийг “үлдэгдэл хөрөнгийг даатгалын компанитай байгуулсан гэрээнд тодорхойлсноор түүний

тэтгэврийн нэрийн дансанд шилжүүлнэ.” гэж, 42.7 дахь хэсгийн “төлбөрийг өвлөгчид олгоно” гэснийг “үлдэгдэл хөрөнгийг өвлөгчид шилжүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 43 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 43 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “бэлэн бусаар олгоно” гэснийг “бэлэн бусаар шилжүүлнэ” гэж, 44.5 дахь хэсгийн “гомдол шийдвэрлэх” гэснийг “гомдол шийдвэрлэх, үлдэгдэл хөрөнгийг шилжүүлэх” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “үүсгэн байгуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн “Үнэлгээг өдрөөр, эсхүл сараар тооцож гаргана.” гэснийг, 46.2 дахь хэсгийн “тухай бүр”, “гаргаж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн “хөрөнгө оруулалтад нөлөөлөх” гэснийг “хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах” гэж өөрчилж, мөн хэсгийн “гишүүнд” гэсний дараа “тухай бүр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “үйлчилгээтэй” гэснийг “үйл ажиллагаатай” гэж өөрчилж, 48.2.3 дахь заалтын “тус тусад нь, мөн ажил олгогчийн төлсөн шимтгэлд холбогдох хадгалагдсан эрхийн мэдээлэл” гэснийг, 48.2.5 дахь заалтын “өвлүүлэх” гэсний дараах “зэрэг” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсгийн “тэрхүү” гэснийг, 49.8 дахь хэсгийн “аливаа” гэснийг, 49.9 дэх заалтын “үүдэн” гэснийг тус тус хасаж, 49.9.2 дахь заалтын хууль зүйн арга хэмжээ” гэснийг “хууль зүйн туслалцаа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн “нэмэлт тэтгэврийн хөрөнгийг гаргуулах, эсхүл бусад арга хэмжээ авахуулахаар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 51 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 51 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 52 дугаар зүйлийн 52.2.3 дахь заалтын “хууль зүйн арга хэмжээ” гэснийг “хууль зүйн туслалцаа” гэж өөрчилж, 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч ажил олгогчийн төлөөгүй шимтгэлийг төлүүлэхээр шүүхэд гомдол гаргаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 53 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 53 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “Цаг хугацаандаа тайлагнаагүй тохиолдолд Хороо холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.” гэснийг, 54.3 дахь хэсгийн “хариуцлагын” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрөл: 6

Татгалзсан: 3

Бүгд: 9

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 55 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 55 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн “эрх бүхий байгууллагаар” гэснийг “Хороогоор” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрөл: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 57 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 57 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсгийн “нэг жилийн” гэснийг “нэг жил хүртэлх” гэж, 58.2 дахь хэсгийн “ажлын 100 хоногийн дотор” гэснийг “зургаан сар хүртэлх хугацаанд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрөл: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувиар санал дэмжигдлээ.

-Төслийн 59 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 59 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“60.1.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9.3 дахь хэсгийн “ба” гэснийг “бөгөөд” гэж, 10.4 дахь хэсгийн “тавин” гэснийг “50” гэж, “хорин” гэснийг “20” гэж, 11.1 дэх хэсгийн “3” гэснийг “гурван” гэж, 11.7 дахь заалтын “Төв банкны” гэснийг “Төв банк /Монголбанк/-ны” гэж, 27.1.2 дахь заалтын Төв банкны үнэт цаас гэснийг Төв банк /Монголбанк/-ны үнэт цаас гэж,

34.4 дэх хэсгийн “ба” гэснийг “бөгөөд” гэж, 45.2 дахь хэсгийн “хуулийн” гэснийг “хуульд заасны” гэж, 46.2 дахь хэсгийн “аудитлан” гэснийг “аудит хийж,” гэж, 47.5 дахь хэсгийн “гаргаж” гэснийг “гаргах,” гэж, 50.3 дахь хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж өөрчлөх.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7
Татгалзсан: 2
Бүгд: 9
77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй болон найруулгын саналаар санал хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн дагасан болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

-Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

П.Анужин: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 25 дугаар зүйлийн “25.7” дахь хэсгийн “хуульд заасны дагуу” гэснийг “хуулийн 41.2.1, 41.2.2-т заасан” гэж өөрчлөх.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “нийгмийн даатгалын” гэснийг “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 41.2.1, 41.2.2-т зааснаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрөл: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын Чингис хаан банкинд байршиж буй сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар болон Капитал банкны эрх хүлээн авагчийн мэдээлэл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Хяналт шинжилгээ, үнэлгээний албаны референт Ц.Элбэгзаяа нар байлцав.

Нийгмийн даатгалын сангийн Чингис хаан банкинд байршиж буй мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Чингис хаан банкны Нийгмийн даатгалын сангийн өр барагдуулах үйл явцын тайлан, мэдээлэл, мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тайланг сонсох асуудлуудыг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрөл: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдэж уг асуудлыг хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 цаг 11 минут үргэлжилж, 17 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 64.7 хувийн ирцтэйгээр 20 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 6 дугаар сарын 20-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Жанжисин Д.Сүхбаатар”
танхим
15 цаг 10 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг Та бүхэндээ танилцуулъя.

Балжиннямын Баярсайхан гишүүн ирсэн, Д.Батлут гишүүн ирсэн байна, Х.Булгантуяа гишүүн ирсэн байна, Б.Жаргалмаа гишүүн ирсэн, Ц.Мөнх-Оргил гишүүн ирсэн, Б.Саранчимэг гишүүн ирсэн, Ж.Чинбүрэн гишүүн хүрэлцэн ирсэн, Ц.Идэрбат нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэндээ танилцуулъя.

Нэгдүгээрт нь, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг хийгдэнэ.

Хоёр.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Мөн өдөр баригдсан. Анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Гурав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдүүрлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Тав.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн. Ням-Осорын Учрал нарын 5 гишүүнээс 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын чуулганд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Анхны хэлэлцүүлэг.

Зургаа.Чингис хаан банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар мэдээлэл сонсоно.

Долоо.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг сонсоно.

Найм.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүдээс 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Эдгээр асуудлуудыг бид өнөөдрийн Байнгын хорооны хурлаар авч хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал гаргах гишүүд байна уу? Нэрээ өгнө үү?

Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасалъя. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн санал хэлнэ.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Бид өнөөдөр Байнгын хороогоороо маш чухал асуудлууд хэлэлцэнэ.

Тэгээд үүнтэй холбоотойгоор дараалалд нэг өөрчлөлт оруулах санал хураалгаж өгөөч ээ гэж Байнгын хорооны даргаас хүсэх байна.

Энэ бол “Хянан шалгах түр хороог байгуулах тухай” тогтоолыг эхэнд нь оруулаад өгөхгүй юу?

Ер нь их тийм удах санал, ярилцах зүйл байхгүй байгаа учраас Та үүнийг санал хураалгаж өгөхгүй юу?

П.Анужин: Горимын санал гаргаж байна. Тийм ээ.

Ж.Чинбүрэн гишүүн өнөөдөр хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах тухай горимын санал гаргалаа.

Ж.Чинбүрэн гишүүн, хэлэлцэх асуудал өнөөдөр байхгүй. Цэгцлээд ороод ирсэн юм байна. Тийм үү?

Ер нь яагаад энэ дараалал орж ирсэн бэ гэхээр нийгмийн даатгалын багц хууль өөрөө хэлэлцэх асуудалтай, маш олон зарчмын зөрүүтэй, 100 давсан зарчмын зөрүүтэй саналтай учраас энэ асуудлыг эхэнд оруулж ирсэн гэдгийг гишүүд маань мэдэж байгаа.

Ж.Чинбүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд ээ. Эхэнд нь хэлэлцэх.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Тогтоол батлаад болох юм байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Чинбүрэн гишүүний гаргасан горимын санал нийт гишүүдийн 55.6 хувиар дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчилж, Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүдээс 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн энэ асуудлыг хэлэлцэнэ.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Юуны өмнө Засгийн газраас өргөн барьсан нийгмийн даатгалын багц хуулийг чуулганы хуралдаанаар хэлэлцэх эсэхийг нь дэмжээд анхны хэлэлцүүлэг хийж байна.

Тэгэхээр маш том хуулийг маш зоригтойгоор шийдэл гаргаж, дээрээс нь Монгол Улсын өнцөг булан бүрт хуулийн

хэлэлцүүлгийг хийж, ажлын хэсэг, ажлын дэд хэсгүүдийн хуралдааныг амжилттай удирдаж, хуулийг өнөөдөр ингээд оруулж ирж байгаа П.Анужин даргатай Нийгмийн бодлогын байнгын хороонд талархлаа илэрхийлье.

Та бүхэнд өчигдөр нийгмийн даатгалын багц хуулийг хэлэлцэж эхэллээ гэж тэр жагсаал дээр хэлэхэд олон ахмадууд баяртайгаар алга ташиж хүлээж авсныг дахин дахин цохон тэмдэглэе.

Дээрээс нь энэ хуулийг хуучин Т.Аюурсайхан сайд байж байхдаа оруулж ирсэн. Зарим нэгэн өөрчлөлтүүдийг шинэ сайд Х.Булгантуяа өөрчлөлтүүдийг хийж, ялангуяа Сангийн яамтай энэ зөрүү болон нийгмийн даатгал олгохтой холбоотой санхүүжилтийн асуудал, нийгмийн даатгалын сан руу төвлөрөх хөрөнгө орлогын асуудлаар тодорхой шийдлийг гаргаж байгаад баяр хүргэе.

Тэгээд бүгдээрээ хамтдаа энэ хуулиа хэлэлцээд энэ 07 сарын 07-ны дотор батлах нь хамгийн чухал зүйл гэдгийг хэлье.

Ингээд хэлэлцэх асуудлын хоёрдугаарт байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн төслүүд Засгийн газраас орж ирсэн байгаа.

Тэгэхээр 3 жилийн туршид би энэ хуулийг өөрчилж, 7 жилийг буцааж 5 жил болгох талаар Улсын Их Хурлын индэр дээрээс нийтдээ 60 гаруй удаа үг хэлсэн байна. 2 удаа жагсаал зохион байгуулсан байна.

Тэгээд үүний үр дүнд энэ хуулийг наашлуулж хэлэлцэж байгаад нь их баяртай байгаа.

Тийм учраас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр миний хуулийг Б.Пүрэвдорж нарын өргөн барьсан хууль гэж хамтад нь уншиж хэлж яваач ээ гэдэг ийм хүсэлтийг тавьж байгаа.

Энэ дээр тодорхой санал хураагаад хамтатгаад хэлэлцье. Угаасаа хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явчихсан байгаа.

Тэгээд анхны хэлэлцүүлгээсээ эхлээд хамтатгаад нэрийг нь дуудаад явах нь зүйтэй гэж үзэж байна.

Энэ хууль Байнгын хорооны дарга таны бас надтай хамт өргөн барьсан хууль шүү дээ.

Тэгээд Байнгын хорооны гишүүд Та бүхнийг дэмжиж санал хурааж өгөөч ээ гэж хүсэж байна.

П.Анужин: Бөхчулууны Пүрэвдорж гишүүнд баярлалаа.

Үнэн. Б.Пүрэвдорж гишүүн 7 жилийг 5 жил болгох асуудал дээр байнгын идэвхтэй ажиллаж, өөрөө хуулийн төслийг өргөн барьсан.

Бид Засгийн газраас өргөн барьсан хуулийг суурь болгож Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нарын өргөн барьсан хуулийг нийцүүлж ингэж ажлын хэсэг дээр энэ хуулиудыг нийцүүлж ажилласан байгаа.

Ингээд бид яг энэ хууль, тэтгэврийн хууль хэлэлцэгдэх үеэр энэ асуудал дээр санал хураагаад явчихна.

Гишүүд ээ, хэлэлцэх асуудалдаа орьё.

**Нэг.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг
хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүн
2023.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн/**

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тогтоолын төслийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн хийнэ.

Ж.Чинбүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2.1.2.1.8-д эм, эмнэлгийн эрсдэлийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн, бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас баталсан Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангахад оролцох байгууллагын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох асуудал чухал байна.

Эрүүл мэндийн яам болон Азийн хөгжлийн банкны санаачилгаар 2017 онд Монгол Улсын эмийн үнэ, хүртээмж, худалдан авах боломж, үнэ бүрдлийн судалгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон олон улсын эрүүл мэндийн үйл ажиллагааны байгууллагын

стандарт аргачлалын дагуу хийж гүйц гүйцэтгэсэн.

Судалгааны дүнд хамгийн хямд үнэтэй ерөнхий нэршлийн эмийн хүртээмж хангалтгүй байх ба улсын байгууллагын хангамж 53.6 хувь, хувийн байгууллагын хангамж 68.9 хувь, эмийн эргэлтийн сангийн хангамж 51.2 хувь байна.

Үүнээс үзэхэд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу зайлшгүй шаардлагатай эмийг 80.0 хувийн хүртээмжтэй байлгах зорилтод хүрэхгүй байна.

Иймд цаашид эмийн хүртээмжийн хангалтгүй байдлын шалтгаан, нөхцөлийг нарийвчин судлах шаардлагатай байна.

Түүнчлэн зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг батлах журам, жагсаал батлахтай холбоотой тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, үе шаттайгаар судлах шаардлага тулгарч байна.

Мөн хүний эмийн чанар, хуурамч болон стандарт бус эмийн үйлдвэрлэл, нийлүүлэлтийн асуудлаар Хянан шалгах түр хорооноос хүний эмийн чанар, стандартыг шалгах явцад эмийн үнийн асуудлыг нарийвчлан судлах, зах зээл дээр худалдагдаж байгаа болон Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлтөд үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн

бодит шалтгаан нөхцөлийг харилцан уялдаатайгаар хяналт шалгалт цаашид үргэлжлүүлэн хийх шаардлагатай гэх дүгнэлтийн дагуу цаашид эмийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасныг үндэслэн эмийн хяналтын тогтолцоо, шалгалтын үр нөлөөний асуудлаар шалгалт хийн дүнг нэгдсэн чуулганд танилцуулах, шаардлагатай бол санал боловсруулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороог байгуулах тогтоолын төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны гишүүд Та бүхэн эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Ж.Чинбүрэн гишүүнд баярлалаа.

Тогтоолын төсөлд уг түр хороонд олонхыг болон цөөнхийг төлөөлсөн гишүүдийн нэрсийг ирүүлсэн байгаа.

Гишүүдийг Та бүхэнд танилцуулъя.

Дамбын Батлут
-Улсын Их Хурлын гишүүн,

Бадарчийн Б.Жаргалмаа
-Улсын Их Хурлын гишүүн,

Мөнхөөгийн Оюунчимэг
-Улсын Их Хурлын гишүүн,

Цэндийн Сандаг-Очир
-Улсын Их Хурлын гишүүн,

Жигжидсүрэнгийн Чинбүрэн
-Улсын Их Хурлын гишүүн

Ингээд цөөнхийн бүлгийг төлөөлж Буланы Бейсен гишүүн Цэвэгдоржийн Туваан нарын гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Байнгын хороодын гишүүдийн 70.0 хувь дэмжиж тогтоолын төсөл батлагдлаа.

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэгийг томилъё.

Эмийн асуудал бол Ж.Чинбүрэн гишүүн ээ, маш их тулгамдсан асуудал.

Тэгээд энэ байдлуудыг харгалзан үзэж эмийн түр хороог сунгаж ажиллуулж байгаа.

Тэгээд Та бүхэндээ амжилт хүсэж, богино хугацаанд идэвх зүтгэлтэй

ажиллаж, ард түмнийхээ эрүүл мэндийн төлөө үр дүнтэй ажиллаарай гэдгийг хэлье.

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд оръё.

Хоёр.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

/Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нийгмийн даатгалын багц хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Тус багц хуулийн төслийг хэлэлцэхдээ Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг суурь болгож Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж нарын гишүүдээс 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, мөн Ням-Осорын Учрал нарын 5 гишүүнээс 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийг нэгтгэн хэлэлцэж байгаа болно.

Нийгмийн даатгалын хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Улсын Их Хурлын даргын

захирамжаар байгуулсан бөгөөд миний бие ажлын хэсгийг ахалж, гишүүдээр Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, С.Чинзориг, Б.Саранчимэг, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат нарын гишүүд ажиллаж байна.

Таван хуулийн төслийг нэг бүрчлэн хэлэлцэх боловч нэг ажлын хэсэг гарсан тул ажлын хэсгийн танилцуулгыг нэгдсэн байдлаар Та бүхэндээ танилцуулна.

Ажлын хэсгийн танилцуулгыг Та бүхэндээ хүргэе.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нийгмийн даатгалын багц хуулийн төсөл болон Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж нарын гишүүдээс 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Ням-Осорын Учрал нарын 5 гишүүнээс 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийг

нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 27 дугаар захирамжаар байгуулсан билээ.

Тус ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Ц.Мөнх-Оргил, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг нар ажилласан болно.

Ажлын хэсэг Булган, Орхон, Дархан, Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Говь-Алтай зэрэг 10 гаруй аймгуудаар, Улаанбаатар хотод нийгмийн бүх төлөөллийг хамруулсан 7 хэлэлцүүлгийг хийж, нийт 6 мянга гаруй иргэдэд хуулийн төслөө танилцуулж, санал авсан бол **D-Parliament** цахим хуудсаар 21 мянган иргэд хуулийн төсөлтэй танилцаж, 1300 иргэн саналаа ирүүлсэн байна.

Ажлын хэсэг олон нийт, нийгмийн төлөөллөөс ирсэн саналыг нэг бүрчлэн хэлэлцэж, төслийн үзэл баримтлал, зарчмыг алдагдалгүйгээр дараах агуулгын шинжтэй саналыг бэлтгэлээ. Үүнд:

1. Ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан зөвхөн тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалд хамрагдахаар, үндсэн ажлын хажуугаар зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр болон ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа

ажилтан зөвхөн тэтгэврийн даатгалд хамрагдахаар.

2. Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн ажил олгогч болон даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг эрх бүхий байгууллага нь нээлттэй сонгон шалгаруулах журмаар нэр дэвшигчийг сонгон Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд ирүүлэхээр.

Байнгын хороо нэр дэвшигчийн нээлттэй сонголыг хийж, тухайн албан тушаалд туршлага, ур чадварын хувьд тэнцэх эсэх санал, дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд танилцуулахаар.

3. Хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр тэтгэвэрт гарч буй даатгуулагчийн нөхцөлийг хэвээр үлдээхээр.

Хөдөлмөрийн хортой халуун нөхцөл болон газрын доор ажиллаж байгаа даатгуулагчийн тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлэхгүй байхаар.

4. Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэхийг жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэхээр.

5. 2018 оноос дараалсан 6 болон 7 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг 5 жилээр нэг удаа шинэчлэн тогтоох.

6. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал нарын 5 гишүүнээс өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй нэгтгэн Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлээ.

Ажлын хэсгээс нийт Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд 26 зарчмын санал, дагасан хуульд нийт 9 зарчмын санал, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд нийт 15 зарчмын зөрүүтэй санал, дагасан 2 санал, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлд нийт зарчмын зөрүүтэй 11 санал, дагасан 1 санал, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төсөлд нийт 21 зарчмын зөрүүтэй санал, дагасан хуулийн 2 төсөлд санал бий.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл, Зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлж зарчмын зөрүүтэй 45 санал гарсан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд урьдчилан тараасан байгаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгье.

Ням-Осорын Учрал гишүүнээр тасалъя. Дамбын Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Одоо нийгмийн хүсэн хүлээж байсан маш чухал хуулийн төслүүд дээр ажиллаж байна.

Энэ хуулийн төсөлтэй холбоотой асуудлууд нэлээн гарсан. Тойрогт ажиллаж байхад манай тойргийн иргэдээс гаргаж байсан асуудлууд байгаа. Тухайлах юм бол уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн ажилтан, албан хаагчид, үйлдвэрчний эвлэлийн байгууллагынхаа шугамаар дамжуулж надад хүсэлт гаргасан.

Тэр бол хөдөлмөрийн хүнд болон хүнд, хортой нөхцөлд ажиллаж байгаа хүмүүстэй холбоотой. Тэтгэврийн насыг нэмэгдүүлж байгаатай холбоотой асуудлыг эргэж харах. Хуучин хууль эрх зүйн зохицуулалтаар нь үлдээх асуудлыг санал болгож байсан.

Харин ажлын хэсэг маань энэ дээр ажиллаад яг энэ шийдэл дээр саналаа гаргаж ирж байгаад их баяртай байна.

Энэ бол бас ажилтан, албан хаагчдын маань санал, хүсэлтийг хүлээж авч, сонсож хуулийн төсөлд хэвээр үлдээсэн нь талархууштай байна.

Нийтийн уурхайчдынхаа өмнөөс ажлын хэсгийнхэнд талархал илэрхийлье.

Асуулт байна. Нийгмийн даатгалын тухай хууль дээр хувийн тэтгэврийн сантай холбоотой шинэ зохицуулалтууд орж ирж байгаа юм. Тэгэхээр үүнтэй холбоотой хоёр асуулт байна.

Энэ 8.1.1, 8.2, 8.3 дээр ажил олгогч, ажилтан, гишүүн гээд. Нэг ёсондоо хувийн тэтгэврийн хөтөлбөрт хамрагдах ажил олгогч, ажилтан, тэр гишүүнтэй холбоотой асуудал дээр тодруулах зүйл байна.

Мэдээж ажилтан, албан хаагч нар нь насан туршдаа нэг байгууллагад

ажилладаггүй. Тэр тохиолдол нэлээн ховор байдаг. Магадгүй ингээд нэг ажил хийж байгаад өөр байгууллагад шилжиж ажиллах тохиолдлууд амьдрал дээр, практик дээр нэлээн их байдаг л даа.

Тэгэхээр өөр байгууллагад ажиллахаар шилжсэн тохиолдолд тэр хувийн тэтгэврийн хөтөлбөрт тэтгэврийг нь шилжүүлэх боломжтой юу? Хөтөлбөрт нь шилжүүлэх боломжтой юу?

Энэ шилжүүлэх боломжийг хууль, эрх зүйн хувьд нь зохицуулалт өгөх зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа. Тэгэхгүй бол ингээд ямар нэгэн байдлаар хийдэл үүсэх үү гэдэг.

Иргэд өөрсдөө хүсэж байдаг. Магадгүй тухайн хувийн даатгалын хөтөлбөр нь өөр албан байгууллагууд дээр хэрэгждэггүй ч юм уу, эсвэл өөр ажилд шилжсэнээрээ, өөр албан байгууллагад шилжсэнээрээ тэр хөтөлбөр нь үргэлжилж явах боломжгүй болчихдог ч юм уу, ийм нөхцөл байдлууд үүсэх вий гэдэг болгоомжлол байна.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор асуудлыг хэрхэн зохицуулах боломж, бололцоо байгаа юм бэ гэдэг дээр хариулт авъя.

Хоёрдугаарт нь, энэ хувийн тэтгэврийн хөтөлбөр дээр ажилтны төлөх шимтгэлийн доод хэмжээ нь сарын нийт шимтгэлийн хэмжээний 50 хувиас, шимтгэлийн сарын нийт дүн нь тухайн ажилтны сарын үндсэн цалингийн 20 хувиас тус тус хэтрэхгүй байна гээд тоо хэмжээгээ заагаад өгчихсөн байна л даа.

Тэгэхээр сайн дурын үндсэн дээр энэ даатгалын хэлбэрээр хандаж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр ингэж тоон байдлаар хувь хэмжээг нь зааж өгөх нь өөрөө энэ сайн дурын гэдэг нөхцөлдөө нийцэж байгаа юм уу? Үүнийг ямар тооцоо, судалгаан дээрээс гаргаж ирж ийм хязгаарыг тавьж өгсөн юм бол гэдэг дээр нэг хариулт авъя. Баярлалаа.

П.Анужин: Дамбын Батлут гишүүнд баярлалаа. Тийм ээ.

Ажлын хэсэг дээр ажлын дэд хэсэг ажиллаж байхад бид олон удаагийн аймаг, орон нутгийн хэлэлцүүлгүүд хийсэн.

Энэ хөдөлмөрийн хүнд нөхцөлийн талаар маш олон иргэдийн санал ирсэн. Бид үүнийг авч үлдэж, төрөл бүрээс нь, тал бүрээс нь хэлэлцсэн.

Ер нь хүнд нөхцөл гэгчхээд тэгээд тэр хүнд нөхцөл дунд сарыг нь нэмнэ гэдэг бол байж боломгүй ойлголт юм гэдэг. Үүнийг уртасгана гэдэг өөрөө логикийн зөрчилтэй гэдэг энэ саналыг гаргаж, ажлын дэд хэсэг дээр хуучин хуулийг хэвээр нь үлдээх санал өнөөдөр Та бүхнээрээ хэлэлцүүлээд бид санал хураалт явуулна.

Ер нь бид өнөөдрийн горимоороо 5 багц хууль маань тус тусдаа хэлэлцэгдээд явна.

Хувийн тэтгэврийн сан тусдаа хэлэлцэгдээд явна. Зүйл, заалт бүр дээрээ.

Тэгэхээр таны энэ асуултыг тэр үед нэгтгэж болох уу? Болж байна. Баярлалаа.

Содномын Чинзориг гишүүн асуулт асууна. Содномын Чинзориг гишүүн асуулт асуухын өмнө би өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн

ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг Та бүхэндээ танилцуулъя.

А.Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч, Б.Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын нийгмийн даатгалын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Д.Ренчиндорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Ц.Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Даваахүү Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга, Б.Гэрэлсайхан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Ө.Бодгэрэл тус яамны Нийгмийн даатгалын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, С.Орхон Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, Г.Ганчимэг судлаач, зөвлөх, Ц.Дашдондог судлаач, зөвлөх гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Асуулт асуух гишүүдийн нэрсийн дараалалд Батсүхийн Саранчимэг гишүүний нэрийг оруулаад өгөөрэй.

Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Хоёр, гурван зүйл тодруулмаар байгаа юм.

Одоо манай Нийгмийн даатгалын сангийн тухай хуулиар хуваарилалтын тогтолцоотой яваад байгаа юм.

Одоо бид Нийгмийн даатгалын хууль шинэчилсэн найруулгаар өөрчлөлт хийгээд хуулиа хэлэлцэж байна л даа.

Тэгээд одоо тэгээд энэ хууль батлагдсанаараа бид хуваарилалтын тогтолцоо цаашдаа хэвээр үргэлжилнэ гэж ойлгож байна уу? Хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж байна гэж ойлгож байгаа юм уу? Тийм хуримтлалын тогтолцоо руу шилжих алхам хэр хийгдэж байгаа юм?

Цаашдаа бид ямар хугацаанд ер нь бүрэн хуримтлалын тогтолцоонд орно гэж Та бүхэн тооцож хуулийн төсөл санаачилж оруулж ирсэн юм бэ гэсэн нэг асуулт байгаа юм.

Хоёр дахь асуудал. Манай одоогийн мөрдөж байгаа Нийгмийн даатгалын хуулийг муу хэлээд л байдаг л даа. Үр дүнгүй. Тэтгэврийн сан өөрөө тэтгэвэртээ гарсан гээд л, үгүйсгээд л.

Тэтгэврийн шимтгэл төлөлтийн ач холбогдлыг алдагдуулаад л нэг хэсэг баахан шуугисан. Энэ бол тийм биш л дээ.

Одоогийн мөрдөгдөж байгаа нийгмийн даатгал бол маш энэрэнгүй хууль шүү дээ. Би хэлээд л байдаг.

Ерөөсөө ажилтан өөрийнхөө цалингаасаа 10 хувийн шимтгэл төлөөд л тэгээд тэтгэвэр авахаараа тэр шимтгэлээ 10 хувийнхаа цалингаас төлсөн шимтгэлийн доод тал нь 45, дээд тал нь 80 хувиар, 70 хувиар, 60 хувиар цалин болгоод л авч байгаа шүү дээ. Ийм өгөөмөр хууль л даа.

Тэгээд одоо энэ чинь улам л өгөөмөр болж байгаа юм байна. Зардал нэлээн нэмэгдэх юм байна.

Тэгэхээр бид энэ хуульд ингээд өөрчлөлт орохоор төсөв дээр ирэх ачаалал хэр нэмэгдэж байгаа юм? Нийгмийн даатгалын сангийн өөрийнх нь

зардал хэр хэмжээгээр нэмэгдэж байгаа юм?

Тэтгэврийн талаар төрөөс баримтлах бодлогын бичиг баримтыг Их Хурал баталсан байдаг. Энэ баримт бичиг чинь Нийгмийн даатгалын сангийн зарлагыг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь байх аа? 2 хувиас ихгүй байлгана гэсэн ийм бодлогын бичиг баримт бий шүү дээ.

Энэ бодлогын баримт бичигтэйгээ нийцэж байгаа юу, нийцэхгүй байгаа юу? Энэ төсвийн зарлага чинь одоо тэгээд ямар хэмжээнд хүрэх юм? Дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувьд хүрэх юм? Энэ хууль батлагдсанаараа гэсэн ийм хоёр зүйл тодруулья.

Гурав дахь асуудал нь, яах вэ “тэтгэвэр өвлөгдөх тухай” асуудал гэж бид яриад байгаа юм.

Уг зарчим нь манайх чинь хуваарилалтын тогтолцоотой явж байгаа нөхцөлд “эв санааны зарчимд тулгуурласан хуваарилалтын тогтолцоо”-той учраас уг нь “тэтгэвэр өвлөгдөх тухай” асуудал зарчим нь нэг их тийм зөв санаа биш л дээ.

Одоо яах вэ, тэгээд иргэдийн шаардлага, шахалтаар гээд ийм санаа орж ирж байгаа юм байна.

Нэг тэтгэвэр авагч чинь хамтдаа, гэр бүлийн хоёрын нэг нь нас барвал нэгэнд нь тэтгэврийнх нь 20 хувийг олгох юм байна. Энд одоо тэгээд жилд ямар хэмжээний зардал гарах юм?

Хоёрдугаарт, тэр шалгуур чинь арай бага юм биш үү. 10 жил хамт амьдарсан бол гэж байгаа юм байна. 10 жилийн гэр бүлийн хугацаа гэдэг чинь бага хугацаа л даа. Ядаж одоо үүнийг 20

жил хамт амьдарсан гэр бүлийн хоёрын нэг нь нас барвал тэр 20 хувь нь олгодог ийм тооцоо хийж үзсэн үү?

Яагаад заавал 10 жил гэсэн юм? Энэ 10 жил гэдэг чинь гэр бүлийн хамтын амьдралд их богино хугацаа шүү дээ.

Тэгээд үүнийг Та бүхэнд тайлбарлаач. Би 20 жил байх тухай асуудлыг бас авч үзэх нь зүйтэй л гэсэн ийм саналтай байгаа. Ядаж яах вэ тэр “өвлөгдөнө” гэдэг нь байдаг юм байгаа биз. Өвлөгдөнө гэх юм уу, юу гэх юм.

Тэгээд ядаж 10 биш 20 жил хамт амьдарсан гэр бүлийн хоёрт гэсэн ийм агуулгаар оруулбал яасан юм бэ гэсэн ийм гурван асуулт байна.

П.Анужин: Содномын Чинзориг сайдын тавьж байгаа гурван асуултууд маш чухал асуудлууд.

Бид өнөөдөр өмнөх тогтолцоо нь болохгүй байсан юм шиг ойлголт нийгэмд их байгаа. Тэгэхээр үүнийгээ халах гэж байгаа юм шиг.

Тэгэхээр зарчмын энэ суурь ойлголтуудтай уялдуулаад саяын асуусан тооцоо, тооцооллуудыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хишигбаяр дарга хариулья.

4 номерын микрофоныг нээгээд өгөөрэй.

А.Хишигбаяр: С.Чинзориг гишүүний асуултад хариулья.

Эхний асуулт нь хуваарилалтын тогтолцоонд “хагас хуримтлал”, “бүрэн хуримтлал” руу хэзээ шилжих вэ гэсэн асуулт байсан.

Монгол Улсын “Алсын хараа” урт хугацааны бодлогод үе шаттай хуваарилалтад тогтолцоо руу шилжинэ.

2040 оноос “**бүрэн хуримтлалын тогтолцоо**” руу шилжинэ гэсэн зорилтыг тавьсан байгаа.

Энэ урт хугацааны бодлогодоо үндэслэж бид хууль хэрэгжүүлэхээс эхлээд “**хагас хуримтлалын тогтолцоо**” руугаа шилжээд явна. Тодорхой шимтгэл төлөгчийн маань тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг яг бэлэн мөнгө болгож “**хагас хуримтлал**” руу шилжүүлнэ.

Цаашдаа 2040 оноос хойш “**бүрэн хуримтлал**” руу шилжүүлнэ гэдэг энэ агуулгаар бол хуулийн төслөө боловсруулсан байгаа.

Тэгэхээр хуулийн төсөл маань хууль хэрэгжсэнээсээ хойш “**хагас хуримтлалын тогтолцоо**” руу бол үе шаттай шилжих эхний алхмууд хийгдэж эхэлнэ гэж хуулийн төсөлд тусгасан байгаа.

Нийгмийн даатгалын багц хууль батлагдсанаар хичнээн төгрөгийн зардал гарах вэ. Энэ дээр тооцоо, судалгаа хийсэн үү гэсэн ийм хоёр дахь асуудал байгаа.

Манай яамны зүгээс, ажлын хэсгийн зүгээс бид тооцоо, судалгаа хийсэн.

Багц хуультай холбоотой нийтдээ 1.2 их наядын зардал нэмэлтээр гарна гэж тооцож байсан. Гэтэл сая Төсвийн тухай хуулиар тэтгэврийн зөрүү ойртуулах зардлыг маань шийдвэрлээд өгчихсөн.

Мөн тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлнэ гэсэн энэ зардлуудыг шийдвэрлээд өгсөнтэй холбоотой нийтдээ 394.5 тэрбумыг шийдвэрлээд өгсөн байгаа.

Тэгэхээр нийгмийн даатгалын багц хууль 2024 оны 01 сарын 01-нээс хэрэгжээд эхэлнэ гэж үзэх юм бол 470.0 тэрбум төгрөгийн зардал нэмэгдэнэ гэж харж байгаа.

Энэ 470.0 тэрбум төгрөгийн маань 369.3 тэрбум маань одоо яг “**хагас хуримтлалтын тогтолцоо**”-нд шилжүүлэх буюу өнөөдрийн шимтгэлийн 2 хувийг бэлэн мөнгө болгож хадгалаад явах энэ зүйлд зарцуулна.

Бусад нь тухайн үеийн гарч байгаа төрөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэл. Мөн агентлагийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг төрөөс хариуцна гэсэн энэ зардлууд ороод явж байгаа.

Энэ орон зайг цаашдаа нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах энэ үйл ажиллагаагаар бид цааш нь тодорхой хэмжээг нь барагдуулаад, орлого, зарлагын балансыг нь тэнцүүлээд явахад боломжтой гэж харж байгаа.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого дээр Нийгмийн даатгалын сангийн татаасыг 2 хувиас хэтрүүлэхгүй гэсэн. Орлого, зарлагын зөрүү буюу Тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг 2 хувиас хэтрүүлэхгүй гэсэн бодлогын бичиг баримтад туссан байгаа.

Өнөөдөр ялангуяа 2023 онд нийгмийн даатгалын сан улсын төсвөөс татаас авахгүй байгаа.

545.0 тэрбумын төгрөгийг өнөөдөр улсын төсвөөс санд олгож байгаа. Гэхдээ энэ бол цэргийн тэтгэвэр авагч, мөн нийгмийн даатгалын харилцаа үүсэхээс өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийн зардал байгаа.

Энэ 545.0 тэрбумыг өнөөдрийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй хэрвээ харьцуулж үзэх юм бол 1.2 хувьд барьж байгаа.

Дараагийн зардал нь 20 хувь буюу гэр бүлийн нэг нь нас барвал нөгөө хүний тэтгэврийг нь 20 хувиар нэмэгдүүлнэ гэсэн зардал байгаа.

Энэ дээр бид тооцоо, судалгаа хийгээд 10 жил хамт амьдарсан. Магадгүй бурхан болоход нөгөө гэр бүлийн хүн маань тэтгэвэр тогтоолгоогүй байх юм бол 5 жилийн хугацаанд эрх нь хадгалагдах байдлаар хуульчилж хуулийн төсөлдөө тусгасан байгаа. Энд нийтдээ 7.7 тэрбум төгрөг зарцуулна гэсэн ийм урьдчилсан судалгаа хийсэн байгаа.

П.Анужин: Гүйцээгээд хариулъя. А.Хишигбаяр дарга.

А.Хишигбаяр: Ийм байгаа. Яг тэтгэвэр авч байгаа хоёр гэр бүлийн хүний нэг нь бурхан болох юм бол бурхан болсон хүний тэтгэврийнх нь 20 хувийг нөгөө үлдэж байгаа гэр бүлийн хүнд нь нэмэгдүүлж олгож байгаа юм.

Гэтэл магадгүй хоёр гэр бүлийн нэг нь тэтгэвэр авагч биш байж болно. Тийм ээ. Арай нас нь хүрээгүй, тэтгэвэр тогтоолгоогүй байх юм бол энэ эрх нь 5 жил дотор хадгалагдаад, магадгүй 2 жилийн дараа гэр бүлийн хүн нь тэтгэвэр тогтоолгох юм бол 2 жилийн дараа тэтгэврийг нь нэмэгдүүлээд явна гэсэн

ийм 5 жилийн дотор хадгалагдаад явах нөхцөлийг нь оруулаад өгч байгаа юм.

П.Анужин: Тэр 10 жилийг яагаад 10 жил гэсэн юм бэ?

Хамтдаа амьдарсан, тэтгэврийн нас хүрчихсэн хүмүүс чинь нийт амьдралын юунд нь энэ 10 жил чинь их богино хугацаа. Энэ үндэслэлээ тайлбарлаарай гэсэн.

А.Хишигбаяр дарга хариулъя. 4 номерын микрофоныг нээгээрэй.

А.Хишигбаяр: Энэ дээр бид бас 10 жил гэдэг энэ доод хугацааг нь зааж өгч байгаа.

Яагаад гэх юм бол бид шууд гэр бүлийн хоёр гээд явах юм бол энэ дээр шууд бие биедээ би нэг тэтгэврээ нөгөөдхийг нь нэмэгдүүлнэ гэх юм бол, одоо бага хугацаа тавьж өгөх юм бол тэтгэврийн даатгалын сан дээр алдагдал гарах юм байна.

Нөгөө талаараа бид гэр бүл тогтвортой байх гэдэг бодлогоор тогтвортой цаашдаа амьдрах, гэр бүл тогтвортой байх гэдгээр бид 10 жилээр хязгаарлаад, 10 жилээс дээш байх юм бол тэтгэврээ нэмэгдүүлдэг байх зохицуулалтыг нь оруулж өгье. Хэтэрхий бага байх юм бол энэ нь нийгмийн даатгалын сандаа ачаалал үүсэх юм байна гэж тооцоо, судалгаа хийсэн байгаа.

П.Анужин: Тодруулах уу? Та. С.Чинзориг сайд тодруулна.

С.Чинзориг: Тэр 2 хувийн хуримтлал үүсгэх асуудал яриад байна. Тийм ээ.

Тэгвэл би “сангийн хуримтлалыг үүсгэх ёстой асуудал” гэж үзээд байгаа

юм. Гэхдээ та нар нөгөө **“нэрийн дансыг мөнгөжүүлэх асуудал”** гэж яриад байна шүү дээ.

Би “сангийн хуримтлал үүсгэх асуудал” бол өөр асуудал. “Нэрийн дансны мөнгийг мөнгөжүүлэх асуудал” өөр тусдаа асуудал.

Нэрийн дансыг мөнгөжүүлэх асуудал тэр сангийн хөрөнгөөр нь өөрийг нь өөрөөр нь мөнгөжүүлэх асуудал биш ээ.

Наад 2 хувь чинь сангаа арвижуулах, тэр хуримтлалын тогтолцоо руу шилжих суурийг нь тавих асуудал болохоос биш тэр мөнгөжүүлэх асуудлыг үүгээр хааж болохгүй шүү дээ. Хоёр өөр юмыг та нар ингээд холиод, Сангийн яаманд хөөрхөн хууртагдаад яваад байгаа юм биш биз дээ?

Би тэр 2 хувийг нь арвижуулахыг бол дэмжиж байна. Тэр бол “бүрэн хуримтлалын тогтолцоо”-нд шилжих суурь болох ёстой.

Нэрийн дансыг мөнгөжүүлэх асуудал бол өөр асуудал шүү дээ. Тэрийг засаг цэвэр.../минут дуусав/

П.Анужин: С.Чинзориг сайд санал хэллээ.

Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: 2020 оны 10 сарын 02-нд миний болон тухайн үед Б.Саранчимэг гишүүн, Б.Баттөмөр гишүүн, Л.Мөнхбаатар гишүүн. Тухайн үед З.Нарантуяа гишүүн байсан.

Ингээд бид 5-ын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх

ажлын хэсэг ажиллаад энэ хуулиудыг боловсруулсан.

Ингээд сонгуулийн дараа өргөн бариад, тэр 2020 оны 10 сарын 02-нд Их Хурлаар хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, тухайн үед Засгийн газраас оруулж ирээд нэгтгээд явъя гэснээс хойш одоо ер нь хөдөлмөр халамжийн салбарт юу ч болов гэдэг шиг явсаар байгаад яг өнөөдрийг хүрээд, Х.Булгантуяа сайд оруулж одоо энэ хуулийн анхны хэлэлцүүлгийг хийгээд, тухайн үед 2020 онд Их Хурлын сонгуульд хамтарч нэг тойргоос дэвшсэн П.Анужин гишүүн ахлаад, босго даваад орж ирж байна. Би түүнд их баярлаж байгаа.

Дээрээс нь би С.Чинзориг гишүүнийг **“хуримтлал руу шилжих ёстой”** гэдэг үгийг ингэж их хэлдэг болсонд нь би маш их баярлаж байгаа.

Яагаад гэхээр **“тэтгэвэр өвлөгдөх ёстой”**. Нийгмийн даатгалын шимтгэл нь өөрөө тэр **“өгөөжийг нь иргэд хүртдэг байх ёстой”**. **“Олон давхаргад тэтгэврийн тогтолцоотой болох ёстой”** гэдгийг л иргэд хүсэж байгаа юм.

Тэгэхээр нэг алхам хийе. Тэр нийгмийн даатгалын шимтгэлд төлж байгаа тэр 17-гийн ядаж 2 хувийг нь **“өгөөжийг нь тооцдог болъё”** л гэж иргэд хүсэж байна шүү дээ.

Тэгэхээр **“нэрийн данс”** гэдэг бол өөрөө **“эзэнтэйгээ хамт бурхан болдог нэрийн данс”** байхгүй юу.

Тэгэхээр тэр гар утасны аппликэйшн рүү ороод нэрийн дансаа шалгаад яах вэ дээ. Тэртээ тэргүй **“өсдөггүй сан”**-г юуг нь шалгах юм. Иргэд.

Тэгэхээр тэр 2 хувь чинь өөрөө тэр үнэхээр 300 хэдэн тэрбум төгрөг байгаа бол түүнийх нь өгөөжийг нь иргэд хүртдэг байвал шимтгэл төлөхдөө иргэд одоо тийм итгэлтэйгээр төлнө шүү дээ.

Тэгэхгүй нийгмийн даатгал чинь өөрөө 30 жилийн дараа би тэтгэвэрт гарахад надад ямар үр шим өгөх бол гээд хүлээж байдаг. Гэтэл тухайн үеийнхээ нэг тэгшитгээд л нэг тэтгэвэр олгочихоор чинь.

Дээрээс нь өнөөдрийн гол асуудал юу вэ гэхээр бид тэтгэврийг даатгалтай андуурч явсаар байгаад өнөөдөр хүрчихсэн байхгүй юу.

“Даатгал чинь тооцож болдоггүй”. Ямар нэгэн гэнэтийн эрсдэл болох юм бол суурилсан ийм санхүүгийн бүтээгдэхүүн.

Харин **“тэтгэвэр бол тооцож болдог”** асуудал байхгүй юу. Хэдэн жилийн дараа тэтгэвэрт гарна гэдэг нь тооцогдож байгаа.

Тэгэхээр тэр 2 хувийг илүү хөрөнгийн менежмент хийж буюу мэргэжлийн хөрөнгө оруулагч нараараа удирдуулаад, түүнийх нь өгөөжийг нь тэр нэрийн дансаараа дамжуулаад иргэд хүртдэг байгаач ээ гэж хүсэж байгаа юм.

Тийм ч учраас өнөөдөр энэ хууль дээр шилэн ажиллагаа явснаас хойш харагдсан.

Одоо тэр бараг хэдэн тэрбум билээ. 35, 36 тэрбум төгрөг авч чадаагүй байж байгаа гээд мэдээллүүд байна шүү дээ. Тэр банкаас.

Гэтэл банкууд нь өнөөдөр тэр мөнгийг аваачиж банканд хийж, байршуулж иргэдийн мөнгийг хүүлээд,

дампуурчхаад, хэн хариуцсан нь тодорхойгүй болчхоод байхад дахиад банкандаа энэ 2 хувийг хийж, түүний өгөөжийг нь иргэддээ хүртээнэ гэж ярьж болохгүй шүү дээ.

Тэгэхээр **“санхүүгийн хэрэгсэл рүү”, “хөрөнгийн зах зээл рүү”** тэр 2 хувийг хийж, түүн дээр нь хөрөнгийн менежмент хийж, түүний **“үр шимийг иргэд хүртдэг тогтолцоо”** руу шилжье.

Өнөөдөр тэр Рио Тинто гэдэг компани чинь Австралийн тэтгэврийн сангийн хувьцаа эзэмшигч. Гэтэл Австралийн ахмадууд Монголын газрын баялгаас хишиг хүртээд байна шүү дээ. Яг энэ агуулгаар бол.

Тэгэхээр 2 хувийн тэр 300.0 тэрбумыг чинь удирдах **мэргэжлийн хөрөнгө оруулагч** нараараа дамжуулаад **хөрөнгийн зах зээлд** хийснээрээ өгөөжийг нь иргэд хүртдэг тогтолцоо руу шилжье гээд байхад Засгийн газрын бонд, үнэт цаас, нөгөө банкууд, дээрээс нь хөрөнгийн зах зээлд санхүүгийн хэрэгсэлд оруулж болох энэ зохицуулалтыг нэмэхгүйгээр зөвхөн энэ гурвыг үлдээхээд дахиад л банк руугаа хийнэ гээд сууж байх юм бол наад 2 хувь чинь дахиад дампуурна шүү.

Тэгэхээр **“санхүүгийн хэрэгсэлд оруулж болно”** гэдэг заалтыг яагаад нэмээгүй юм.

П.Анужин: Н.Учрал сайдын асуултад Б.Батжаргал дарга хариулья.

Ер нь бид хууль дээрээ 29.5.1-тэй бид энэ хуулийн 13.1-д заасан **“санхүүгийн хэрэгсэлд”** гээд заачихсан байгаа. Тийм ээ.

5 номерын микрофоныг өгье. Б.Батжаргал дарга хариулья.

Б.Батжаргал: Н.Учрал гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Б.Батжаргал.

2 хувийн асуудал яг одоо **РАУГ** [‘ray-as-you-go’] схем дээр байгаа 17 хувийг 15-ыг нь яг улсын схем дээрээ үлдээгээд, хуваарилалтын тогтолцоо дээрээ үлдээгээд, 2 хувийг нь хуримтлалын сан руу авах ийм үндсэн төлөвлөгөөтэй байгаа.

Тэгээд Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төслийг манайх Сингапурын хамтын ажиллагааны байгууллагатай хамтраад ажиллаад боловсруулаад явж байгаа.

Тэр төсөл дээр Хувийн нэмэлт тэтгэврийн сангийн тухай хууль нь хөрөнгө оруулалтын хэрэгсэлтэй адилхан “Засгийн газрын бонд”, “бүх төрлийн үнэт цаас”. Тэгэхдээ зохицуулалттай зах зээл дээр арилжаалагдаж байгаа “үнэт цаас”.

Тэгээд “гадаадын хөрөнгө оруулалтын боломжит хувилбаруудыг бүгдийг нь тусгана” гэсэн үндсэн үзэл баримтлалаар төсөл нь бичигдээд явж байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй. Баярлалаа.

П.Анужин: Х.Булгантуяа сайд нэмэлт хариулт өгье.

Х.Булгантуяа: Сая Б.Батжаргал даргын хариулж байгаа нөгөө 2 хувийн асуудлыг яриад байна л даа.

Энэ бол жилд 370.0 тэрбум төгрөг. Ингээд 2 жил дамнангуут шууд 740.0 тэрбум төгрөг гээд хуримтлал үүснэ.

Үүнийг бид хуримтлалын сангийн тухай бүр ийм тогтолцоог бий болгох гэж байгаа. Энэ бол Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөрт гээд бүгдэд нь туссан.

Тэгэхээр энэ хуулийг Баялгийн сангийн тухай хуультай хамтад нь бичиж байгаа.

Энэ хууль дээр “санхүүгийн хэрэгсэл байршуулах”, “гадаад, дотоодын үнэт цаас худалдан авах” байдаг юм уу? Эдгээр нь тусгайлсан энэ хуулиар зохицуулагдах нь зүйтэй юм гэж үзэж байгаа.

Одоо бол бид ямар ч байсан эхний шатад Сангийн яамтайгаа ойлголцолд хүрээд 2 хувийг нь бид мөнгөжүүлээд аваад үлдье. Өмнөх шигээ бүх нийгмийн даатгалын шимтгэлийг, тэтгэврийн шимтгэлийг аваад буцаад өнөөдөр тэтгэвэрт нь буцаад гаргачихдаггүй, 2 хувийг нь бид хуримтлал байдлаар аваад үлдье гээд. Харин үүндээ зориулсан хууль эрх зүйн орчныг л бий болгоё гэж байгаа юм.

Тэгэхээр Н.Учрал гишүүний хэлж байгаа энэ зохицуулалтуудыг тухайн хуулиар нь хийе гэж бид төлөвлөж байгаа. Ирэх намар Улсын Их Хуралд Засгийн газраас өргөн барихаар ажиллаж байна.

П.Анужин: Н.Учрал гишүүн тодруулж асууя.

Н.Учрал: Энэ 2 хувийн хуримтлалыг Засгийн газрын бонд, үнэт цаас, дээрээс нь банкуудад гээд хаачхаж байгаа байхгүй юу.

Энэ дээрээ “санхүүгийн хэрэгсэл оруулж болно” гэж нэмэхгүй бол Х.Булгантуяа сайдын хэлээд байгаа нөгөө хууль чинь орж ирэхэд энэ чинь хаагдчихсан л ороод ирнэ.

Тэгэхээр Х.Булгантуяа сайд уг нь прогрессив^[дэвшилтэт] хүн байхгүй юу.

Тэгэхээр энэ “хөрөнгийн зах зээлээ”, “санхүүгийн зах зээлээ” дэмжинэ гэдэг ойлголтыг оруулж ирэхгүй бол болохгүй шүү дээ.

Дээрээс нь бас нэг ойлголтыг Та иргэддээ өгөх ёстой. С.Чинзориг сайд зөв хэлээд байна шүү дээ.

Хуваарилалтын тогтолцооны тэр мөнгө чинь өвлөгдөхгүй шүү дээ. Иргэдэд буруу ташаа ойлгогдох гээд байна шүү дээ.

Тэр 2 хувийн хуримтлал дээр чинь л өгөөж тооцоод өвлөгдөх юм яригдаж байгаа болохоос, иргэн болгоны тэтгэвэр өвлөгдөх хууль гарчихлаа гэж ингэж андуураад байна шүү дээ.

Харин тэгээд тэр 2 хувийнхаа хуримтлалын өгөөжийг яаж тооцоод, яаж өвлүүлэх юм. Дээрээс нь ямар мэргэжлийн хөрөнгө оруулагч нар түүнийг удирдах юм.

Тэгэхгүй бол “**Нийгмийн даатгалын зөвлөл**” гээд нөхдүүд чинь дахиад дампууруулна шүү дээ.

П.Анужин: Яг энэ хоёр зүйл жоохон хоорондоо хутгагдаж, хүмүүс буруу ойлгоод байгаа.

Сая С.Чинзориг сайдын ярьж байгаа 20 хувь бол тэтгэврийн тусгай зохицуулалт гэж байгаад нийгэм, эдийн засаг, ард түмний амьдрал, хамтарсан тэтгэвэр авсан байдал. Одоо нэг нь бурхан болбол үлдэж байгаа хүний эдийн засгийн ачаалал зэргийг тооцоод ийм “**тусгай зохицуулалт**” гэдгээр 20 хувь орж ирсэн. Энэ бол “өвлөгдөхтэй ямар ч хамаагүй”. Энэ нэрийн дансны өвлөгдөх

байдалтай хамаагүй тусгай зохицуулалт гэдгийг хэлье.

Ням-Осорын Учрал гишүүн санал хэллээ.

Батсүхийн Саранчимэг гишүүнийг асуулт асуухаас өмнө дэгээрээ түрүүн Дамбын Батлут гишүүний асуусан Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалтай холбоотой. Энэ нь шилжих үү, байгууллага шилжүүл гэсэн ийм асуулт асуусан шүү дээ. Хоёр асуулт.

Тэр дээр 5 номерын микрофонд Б.Батжаргал дарга одоо хариултыг нь өгчих.

Б.Батжаргал: Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Энэ аягүй чухал асуудал юм байна лээ.

Бид олон улсын туршлагыг судалж байгаад зөвхөн хувийн нэмэлт тэтгэврийн нэрийн данс гээд хүн бүхэн дээр нэг л данс үүснэ.

Тэгээд ажлаас гараад өөр ажилд ордог ч юм уу, ямар нэгэн шалтгаанаар одоо энэ хөтөлбөрөө сольсон тохиолдолд яах вэ гэсэн зохицуулалтыг хуулийн төслийн 5 дугаар бүлэг дээр 39.1. 39.2 гэсэн заалт дээр зохицуулаад өгчихсөн байгаа. Бас 9 дүгээр бүлэг дээр “**мэдээллийн сан**” гэсэн бүлгийг бас оруулж ирээд энэ дээр тухайн тэр бүх хүмүүсийн мэдээлэл нь ямар байдлаар үүсэх юм, яаж ашиглах юм гэсэн мэдээллийг нь бүгдийг нь оруулчихсан байгаа. Зохицуулалт нь байгаа. Тийм.

П.Анужин: Хоёр дахь нь, яагаад хязгаар тавьсан юм бэ гэж байгаа шүү дээ. Энэ өөрөө сайн дурын гэгчхээд энэ

хязгаарын чинь учир нь юу юм бэ тийм гэж асуусан.

Б.Батжаргал: Хоёр дахь асуултын хувьд хуулийн төслийн 10.4 дээр хоёр төрлийн хязгаарлалт байгаа.

Нэгдүгээрт, ажилтны төлөх шимтгэл ажилтныг хамгаалсан заалт. Хамгийн дээд талдаа нийт төлөх шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй шүү. Ажил олгогч бол хэдэн ч хувийг төлж болно. Нийт төлөх шимтгэлийг 90 хувиар ч юм уу, 100 хувиар төлж болно. Тухайн ажилтнаа дэмжих үүднээс.

Ажилтан бол хамгийн дээд талдаа шимтгэлийнхээ 50 хувийг, нийт төлөх шимтгэлийн 50 хүртэл хувийг төлнө гэсэн ажилтнаа хамгаалсан заалт байгаа.

Хоёр дахь асуулт нь, 20 хувийн хязгаарыг яагаад тавьсан бэ гэдэг нь болохоор энэ нь өөрөө татварын чөлөөлөлттэй холбоотой онцлог харилцаа. Төлж байгаа шимтгэл, ажил олгогчийн төлж байгаа шимтгэл, гишүүний төлж байгаа шимтгэл хоёулаа хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын татвар ногдуулах орлогоос чөлөөлөгдөнө.

Тэгэхээр энэ дээр дээд тааз байхгүй бол энд ямар нэгэн байдлаар бас буруугаар ашиглах тохиолдол олон улсад гардаг юм байна гэдэг дүгнэлтээс үүдээлтэйгээр 20 хувийн тааз тогтоож өгсөн байгаа. Тэгэхдээ энэ бол нэлээн өндөр тааз байгаа.

П.Анужин: Баярлалаа. Батсүхийн Саранчимэг гишүүн асуулт асууна.

Б.Саранчимэг: Баярлалаа.

Тэгэхээр өнөөдөр бид маш чухал хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Тэгээд

энэ дундаас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар тодруулах зүйлүүд байна.

Малчдын тэтгэвэр, тэтгэмжийг ямар бодлогоор яаж шийдэл гаргаж байгаа вэ гэсэн нэг ийм асуулт байна.

Тэгэхээр малчин хүн нийгмийн даатгалын шимтгэлээ хэрвээ өөрөө төлбөл 50 хувийг нь хөнгөлөлт үзүүлнэ гэж яриад байгаа.

Тэгэхээр энэ дээр тодруулж тодруулга авах гэсэн юм. Ер нь “малчин хүн” гэж ямар хүнийг хэлж байгаа вэ? Өнөөдөр нэг малтай хүнийг “малчин” гэж тооцох уу? Тийм ээ.

Тэгэхээр олон малтай хүний малчнаас энэ хөнгөлөлт үйлчлэх үү? Энэ бас нийгэм дээр нэлээн шүүмжлэл, нэлээн ойлголтын зөрүүтэй яваад байгаа учраас энэ дээр Сангийн яам болоод ажлын хэсгийн ахлагчийг тодруулж өгөхийг хүсэж байна.

Хэрвээ малчид маань өөрсдөө нийгмийн даатгалынхаа шимтгэлийг төлөөд явчихвал манай энэ улсын төсөвт ямар хөнгөлөлт үзүүлж байгаа вэ? Хэрвээ төлөхгүй бол ямар дарамт үзүүлж байгаа вэ гэдгийг бас нэг тодруулмаар байна.

Нөгөө талаар хүнд нөхцөлд ажилладаг хүмүүсийг тодорхой нэрлэхсэн байдаг. Тэгвэл өвлийн болоод хүйтэн улиралд ажилладаг уурын зуухын галчийг ийм хүнд нөхцөлд ажилладаг гэж оруулдаггүй юм билээ.

Тэгэхээр Нийгмийн даатгалын сангийн талаар хэлэлцүүлэг хийгээд явж байхад энэ тал дээр маш их асуулт асууж, тодруулга өгөхийг хүсэж байсан.

Тэгэхээр хүйтний нөхцөлд ажилладаг яг энэ уурын зуухын галчийг бас хүнд нөхцөлд оруулж өгөөч ээ гэсэн ийм хүсэлт байсан. Энэ хуулийн төсөлд орсон байгаа юу? Энэ дээр нэг тодруулга өгөөч. Баярлалаа.

П.Анужин: Б.Саранчимэг гишүүн их чухал тодруулгуудыг хийж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хуулийн төсөлд оруулж ирсэн нөгөө тооцоолол дээрээ үндэслээд. Тийм ээ. Энэ малчин иргэдэд үзүүлэх. Хэрвээ өөрөө төлбөл 50 хувийг нь улсаас дэмжлэг үзүүлнэ гэсэн энэ заалтаа санхүүгийнхээ тооцоололтой уялдуулаад тодорхой тайлбар өгчихье.

3 номерын микрофонд Ц.Ганцэцэг дарга хариулах уу? 2 номерын микрофонд.

Ц.Ганцэцэг: Б.Саранчимэг гишүүний асуултад хариулья.

Хуулийн төсөлд малчдын нийгмийн даатгалын хамралттай холбоотой нэлээн тодорхой тодорхой заалт орж байгаа. Энэ маань юу гэсэн үг вэ гэхээр малчид маань өнөөдөр нийгмийн даатгалын хамралт үндсэндээ 20 орчим хувьтай. Тоон үзүүлэлтээр аваад үзэхээр 40 гаруй мянган малчин нийгмийн даатгалд даатгуулаад явж байгаа.

2019 онд орсон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар 5 жилийн насыг нь наашлуулсан. Өнөөдөр 27 орчим мянган малчин нийгмийн даатгалаас тэтгэвэр аваад явж байгаа.

Тэгэхээр хамралт үндсэндээ хангалтгүй бага байгаа ийм үндэслэлээр малчдын нийгмийн даатгал даатгалын

шимтгэлийн 5 хүртэл жилийн шимтгэлийг өөрөө хариуцан төлж байгаа бол тэр шимтгэлийнх нь 50 хувийг нь төрөөс хариуцъя гэсэн ийм зохицуулалтыг оруулж байгаа.

Хэрвээ энэ зохицуулалт хэрэгжээд явбал малчид маань Нийгмийн даатгалынхаа сангаас тэтгэвэрээ аваад явах боломжтой. Тооцооллоор аваад үзэхээр жилдээ дунджаар 500 мянган төгрөгийн тэтгэврийг одоо аваад явж байна. Малчид маань.

Хэрвээ нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхгүй явбал улсын төсвөөс 13.2 их наяд төгрөг зарцуулах маш том зардлын тооцоолол үүсэж байгаа учраас энэ шимтгэлийнх нь орлогыг бас хариуцаад явбал яасан юм бэ гэсэн ийм зохицуулалт орж байгаа.

Хөдөлмөрийн хүнд нөхцөлийн хувьд ажлын хэсэг дээр яриад, ер нь энэ өргөн барьсан хуулийн төслөөр хөдөлмөрийн хүнд нөхцөлийг үндсэндээ 2025 оноос байхгүй болгоё гэсэн ийм зохицуулалт орсон боловч энэ хэлэлцүүлгийн үеэр ард иргэдийн санал, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, ер нь хэлэлцүүлэгт орсон.

Дээрээс нь ажлын хэсэг дээр яриад хөдөлмөрийн хүнд нөхцөлийг хэвээр нь байлгая гэдэг ийм зохицуулалт оруулаад ингээд зарчмын зөрүүтэй саналаар явж байгаа.

Одоогийн мөрдөж байгаа хуулиар хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн жагсаалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан тушаалаар мөрдөөд явж байна.

2004 оны 77 дугаар тушаалаар баталсан энэ жагсаалтыг мөрдөж байна.

Хүнд нөхцөлд ямар ямар ажил орох вэ. Таны асууж байгаа тэр сургуулийн, цэцэрлэгийн. Тийм ээ. Жижиг байгууллагын уурын зуухны галчийн хувьд жилийн дөрвөн улиралд бүтэн ажилладаггүй. Зуны улиралд амарчихдаг учраас энэ хүмүүсийн хувьд одоо мөрдөж байгаа жагсаалтаар бас хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамааруулах боломжгүй байгаа.

Яг өндөр хүчин чадал бүхий эрчим хүчний байгууллага, бүхэл бүтэн байгууллага, аймаг, салбар, одоо нөгөө талбайгаар нь халаалт гэдэг юм уу, цахилгаан эрчим хүчээр хангаж байгаа ийм байгууллагын уурын зуухны машинчийн хувьд хөдөлмөрийн хүнд нөхцөлд хамаарах нь нээлттэй байгаа.

Хуулийн төсөл батлагдсанаараа мэдээж энэ жагсаалт бас одоогийн хуулийнхаа заалтын дагуу сайд батлахаар байгаа.

Тэгээд энэ жагсаалт дээр бас шинэчлэл өөрчлөлт орно гэж ингэж харж байгаа.

Малчны хувьд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд тодорхойлолт нь байгаа. Жилийн дөрвөн улиралд мал аж ахуйнхаа орлогоор амьдралаа залгуулж байгаа хүнийг “малчин” гэнэ гээд.

Бид малчныг 5 жилийн өмнө тэтгэвэр тогтоож байхад энэ зохицуулалтаа “А” данс бүхий, жил бүхэн малаа тоолуулаад Үндэсний статистикийн хорооноос “А” дансаа авч байгаа, малын тооллогод хамаарсан хүмүүсийг малчин гэж үзээд малчинд хамааруулаад тогтоолгоод явж байгаа.

П.Анужин: Энэ 3.1.9 нь “малчин” гэж “мал аж ахуй эрхэлж,

үндсэн орлогоо олдог иргэнийг малчин” гэнэ гээд байж байгаа. Хуульдаа. Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж байгаа.

Гишүүд хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчдоос асуулт тавьж болно.

Нийт 47 зүйл байгаа. Ажлын хэсгээс бэлтгэсэн 21 зарчмын зөрүүтэй, найруулгын 1 санал байгаа.

Нэг.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

Хоёр.Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгье. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй. Санал байхгүй байна.

Гурав.Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгье. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй. Санал байхгүй байна.

4 дүгээр зүйлийн хуулийн нэр томьёоны тодорхойлолт.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “даатгуулагч” гэсний өмнө “нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор” гэж нэмж, мөн заалтын “заасан хувь хэмжээгээр” гэснийг “заасны дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.15 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг. Цаашид “Ажлын хэсэг” гэнэ. Санал хураая.

Гишүүдийг дуудаарай.
Х.Булгантуяа сайдыг дуудаарай.

Гишүүд Нийгмийн даатгалын багц хууль хэлэлцэж байна. Ирцдээ орчихоод гардаг байдлаа боль. Ингээд ирцдээ бүртгүүлчихээд хэлэлцэх асуудалдаа ордоггүй байдлаа больцгоо.

Ж.Чинбүрэн гишүүн ирсэн байна шүү дээ. Түрүүн. Нэгдүгээр асуудлаар өөрийнхөө асуудлыг. Тийм. Хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчлүүлж орсон. Энэ чухал хууль дээрээ Ж.Чинбүрэн гишүүнийг дуудаарай.

Санал хураалт явуулья. Гишүүд ээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбоотой санал хураалт. Түрүүн уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар дэмжигдлээ.

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын зарчим. Ерөнхий хууль дээрээ байгаа.

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын зарчим зүйл байгаа. 5 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

6 дугаар зүйл.Нийгмийн даатгалын төрөл. Энэ зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

7 дугаар зүйл.Нийгмийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ.

Зарчмын зөрүүтэй 4 санал ажлын хэсгээс байгаа.

Гишүүдээс саналтай гишүүд байна уу? Асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй 4 саналаар санал хураалт явуулья.

2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасаж, мөн зүйлийн 7.2.3 дахь заалтын “гадаад орноос Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар” гэснийг “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар” гэж өөрчилж, 7.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсад байрладаггүй өөрийн төлөөний газраар

дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтан;”

Санал гаргасана Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалтын “ганц гишүүнтэй ажил олгогчийн захирал,” гэснийг, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “эсхүл эцэг” гэсний дараа “, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч эх, эсхүл эцэг” гэж нэмэх.

Санал гаргасана Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Санал уналаа. Д.Батлут гишүүн санал гаргая.

Д.Батлут: Би саяын санал дээр дэмжих санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй.

Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож, ахин санал хураалгаж өгнө үү гэж хүсэж байна.

П.Анужин: Д.Батлут гишүүний төхөөрөмж ажиллаагүй тул саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгохыг дэмжсэн гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул ахин санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 7.4.10 дахь заалт нэмж, мөн зүйлийн 7.5.1 дэх заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасах.

“7.4.10.өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан.”

Санал гаргасана Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.10 дахь хэсэг нэмэх:

“7.10.Даатгуулагч сайн дураар даатгуулсан хугацаанд энэ хуулийн 19.1.2-г заасан гэрээгээр ажил гүйцэтгэсэн бол энэ хуулийн 7.9 дэх хэсэг хамаарахгүй.”

Санал гаргасана Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Би өгөөгүй байна. Би зарчмын зөрүүтэй санал гаргая. Төхөөрөмж сая орсонгүй. Саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгож өгөх саналыг гаргаж байна. Санал хураалт явуулья.

Санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Санал хураалтыг ахин явуулья.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

8 дугаар зүйл дээр саналтай, асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

9 дүгээр зүйлтэй холбоотой санал хэлж, асуулт асуух гишүүд байна уу? Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

10 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуу, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

11 дүгээр зүйлтэй холбоотой санал хэлж, үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй болно.

12 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн зарлага гэсэн зүйл байгаа. Уг зүйтэй холбоотойгоор үг хэлж, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Санал хураалт явуулья.

6.Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4, 12.1.5 дахь заалт нэмэх:

“12.1.4.энэ хуулийн 13.3-т заасан зөвлөлийн гишүүний урамшуулал, үйл ажиллагааны зардал;

12.1.5.нийгмийн даатгалын сангаас төлөх шимтгэлийн төлбөр;”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Содномын Чинзориг гишүүнд микрофон өгье.

С.Чинзориг: Би үүнийг нөгөө зөвлөлийн гишүүний урамшуулал, үйл ажиллагааны зардал гээд байхаар нь

зөвлөлийн гишүүний л урамшуулал юм бодсон чинь өөр юм байна л даа.

Тэгээд ийм юм одоо шинээр оруулах хэрэг байгаа юм уу? Тэртээ тэргүй энэ хуулиар чинь төрийн захиргааны байгууллага хариуцна гээд нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн гээд тэр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааг агентлаг өөрөө хариуцах юм байна шүү дээ? Тийм ээ.

Тэгээд энэ хуулиар чинь тэр хяналтын зөвлөлтэй байх юм байна. Хяналтын зөвлөл нь үйл ажиллагааны зардалтай байх, зөвлөлийн гишүүдийн урамшуулалтай байх нь л дээ. Ийм байх хэрэг байгаа юм уу?

Тэртээ тэргүй хуулиараа тэр асуудлыг чинь “**нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага**” гэдэг чинь “**агентлаг**” л эрхлэх юм байна шүү дээ.

Одоо тэр “хөрөнгө оруулах үйл ажиллагаанд хяналт тавих”, “мэргэжил, арга зүйн зөвлөгөө” анх “орон тооны олон нийтийн хяналтын зөвлөлтэй байна” гээд нэг зөвлөл гаргаж ирээд.

Тэр нь тэгээд нийгмийн даатгалын шимтгэлээс төлбөр авахаар, үйл ажиллагааны зардалтай байхаар, гишүүдийн урамшуулалтай байхаар асуудал орж ирж байна. Ийм байж болохгүй шүү дээ.

Би бол энэ шаардлагагүй л гэж үзэж байна. Яагаад ийм юм оруулж ирж байгаа юм.

Тэртээ тэргүй тэр үүрэг нь 13.2-оороо тэр “**агентлаг энэ үйл ажиллагааг эрхэлнэ**” л гээд хуульчилчихсан юм байна шүү дээ. Тэгээд тэр “хяналтын зөвлөл” гээд тийм нэг зөвлөлтэй болгоод.

Тэгээд тэр нь бүр нийгмийн даатгалд иргэдийн төлж байгаа шимтгэлээс үйл ажиллагааны зардал авах, бүр урамшуулал авах асуудал оруулж ирдэг. Ийм бол дэмжих шаардлагагүй. Би дэмжихгүй л гэсэн ийм л байр суурьтай байна.

П.Анужин: С.Чинзориг сайдын асуултад хариулъя.

13.2-т заасан “хөрөнгө оруулах үйл ажиллагаанд хяналт тавих” гэж байгаа.

Мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлтэй байна гэж.

Өнөөдрийг хүртэл ард, иргэд НДҮЗ^[Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл]-ийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай биш байгаа.

Эдгээрийн ямар ч хяналтгүй гаргасан энэ шийдвэрийн гороор одоо энэ иргэдийн өгсөн мөнгийг үлэмж хэмжээгээр алдчихсан байгаа.

Тэгэхээр энд мэргэжил, арга зүйгээр хангаж, ингээд хяналт тавих ийм 4 мэргэжлийн хороог байгуулж байгаа юм байна гэж Засгийн газраас өргөсөн хуульд оруулж ирсэн байгаа.

Орон тооны бус гэдгийг бид асуусан. Зардал гаргах зүйлүүдийг хууль санаачлагчаас асуусан байгаа.

Тооцоололтой холбоотой зүйлийг 4 номерын микрофон дээр хариулъя. А.Хишигбаяр дарга хариулъя.

А.Хишигбаяр: С.Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Нийгмийн даатгалын байгууллага санхүүгийн хөрөнгө оруулалт орох үйл ажиллагааг нь зохион байгуулах ажлыг л хийнэ.

Гол санхүүгийн хэрэгсэлд оруулах шийдвэрүүд нь Үндэсний зөвлөл дээр гарч байгаа.

Тэгэхээр Үндэсний зөвлөлийн гаргаж байгаа шийдвэр дээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө, хяналт тавих хөндлөнгийн байгууллагын орон тооны бус зөвлөл ажиллахаар, хяналтын зөвлөл ажиллахаар бид оруулж өгсөн байгаа.

Энэ бол бас нөгөө орон нутгаар явж байгаа болон бусад иргэдээс ирсэн маш их санал байгаа. Одоо Авлигатай тэмцэх газар гэхэд хяналтын зөвлөл ажилладаг. Олон нийтийн хяналтын зөвлөл ажилладаг. Үүнтэй адилхан нийгмийн даатгалын хөрөнгө бол даатгуулагч, ажил олгогч, төрөөс гээд гурван талаас шимтгэл цуглуулж байгаа хөрөнгө учраас олон нийтийн хяналтын зөвлөл ажиллах нь зүйтэй гэдэг санал маш их ирсэн байгаа.

Тэгээд үүнтэй уялдуулаад бид оруулаад явсан байгаа.

П.Анужин: Санал хураалт явуулъя. Гишүүд ээ.

Санал хураалт. Түрүүн уншиж танилцуулсан. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

13 дугаар зүйл. Асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? 13 дугаар зүйлтэй холбоотойгоор. Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Санал хураалт явуулъя. Танилцуулъя. Уншиж танилцуулъя.

7.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын “Монголбанкнаас тогтоосон системийн ач холбогдол бүхий” гэснийг “Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “үүрэг бүхий” гэсний дараа “орон тооны бус” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Төсөл 77.8 хувиар дэмжигдлээ.

14 дүгээр зүйлтэй холбоотой санал хэлж, үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

15 дугаар зүйлтэй холбоотой санал хэлж, үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

16 дугаар зүйлтэй холбоотой санал хэлж, үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

17 дугаар зүйлтэй холбоотой санал хэлж, үг хэлэх гишүүд байна уу? Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан гэсэн. Санал хэлж, үг хэлэх гишүүн байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал байхгүй.

18 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ гэсэн зүйлтэй холбоотой санал хэлж, үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулья.

8.Төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “хувь хэмжээ,” гэсний дараа “хэрэглэх” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Санал 66.7 хувиар дэмжигдлээ.

19 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүн. 19 дүгээр зүйл байгаа.

Уг зүйлтэй холбоотойгоор санал хэлж, үг хэлэх гишүүн байна уу? Содномын Чинзориг гишүүн үг хэлье.

С.Чинзориг: Энэ 19 дүгээр зүйл “нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүн хэсэг” гэсэн ийм зүйл байна л даа.

Тэгээд энэ дотроос А.Хишигбаяр аа, 19.1.3 дахь заалтын тэр “бүсийн болон хээрийн нэмэгдэл” гэдгийг “шимтгэлд ноогдох орлого”-оос хасчхаж байгаа юм байна л даа.

Үнийг яагаад хасаж байгаа юм? Бүсийн болон хээрийн нэмэгдлийг нь шимтгэлд ногдох орлогоос хасах ямар шаардлага байгаа юм? Яагаад хасчихсан юм?

Уг нь Засгийн газар оруулаад ирсэн юм байна л даа. Ажлын хэсэг дээр хасчихсан юм байна гэж ойлгоод байна. Үүнийг яагаад хасаж байгаа юм? Бүсийн болон хээрийн нэмэгдэл уг нь байж байхад нэг их буруудахгүй юм байхгүй шүү дээ.

П.Анужин: 4 номер. Ажлын хэсгийн гишүүн А.Хишигбаяр дарга хариулья.

А.Хишигбаяр: С.Чинзориг гишүүний асуултад хариулья.

Бүсийн болон хээрийн нэмэгдэл гэсэн энэ нэмэгдэл бол нөгөө цалин хөлс

буюу 19.1.1 дотор өөрөө багтаж байгаа юм билээ. Нэмэгдэл гэдэг дотроо, цалин хөлсний үндсэн нэмэгдэл дотроо ороод явна.

Тийм учраас яах вэ, агуулгын хувьд давхардаад байна гээд бид хэд хассан байгаа.

П.Анужин: Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууя.

Б.Жаргалмаа: Би энэ зүйл, заалттай холбоотой байх гээд нэг зүйлийг тодруулаадахъя.

Хөдөлмөрийн тухай хуульдаа бид цагийн хөлс, дадлагажигч ажилтны хөдөлмөрийн хөлс гэдэг ийм зүйл, заалтууд оруулсан байгаа. Тэгээд энэ зүйл заалтаас шалтгаалаад өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд, байгууллагууд цагаар ажилласан ажилтныхаа хөдөлмөрийн хөлсийг өгөх энэ асуудал дээр бас яг нийгмийн даатгалын шимтгэлийн хувьд бас маргаан дагуулсан ийм асуудал үүсээд байгаа.

Өөрөөр хэлбэл 3 өдөр ажиллаад 3 өдрийн хөдөлмөрийн хөлсөө авах гэхээр нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх ийм зохицуулалт байгаад байна.

Үүнээс үүдэн цагийн хөлс болон өдрөөр ажилласан ажилтандаа бид нийгмийн даатгал заавал төлөх шаардлага үүсээд байдаг. Гэтэл 2 өдрийн цалинг олгохоор заавал даатгал төлөх нь өөрөө аж ахуйн нэгжид тодорхой хэмжээний хүндрэл учруулаад байна.

Ямар нэгэн байдлаар шууд дадлагачид туршилтын хугацаанд ажилласан гэдгээрээ даатгал төлөхгүй байхаар эргээд аудитаас даатгалын

асуудал дээр торгууль тавигдаад байна гэдэг ийм зүйл, заалт ярьж байгаа.

Тэгэхээр Нийгмийн даатгалын багц хуулийн даатгалтай шимтгэлд ногдох орлогын бүрэлдэхүүн гэдэг энэ зүйл заалт дээр энэ асуудал ер нь зохицуулагдах боломж байгаа болов уу гэдэг зүйлийг тодруулья.

П.Анужин: 2 номерын микрофонд Ц.Ганцэцэг дарга хариулна.

Ц.Ганцэцэг: Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулья.

Хуулийн төслийн 19.1.1-д үндсэндээ нийгмийн даатгалын шимтгэлд ногдуулах орлогын бүрэлдэхүүн маань Хөдөлмөрийн хуулийн холбогдох зүйл, заалттай уялдаж орсон байгаа.

Хөдөлмөрийн хуулиар дадлагажигч гэдэг юм уу, цагаар ажиллаж байгаа хүмүүсийн хувьд хөдөлмөрийн гэрээ байгуулахаар, Хөдөлмөрийн хуулиараа зохицуулж байгаа учраас нийгмийн даатгалын харилцаа маань үндсэндээ хөдөлмөрийн гэрээн дээр, хэрвээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол нийгмийн даатгалд албан журмаар заавал даатгуулна гэсэн энэ зохицуулалт уялдаад явж байгаа.

Тэгэхээр цагаар байна уу, өдрөөр байна уу тэр хүн цалин хөлс аваад гэрээгээр ажиллаж байгаа бол нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөр байгаа.

Эргээд энэ төлсөн шимтгэлээс нь тэтгэврийг нь, тэтгэмжийг нь, шимтгэл төлсөн хугацааг нь тооцох асуудал нээлттэй учраас тухайн дадлагажигч, цагаар ажиллаж байгаа оюутнууд гэдэг юм уу, энэ хүмүүс маань нийгмийн даатгалын харилцаанд ороод явбал

нийгмийн баталгаа нь хамгаалагдаад явна гэсэн байдлаар, үндсэндээ шимтгэл төлнө гэсэн байдлаар ороод явж байгаа.

П.Анужин: Санал хураалт явуулья. Гишүүд ээ.

9.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын “бүсийн болон хээрийн нэмэгдэл,” гэснийг хасаж, мөн зүйлийн 19.1.4 дэх заалтын “зүйлийн 19.1.1, 19.1.2-т “ гэснийг “хуулийн 19.1.1-д” гэж өөрчлөх:

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар санал дэмжигдлээ.

20 дугаар зүйл. 20 дугаар зүйлтэй холбоотойгоор санал хэлж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

21 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт гэсэн зүйл байгаа. Санал хэлж, үг хэлэх гишүүд байна уу? Шимтгэлтэй холбоотойгоор. Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Саналыг уншиж танилцуулья.

10.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.28 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 21.31 дэх хэсгийг хасах:

“21.28.энэ хуулийн 7.7-д заасан даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуульд заасны дагуу нийгмийн даатгалын зохих санд төлж болно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

22 дугаар зүйлд итгэлцүүрийг хэрэглэх, тогтоох гэсэн зүйл байгаа. Үүнтэй холбоотойгоор санал хэлж, үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг Та бүхэндээ танилцуулья.

11.Төслийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “4 дүгээр” гэснийг “8 дугаар” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар санал дэмжигдлээ.

23.Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацаа. Энэ зүйлтэй холбоотойгоор үг хэлж, санал хэлэх гишүүд байна уу? Асуулт байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

24 дүгээр зүйлтэй холбогдож үг хэлж, санал хэлэх гишүүд байна уу? Асуулт байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

25 дугаар зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах гэсэн зүйл байгаа. Энэ зүйлтэй холбоотой санал хэлж, үг хэлэх гишүүд байна уу? Асуулт байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

26 дугаар зүйл. Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох гэсэн зүйл байгаа. Энэ зүйлтэй холбоотойгоор үг хэлж, асуулт асууж,

санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

27 дугаар зүйл. Тэтгэврийн даатгалын нэрийн дансны бүртгэл. Энэ зүйлтэй холбоотойгоор санал, асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулья.

12.Төслийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтын “төлсөн” гэсний дараа “тэтгэврийн даатгалын” гэж нэмж, мөн зүйлийн 27.4 дэх хэсгийн “тусгай дансанд” гэснийг “тусгайлан” гэж, 27.7.2 дахь заалтын “системийн ач холбогдол бүхий” гэснийг “Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалт 55.6 хувиар дэмжигдлээ.

28 дугаар зүйл. Нэрийн дансны орлогыг бүртгэл тусгай төсөл гэсэн. Энэ зүйлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

29 дүгээр зүйл. Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх. Асуулт, үг байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулья.

13.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийн “орлогыг” гэснийг “орлогын тодорхой хувийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 29.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож зөрүүг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Содномын Чинзориг гишүүн асуулт асууя. Санал хураалтыг түр түдгэлзүүл. Содномын Чинзориг сайд асуулт асууна.

С.Чинзориг: Энэ хоёр тийм ойлголтын зөрүү л яваад байгаа юм даа.

Яах вэ, тэр тэтгэврийн сангийн 2 хувийг мөнгөжүүлэх, хуримтлал үүсгэх юм байна. Тийм ээ.

Тэгээд үүнээсээ мөнгөжүүлэх юм байна. Тэтгэврийн санг хуримтлал үүсгэх асуудал өөр жичдээ асуудал. Нэрийн дансыг мөнгөжүүлэх асуудал чинь өөр асуудал гэж би тэгж ойлгоод байгаа юм.

Тэгээд та нар энэ мөнгөжүүлэх асуудлыг сангийн 2 хувийн үлдэгдлээр нь хуримтлал үүсгээд мөнгөжүүлэх асуудал болгоод байна шүү дээ. Энэ чинь тэгээд хоёр юмыг холиод байгаа юм биш үү?

Нэрийн дансыг мөнгөжүүлэх асуудал өөр жич тусдаа асуудал. Нийгмийн даатгалын санг өөрийг нь хуримтлал үүсгэж хуримтлуулах асуудал өөр асуудал.

Мөнгөжүүлэх асуудал яагаад үүсээд байна вэ гэхээр манайх нөгөө

хуримтлалын хуваарилалтын тогтолцоотой учраас өнөөгийн шимтгэл төлж байгаа иргэдийнхээ шимтгэлээр л өмнө нь тэтгэвэрт гарсан иргэдийнхээ тэтгэврийг л төлж тавьчихсан асуудал шүү дээ.

Тэгээд үүнийгээ засаг өөрөө бүрэн хариуцаж мөнгөжүүлэх ёстой асуудал. Тэр сангийн чөлөөт үлдэгдлийг чинь 2 хувь хуримтлал үүсгээд. Энэ чинь харин хуримтлал үүсээд хуваарилалтын тогтолцооноосоо бид хагас хуримтлалын тогтолцоо руу шилжих. Энэ бол өөр асуудал.

Тэр хоёр өөр асуудлыг л ингээд холиод л яваад байна даа гэж би тэгж л хэлэх гээд байгаа юм л даа. Үүнийг та бүхэн юу гэж ойлгоод байна?

Хоёр дахь асуудал нь, нэрийн дансны мөнгийг чинь ингээд хуримтлал үүсгэчхээд, тэгээд мөнгөжүүлсэн орлогыг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ гэж.

Тэгээд энэ чинь хэдэн оноос мөнгөжих юм? Энэ мөнгөжүүлсэн орлогыг чинь өвлүүлнэ гэдэг чинь хэдэн оноос хэрэгжих юм? Үүнийг тодорхой заах юм уу, үгүй юм уу?

Нөгөө Тэтгэврийн тухай хууль дээр чинь тэтгэвэр авч байгаа хоёр иргэний нэг нь нас барвал 20 хувийг нь олгоно гээд байгаа чинь энэ мөнгөжүүлсэн орлогоосоо өв залгамжлагчид нь өвлүүлнэ гэдгийг хэлээд байгаа юм уу? Тэр чинь дахиад тусдаа өөр асуудал юм уу?

Тэр Тэтгэврийн хууль дээр чинь байгаа тэтгэврийнх нь 20 хувийг аль нэгэн амьд үлдсэн сэрүүн байгаад нь өгөх тухай асуудал орж ирж байна лээ шүү дээ. Тэр 9 дүгээр зүйл дээр байв уу даа.

Тэр чинь үүнийг хэлээд байгаа юм уу? Дахиад өөр зохицуулалт юм уу? Мөнгөжүүлсэн орлогоо өв залгамжлуулна гэдэг чинь өөр асуудал. Би өөр шинэ асуудал болов уу гэж ойлгоод байгаа юм.

Тэр үлдсэн нэгэнд нь 20 хувийг нь тэтгэврийг нь нэмж өгнө гэдэг өөр асуудал юм уу гэж би тэгж ойлгоод байгаа юм. Энэ мөнгөжүүлсэн орлогоо өвлүүлнэ гэдэг чинь өөр асуудал юм бол. Хоёр өөр юм уу гэж би тэгж ойлгоод байгаа юм.

Хэрвээ энэ мөнгөжүүлэх асуудлыг шийдээд, тэгээд өв залгамжлагчид нь өвлүүлнэ гэж байгаа бол хэдэн оноос ямар хэмжээний орлого бүрдээд, ямар хэмжээгээр өвлүүлэх юм бэ? Хэдэн оноос хэрэгжих юм бэ? Тодорхой асуудал оруулахгүй бол энэ чинь тэгээд хууль батлагдаад, хэрэгжээд, эхэлснээс ингээд мөнгөжүүлсэн орлогоос өвлөх тухай асуудал болоод явчихна шүү дээ.

Тэгэхээр ер нь наад сан чинь тэгээд юу болох юм? Дийлэх юм уу? Тэтгэврийнх нь 20 хувийг нь амьд үлдсэн нэгэнд нь өгнө л гэнэ, мөнгөжүүлсэн орлогыг нь өвлүүлнэ л гэнэ. Мэдэхгүй. Сангийн яам нь тэгээд тооцоогоо нийлсэн л байгаа даа. Базарваань.

Бидэнд ингээд ярихад сайхан л байна. Тэтгэвэрийн чинь 20 хувийг нэгэнд нь өгнө, мөнгөжүүлсэн орлогыг чинь өвлүүлнэ гээд ярихад. Тэгээд үүнийгээ Сангийн яамтайгаа нийлсэн юм уу, тооцоо нийлсэн юм уу? Хэдэн оноос хэрэгжих юм? Хэдэн хувийг нь өвлүүлэх юм? Энэ асуудал ерөөсөө тодорхойгүй байна шүү дээ.

П.Анужин: 4 номерын микрофонд А.Хишигбаяр дарга хариулья.

А.Хишигбаяр дарга аа, түрүүнээс хойш С.Чинзориг сайд хоёр юмыг ялгаад. Та нар хутгаад байгаа юм биш үү? Тэр дээр нэг тодорхой хариулт өгчих.

А.Хишигбаяр: С.Чинзориг гишүүний асуултад хариулья.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл дээр яг мөнгөжүүлэх буюу нэрийн дансыг мөнгөжүүлэх асуудлыг тусгайлан заасан байгаа.

Таны хэлдгээр нөгөө “**нэрийн данс**”, “**мөнгөжүүлэх**” хоёр чинь тусдаа гээд байгаа юм. Тийм.

Бид өнөөдөр яаж хүний шимтгэлийг мөнгө болгох вэ гэдгийг гурван зүйлээр зохицуулсан байгаа.

Хууль хэрэгжээд эхлэхээр ажил олгогчийн төлж байгаа 1 хувь, даатгуулагчийн төлж байгаа 1 хувь, ингээд 2 хувийг нь тэтгэвэрт олгохгүйгээр бэлэн мөнгөөр тусгайлсан дансанд бүртгээд яг бэлэн мөнгө болгоод явъя гэдгийг хэлж байгаа.

Энэ зардалд нийтдээ 369.0 тэрбум төгрөг шаардлагатай. Энэ нь магадгүй улсын төсвийн татаас болж нийгмийн даатгалын сан дээр орж ирэх байх гэж Сангийн яамтайгаа бид ийм зардал гарахаар байна гэдэг дээр тохиролцсон байгаа.

Нөгөөдөх нь, өнөөдөр 1.4 сая хүн нэрийн дансны бүртгэлтэй. Энэ дээр 27 их наяд бичигдсэн байгаа. Энэ бичигдсэн 27 их наядыг хоёр эх үүсвэрээс бүрдүүлээч ээ гэдгийг энэ хууль дээр бас бид тусгасан байгаа.

Нэгд, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу 2030 оноос эхлээд

Ирээдүй өв сангаас мөнгө Засгийн газар луу шилжүүлнэ. Энэ Засгийн газарт шилжүүлж байгаа мөнгөнөөс нэрийн дансны бичилтийг мөнгөжүүлээч ээ гэж оруулж ирж байгаа.

Хоёрт, улс өнөөдөр ямар нэгэн байдлаар боломжтой болох юм бол улсын төсвөөс жил болгон тодорхой хэмжээгээр нэрийн дансны өнөөдрийн 27 их наядыг бас мөнгөжүүлээд яваач ээ гэсэн ийм гурван эх үүсвэрээс л энэ мөнгөжүүлэх асуудал гарна гэж үзэж байгаа.

Мөнгөжүүлэх асуудал маань тодорхой хугацааны дараа бид өвлүүлэхгүй бол хууль хэрэгжүүлээд л 2 хувиа өнөөдөр одоо ингээд л бэлэн мөнгө болгоод л явж байнгуутаа хууль хэрэгжүүлээд бид өвлүүлнэ гэвэл энэ нь боломжгүй гэж харж байгаа.

Тэгэхээр яг өвлүүлэх харилцаа бол 2030 оноос өвлүүлнэ гээд хойшоогоо заалтаар бид тусгайлан заагаад өгчихсөн байгаа.

Яг хэдэн хувь өвлүүлэх юм бэ, ямар байх юм бэ гэдэг нь Засгийн газрын журмаар бид зохицуулаад явахгүй бол 2030 оны асуудлыг бид шууд 2 хувийн нөлөө нь 40, 50, нийт мөнгөжүүлсэн орлого нь 40, 50-ийг өвлүүлнэ гэдэг нь өнөөдрийн хувьд арай эрт байна гэж харж байгаа.

Тэр 29.7-г бид ингэж харж байгаа. Магадгүй тухайн хүн тодорхой хэмжээний мөнгө мөнгөжүүлчихсэн байна. Дансанд нь. Тэгтэл тухайн хүн бурхан болчих юм бол ард нь тэр хүний асрамжид байсан тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүн гарч ирж магадгүй.

Тэгвэл энэ хүнд нь хамгийн түрүүнд бид нийгмийн байдлыг нь

дордуулахгүйн тулд эхлээд тэжээгч алдсаны тэтгэврийг нь тогтоож өгнө. Магадгүй 17 настай хүүхэд үлдлээ гэх юм бол 2 жил тэжээгч алдсаны тэтгэвэр авах ёстой. 2 жил бид хэчнээн төгрөг тэр хүн тэтгэвэр болгож хүүхдэд өгөх вэ, тэр мөнгийг нь тооцож өгөөд мөнгө үлдэх юм бол тэрийг нь бид өвлүүлэх харилцаа руу оруулна гэсэн ийм байдлаар нэмэлт зарчмын зөрүүтэй саналаар оруулж ирээд явж байгаа.

П.Анужин: Санал хураалт явуулъя. Гишүүд ээ.

Тэр хуримтлалд хуримтлагдсан мөнгөөр эрүүл мэнд, боловсрол, ипотекийнхоо асуудлыг шийдэхэд хэрэглэнэ. Тэр хэзээнээс вэ гэж байгаа.

Ахиад хариулчихъя. 4 номерын микрофонд.

А.Хишигбаяр: 2 хувийг бид бэлэн мөнгө болгож, хууль хэрэгжиж эхлэхээс эхлээд хадгалаад явна гэж байгаа.

Энэ нь тухайн даатгуулагчийн төлж байгаа шимтгэлийн 14-өөс 15 хувь нь байгаа.

Тэгэхээр сая төгрөгийн шимтгэл төлж байна гэвэл 150 мянга нь яг бэлнээр хадгалагдана. Үлдсэн мөнгө нь өнөөдрийн тэтгэвэр авагчийн тэтгэвэрт зарцуулаад явна гэж байгаа.

Энэ 2 хувиа бид буцаагаад “хуримтлалын нэгдсэн сан” руугаа Хуримтлалын нэгдсэн сангийн хуулиар зохицуулж байгаа санхүүгийн хэрэгсэлд оруулж өсгөн арвижуулах. Энэ санхүүгийн хэрэгсэлд ямар хөрөнгө оруулалтад оруулах вэ, ямар санхүүгийн хэрэгсэлд оруулах вэ гэдэг нь тухайн даатгуулагч өөрөө сонголтоо хийнэ гэдэг байдлаар.

Хуримтлалын нэгдсэн санд очиж байгаа тэр 2 хувиараа ипотекийн зээлдээ хамрагдаж болно.

Мөн сургалт буюу эрүүл мэндийн зардалдаа зарцуулж болно гэдэг нь хуримтлалын нэгдсэн сангаараа зохицуулаад явна гэдэг байдлаар бид томьёолоод явж байгаа.

П.Анужин: Содномын Чинзориг сайд тодруулъя.

С.Чинзориг: Бидэнд тийм их орлого нь байхгүй, хуримтлал нь байхгүй, тэгээд л баахан мөнгөжүүлнэ гээд л, тодорхой хэмжээгээр эрүүл мэнд, соёлын, боловсролын зардалд зарцуулж болно, орон сууцын ипотекийн зээлд зарцуулж болно, өвлүүлж болно гээд л баахан ийм юм яриад.

Тэгээд тэр нь хэзээ хэрэгжих нь тодорхойгүй, хэзээ тэр мөнгө нь орох нь тодорхойгүй, хэзээ мөнгөжих нь тодорхойгүй ийм юмыг бичиж ингэж ард түмний дунд хүлээлт үүсгэж, хий сенсац үүсэх хэрэг байгаа юм уу, үгүй юу?

Тэр Баялгийн сантайгаа, Хуримтлалын сантайгаа давхар яримаар.

Хоёрдугаарт, нийгмийн даатгалын санг арвижуулах, хуримтлал үүсгэх асуудал чинь өөр асуудал.

Нэрийн дансыг мөнгөжүүлэх чинь өөр асуудал гэж хэлээд байхад үүнийг нь чи тодорхой тайлбарлаад хэл л дээ. Тэгээд хутгаад байна шүү дээ.

Тэгээд тэр хуримтлалынхаа сангаараа сангийн чинь сангаар нь мөнгөжүүлэх гээд байна шүү дээ.

П.Анужин: 4 номерын микрофонд хариулт өгье. Х.Булгантуяа сайд хариулья.

Х.Булгантуяа: Нэгдүгээрт, С.Чинзориг сайд аа, энэ Засгийн газрын өргөн барьсан хууль.

Дээрээс нь нэмээд өнөөдрийг болтол бас хэлэлцэхгүй байсан зүйл нь энэ олон мөнгөний асуудлуудыг, төсөв, санхүүгийн асуудлууд дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам хоёр тооцоонуудаа нийлэх зайлшгүй шаардлагатай байсан.

Сүүлийн хоёр сар Нийгмийн бодлогын байнгын хороо, манай яам, Сангийн яам ерөөсөө л энэ хэдэн тооцоогоо л нийлсэн.

Таны хэлж байгаа үнэн. 1.4 сая хүний 27 их наяд дээр зүгээр бичилт л хийсэн байгаа. Үүнийг мөнгөжүүлнэ гэх юм бол бид нэг доор, нэг удаа үүнийг мөнгөжүүлж чадахгүй.

Тэгэхдээ ийшээгээ бид алхмыг хийх ёстой. Хуваарилалтын зарчмаас бид “хагас хуримтлал” руу, тэгээд явсаар байгаад “бүрэн хуримтлал” руу бид цаашдаа явах ёстой.

Үүнийг бид аажмаар хийе гэж байгаа юм. Бид ихээр хийж чадахгүй.

Тийм учраас ирэх жилээс 2 хувийг. Энэ л гэхэд 370.0 тэрбум төгрөгийн төсөв дээр ачаалал өгнө. Тэгэхдээ Сангийн яам ч гэсэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч гэсэн эхлээд 2 хувиар эхэлье.../минут дуусав/

П.Анужин: Санал хураалт явуулья. Гишүүд ээ. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

30 дугаар зүйлтэй холбоотойгоор санал хэлж, асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

31 дүгээр зүйл. Үг хэлж, асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

32 дугаар зүйлтэй холбоотой асуулт, санал байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

33 дугаар зүйтэй холбоотой асуулт, санал байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн.

14.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.5 дахь заалтын “ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг хуулиар тогтоосон” гэснийг “ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ болон энэ хуулийн 21.1-д заасан” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

34.Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны зарчим. Энэ зүйлтэй холбоотойгоор үг хэлж, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

35 дугаар зүйлтэй холбоотой санал, үг байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

15.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “үйлдвэрчний эвлэлээс” гэснийг “байгууллагаас” гэж өөрчилж, мөн зүйлийн 35.3 дахь хэсэг, 35.16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 35.15, 35.16 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 35.9 дэх хэсгийг хасах:

“35.3.Ажил олгогч болон даатгуулагчийн төлөөллийн байгууллага нээлттэй сонгон шалгаруулах журмаар нэр дэвшигчийг сонгон Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд ирүүлнэ.

35.15.Үндэсний зөвлөлийн дүрэм болон энэ хуулийн 35.3-г заасан нээлттэй сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.

35.16.Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

36 дугаар зүйл.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг. Үг асуулт байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

37.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдлага, чиг үүрэг. Асуулт үг байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулья.

16.Төслийн 35 дугаар зүйлийн 35.17 дахь хэсгийн “тогтолцоо, хууль тогтоомж, нийгмийн даатгалын” гэснийг, мөн зүйлийн 35.20 дахь хэсгийн “Энэ зүйлийн 35.14-г заасан” гэснийг тус тус хасаж, 35.17 дахь хэсгийн “аудитын” гэсний дараа “орон тооны бус” гэж, 35.19 дэх хэсгийн “35.17-д заасан” гэсний дараа “мэргэжлийн хорооны ажиллах журам,” гэж тус тус нэмж, 35.17 дахь хэсгийн “ажиллуулж, урамшуулал олгоно” гэснийг “ажиллуулна” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 35.20 хэсэг нэмэх:

“35.20.Энэ хуулийн 35.19-г заасан урамшууллыг мэргэжлийн хорооны гишүүний ажлын үр дүнг харгалзан Үндэсний зөвлөл олгоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

38.Нийгмийн даатгалын хяналт, шалгалт, нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх үүрэг гэсэн зүйл байгаа. Санал, үг байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

39.Нийгмийн даатгалын улсын байцаагчид хориглох зүйл. Санал, үг байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Уншиж танилцуулья.

17.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалтын “нормативыг” гэснийг “дээд хязгаарыг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

37 дугаар зүйлийг та бүхэнд уншиж танилцуулья. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдлага, эрх, чиг үүрэг. Санал, асуулт байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна.

18.Төслийн 37 дугаар зүйлийн 37.3, 37.9, 37.12 дахь хэсгийн “өвчин судлалын” гэсний дараа “төрөлжсөн мэргэшлийн” гэж, мөн зүйлийн 37.12 дахь хэсгийн “нийгмийн хамгааллын” гэсний дараа “болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

38 дугаар зүйлтэй холбоотой санал, асуулт байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

39 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын улсын байцаагчид хориглох зүйл байгаа. Санал, асуулт байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

19.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1.5 дахь заалтын “, хууль тогтоомж зөрчихийг зөвлөх, тулгах, шаардах” гэснийг хасаж, мөн зүйлийн 39.1.7 дахь заалтыг “39.1.7, 39.1.8, 39.1.9” дахь заалт болгох.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

40 дүгээр зүйл. 40 дүгээр зүйлтэй холбоотойгоор санал, асуулт байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

41 дүгээр зүйл. 41 дүгээр зүйлтэй холбоотой санал, үг байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

42 дугаар зүйлтэй холбоотой санал, асуулт байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

43 дугаар зүйлтэй холбоотой санал, асуулт байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй.

44 дүгээр зүйл. 44 зүйлтэй холбоотой санал, асуулт байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй.

45 дугаар зүйл.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих. Асуулт, санал байна уу? Байхгүй байна.

46 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт. Үг, санал байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулья.

20.Төслийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

47 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй нэг санал байна. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулья.

21.Төслийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй санал дууссан. Одоо найруулгын шинж чанартай хоёр санал байна. Уншиж танилцуулья.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 дэх заалтын “хорогдуулах” гэснийг “богиносгох” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “үүссэн үүргийн дагуу” гэснийг “тогтоосон” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “343 дугаар зүйлд заасан ажил гүйцэтгэх, мөн хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах” гэснийг “343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх болон хөлсөөр ажиллах гэрээ” гэж, 29 дүгээр зүйлийн 29.5.2 дахь заалтын “тусгай” гэснийг “тухайлсан” гэж, 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “хуулиар тогтоосон” гэснийг “хуулийн 25.1-д заасан” гэж, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 35.6 дахь хэсгийн

“Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Төв” гэснийг “Магадлалын төв” гэж тус тус өөрчилж, 44 дүгээр зүйлийн 44.6, 44.7 дахь хэсгийг 44.8, 44.9 дэх хэсэг болгон шилжүүлэх.

2.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “(цаашид “Итгэмжит зөвлөх” гэх), (цаашид “Зөвлөх” гэх) (цаашид “Тэргүүлэх” гэх)” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Одоо хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн буюу дагасан хуулийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох.

1 дүгээр зүйл.1994 оны 5 дугаар дугаар 31-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

1 дүгээр зүйлийг уншиж танилцууллаа. 1 дүгээр зүйлтэй холбоотойгоор үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйлийг уншиж танилцуулья.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль

/Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай.

1 дүгээр зүйл. 1994 оны 7 дугаар 5-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

Саналтай гишүүн байна уу? Уншиж сонсголоо.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйлтэй холбоотой үг, санал.

2 дугаар зүйлтэй холбоотой. Уншиж сонсголоо.

Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай. 2 зүйлтэй байгаа. 1, 2 дугаар зүйлтэй холбоотой.

1 дүгээр зүйлтэй холбоотой санал байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйлтэй холбоотой санал байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулья.

Нэг.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 2 дугаар зүйлийн “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Дипломат албан тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйлтэй холбоотой саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйлтэй холбоотой үг хэлэх гишүүн байна уу? Асуулт байна уу? Байхгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай.

1 дүгээр зүйл дээр. Байхгүй байна.
2 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал, асуулт байхгүй байна.
2 дугаар зүйл. Санал, асуулт байхгүй байна.
3 дугаар зүйл. Санал, асуулт байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй хоёр санал байгаа. Уншиж танилцуулья.

Хоёр.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1 дэх заалтын “0-16” гэснийг “0-18” гэж, 37.2.2 дахь заалтын “16” гэснийг “18” гэж, 37.2.2, 37.2.3 дахь заалтын “эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөл” гэж, 37.3 дахь хэсгийн “комисс” гэснийг

“зөвлөл” гэж, 37.4 дэх хэсгийн “37.2.1, 37.2.2-т” гэснийг “37.2.1-д” гэж, 37.5 дахь хэсгийн “37.2.1-37.2.3-т заасан комиссын” гэснийг “37.2.1, 37.2.2-т заасан зөвлөлийн” гэж, 37.9 дэх хэсгийн “комиссоос” гэснийг “зөвлөлөөс” гэж тус тус өөрчилсүгэй.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсгийн “37.2.2” гэснийг, 37 дугаар зүйлийн 37.5 дахь дэх хэсгийн “-37.2.3” гэснийг тус тус” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар дэмжигдлээ.

Дагасан хуулиа үргэлжлүүлэн танилцуулья.

Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Байхгүй байна.
2 дугаар зүйл. Байхгүй байна.
3 дугаар зүйл. Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг саналтай.

Гурав.Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “татварын өрөө барагдуулаагүй татвар” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өрөө

барагдуулаагүй татвар, шимтгэл” гэж, мөн заалтын “татварын” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн” гэж тус тус өөрчилсүгэй.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар дэмжигдлээ.

Найруулгын санал.

1.Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “73.1.4” гэснийг “73.1.4.а” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

3 дугаар зүйл дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

4 дүгээр зүйл дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Нэг зарчмын саналтай байна.

Дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйл болгох:

“3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн тайлбар хэсгийг хассугай.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 8.2, 8.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал, асуулт байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл. Санал, асуулт байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна.

Тав.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалтын “тэтгэвэр, тэтгэмжийн” гэснийг “тэтгэврийн” гэж өөрчилсүгэй.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

44.4 хувиар санал уналаа.

Д.Батлут гишүүн.

Д.Батлут: Дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалгаж өгнө үү.

П.Анужин: Д.Батлут гишүүний горимын саналаар саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн

саналын томъёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

Д.Батлут гишүүний гаргасан горимын санал 66.7 хувиар дэмжигдлээ.

Санал хураалтыг дахин явуулья. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

- 1 дүгээр зүйл. Байхгүй байна.
- 2 дугаар зүйл. Байхгүй байна.
- 3 дугаар зүйл. Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Уншиж танилцуулья.

Зургаа.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсэг,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Дагасан хуулиуд. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл дээр санал, асуулт байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр санал, асуулт байна уу? Байхгүй байна.

Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

- 1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
- 2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна.

Долоо.Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “гарчиг” гэснийг “нэрийн “ДААТГАЛЫН ТУХАЙ” гэснийг “ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ” гэж, мөн зүйлийн “45 дугаар зүйлийн 45.1.3” гэснийг “44 дүгээр зүйлийн 44.1.3” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

- 1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
- 2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна.

Найм.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “44 дүгээр зүйлийн 44.6-д” гэснийг “43 дугаар зүйлийн 43.5-д” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Дагасан хууль. Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэх үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “тухай” гэснийг хассугай.

Санал алга байна.

2 дугаар зүйл. Саналтай гишүүн байна уу? Алга байна.

Татварын өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Асуулт алга байна.

Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга.
2 дугаар зүйл. Асуулт, санал алга.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.

Эдийн засгийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.

2 дугаар зүйл. Санал алга байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.

Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.
3 дугаар зүйл. Санал алга байна.
Уншиж сонсголоо.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

1 дүгээр зүйл. Санал алга байна.
2 дугаар зүйл. Санал алга байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр

Улсын Их Хурлын гишүүн П.Анужинг томилж байна.

Гишүүддээ баярлалаа.

Өөрсдөө амаараа чухал чухал гэж хэлчихээд, тойрогтоо очихоороо энэ хуулиа урдаа барьж ярьчихаад, тэгээд энэ батлах явцад хариуцлагагүй хандаж байгаа гишүүд өөрсдөө доор бүрнээ юм бодно биз дээ. Тийм.

Энэ хуулийг хэлэлцүүлэх явцад идэвхтэй оролцож байгаа харьяа яамны сайд, Х.Булгантуяа сайд, С.Чинзориг сайд, Д.Батлут гишүүн, Д.Сарангэрэл гишүүн, Б.Саранчимэг гишүүн, Б.Жаргалмаа нарынхаа гишүүдэд баярлалаа.

Маш хүндэтгэлтэй хандаж, чухал саналаа оруулж байгаад баярлалаа.

Эхний хууль маань дууслаа. Ерөнхий хууль маань.

Ерөнхий яагаад ингээд их хурдтай сайн яваад байгаа юм бэ гэхээр ажлын хэсэг маань их сайн ажилласан юм. Яг хуулийн бичилтийн хувьд маш сайн ажилласан.

Найруулгын шинж чанартай засвар маш бага байгаа. Техникийн, ихэвчлэн хуульд нийцүүлсэн ийм олон зүйл байгаа. Мэдээж дагасан хууль олон.

Бид шинэ журмаараа дагасан хууль бүрийг зүйл заалтаар нь танилцуулдаг ийм журамтай болсон байгаа юм.

Тэгэхээр сайн бичилт хийгдэж, сайн орж ирсэн хууль шүү. Засгийн газар сайн оруулж ирсэн гэдгийг хэлье.

Мэдээж дотор байгаа зүйл,
заалттай холбоотой маргах олон
асуудлууд байгаа.

Багц хуулийнхаа хоёрдугаар хэсэг
орьё.

**Гурав.Нийгмийн даатгалын сангаас олгох
тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**

/Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Нийгмийн даатгалын сангаас тэтгэврийн
тухай хуулийн төслийн анхны
хэлэлцүүлгийг хийе.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй
холбогдуулан асуулт асуух гишүүд
нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд
байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал байхгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйтэй
холбогдуулан асуулт асууж, санал хэлэх
гишүүд нэрсээ өгнө үү?

2 дугаар зүйлтэй холбоотой
зарчмын зөрүүтэй нэг санал байгаа юм
байна. Уншиж танилцуулья.

1.Төслийн 2 дугаар зүйлд доор
дурдсан 2.1.6 дахь хэсэг нэмэх:

“2.1.6.”хүндэтгэн үзэх
шалтгаан” гэж Татварын ерөнхий
хуулийн 6.1.41-д заасныг.”

Санал гаргасан Улсын Их Хурлын
гишүүн П.Анужин, Ж.Батжаргал,
С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа,
Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил,
М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир,
Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг.
Цаашид “Ажлын хэсэг” гэх. Санал
хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй
холбоотойгоор асуулт асууж, үг хэлэх
гишүүд байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал
байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг
уншиж танилцуулья.

2.Төслийн 2 дугаар бүлгийн
гарчгийн ”ТОГТОЛЦОО” гэснийг
“ТӨРӨЛ” гэж өөрчилж, төслийн 3 дугаар
зүйлийг 4 дүгээр зүйл болгон доор
дурдсанаар өөрчлөн найруулах:

**“4 дүгээр зүйл.Хувийн нэмэлт
тэтгэвэр**

4.1.Нийгмийн даатгалын ерөнхий
хуулийн 4.1.2-т заасан даатгуулагч
хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт
хамрагдаж нэмэлт тэтгэвэр авч болно.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан
тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт
тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

4 дүгээр зүйл дээр саналтай
гишүүд байна уу? Саналтай гишүүн алга.
Асуулт алга.

Зарчмын зөрүүтэй хоёр санал байгаа. Танилцуулья.

3.Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон дугаарыг өөрчилж зүйлийн гарчгийн “тэтгэвэр” гэснийг “тэтгэврийн төрөл” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

5 дугаар зүйл. 5 дугаар зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Байхгүй бол зарчмын зөрүүтэй саналаа танилцуулья.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсгийн “55” гэснийг “50” гэж, “50” гэснийг “45” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.1.4 дэх заалтад хамаарах тайлбарыг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Энэ санал Д.Батлут гишүүний аймаг, орон нутагтаа хуулийн төслийг танилцуулж ажиллаж байхад, мөн зөвхөн өөрийнхөө сонгогдсон аймаг, орон нутаг гэхгүй нийт энэ хүнд нөхцөлд ажиллаж байгаа нийт ажилчин, албан хаагчдын саналыг нэгтгэж, ажлын хэсэг дээр үнэтэй санал өгсөн. Энэ санал нь дэмжигдсэн гэдгийг би бас энд тодруулж хэлье.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

6 дугаар зүйлтэй холбоотой санал хэлэх гишүүн байна уу? Үг байна уу? Байхгүй бол зарчмын зөрүүтэй нэг саналаа танилцуулья.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Даатгуулагч” гэснийг

хасаж, “төрсөн,” гэсний дараа “мөн энэ хуулийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, 5.1.7-д заасан даатгуулагч” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

7 дугаар зүйл.Өндөр насны тэтгэврийн хэмжээг цалинд үндэслэсэн аргаар бодох гэж байгаа. Энэ дээр асуулттай гишүүд байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

8 дугаар зүйтэй холбоотой гишүүдээс санал байна уу? Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Зарчмын зөрүүтэй саналаа танилцуулья.

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн томъёоны “НД_{с2}” гэснийг “НД_{с3}” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

9 дүгээр зүйлтэй холбоотойгоор санал, үг байна уу? 9 дүгээр зүйлтэй холбоотойгоор Содномын Чинзориг сайд санал хэлнэ.

С.Чинзориг: Энэ 9 дүгээр зүйл дээр шинээр тэтгэврийн тусгай зохицуулалт гэж оруулж ирж байгаа юм байна.

9.1.2 дээр тэр 10 ба түүнээс дээш жил хамт амьдарсан бол гээд. Тэгээд амьд сэрүүн үлдсэн нэгэнд нь энэ тэтгэврийнх нь 20 хувьтай тэнцүү хэмжээний нэмэгдэл олгох юм байна л даа.

Би энэ 10 жил гэдгийг яаж тооцсон юм бэ гэж түрүүнээс хойш асуугаад байгаа юм.

Монголчууд бид уламжлалт гэр бүлийн харилцаатай ийм ард түмэн. Тэр утгаараа хоёр хөгшин олон жил хамт амьдарч байвал сайн л хэрэг. Бат бэх гэр бүлийг дэмждэг ийм л уламжлалтай ард түмэн шүү дээ. Тэр утгаараа энэ хоёр хөгшин хүн хамтдаа 20, 30 жил, 40 жил хамт амьдарч байвал сайн л байгаа юм.

Тэгээд энэ 10 жил хамт амьдарсан бол тэтгэврийн 20 хувийг нь өгөөд. Би тэр 10 жил гэдэг нь бага байна л гэж байгаа юм.

Бид тийм бат бэх гэр бүлийг л дэмжиж байгаа шүү дээ. Тэр утгаараа энэ 10 жил нь бага байна. Үүнийг ядаж 20 жил болгох хэрэгтэй гэсэн ийм байр суурьтай байгаа. Тэгээд би зарчмын зөрүүтэй саналын томьёолол бэлдэж бичиж өгсөн. Үүнийг бас хэлэлцүүлээд, санал хураалгаад шийдэх тийм бололцоо нь юу байна вэ гэж.

Би 10 жил гэдэг арай л бага байна гэж. 10 жил гэдэг чинь одоо тэр уламжлалт гэр бүлийн харилцааг дэмжиж байгаа. Гэр бүл одоо тийм бат бэх, тогтвортой байх тэр бодлогыг дэмжиж байгаа тийм ч бодлого биш шүү дээ. Ядаж 20 жил хамт амьдарсан байх гэдэг ийм нөхцөл тавих нь илүү оновтой гэсэн бодолтой байгаа юм.

П.Анужин: Хэлэлцэгдэж байгаа зүйлтэй холбоотойгоор С.Чинзориг зарчмын зөрүүтэй санал гаргалаа.

Саналын томьёоллыг Та бүхэндээ. С.Чинзориг сайд маань өөрөө ажлын хэсгийн гишүүн.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэндээ уншиж танилцуулья.

Хуулийн “9.1.2-т “10” гэснийг “20” гэж өөрчлөх. Сая өөрсдөө танилцууллаа.

Санал гаргасан ажлын хэсгийн гишүүн С.Чинзориг. Санал хураалт. /алх цохив/

10 жилийг 20 жил болгоё гэж байна.

Санал хураалт дэмжигдсэнгүй.

10 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

11 дүгээр зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

12 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

13 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

14 дүгээр зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

15 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

16 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

17 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

18 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

19 дүгээр зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

20 дугаар зүйл. Уг зүйлтэй холбоотой асуулт, санал байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг саналаа танилцуулья.

7.Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал уналаа. Б.Саранчимэг гишүүн горимын санал гаргая.

Б.Саранчимэг: Би уг нь сая дэмжиж санал өгсөн чинь энэ техник ажилласангүй. Энэ саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулья.

П.Анужин: Б.Саранчимэг гишүүний гаргасан горимын саналаар саяын уншсан санал хураалтыг хүчингүй болгох гэсэн томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт. /алх цохив/

Б.Саранчимэг гишүүний гаргасан санал 66.7 хувиар дэмжигдэж, уг санал хүчингүй боллоо.

20 дугаар зүйл дээр санал хураалт явуулья. Зарчмын зөрүүтэй нэг санал дээрээ. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

21 дүгээр зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

22 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

23 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

24 дүгээр зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

25 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

26 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

27 дугаар зүйл. Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх. Асуулт, санал байна уу? Байхгүй бол зарчмын зөрүүтэй нэг саналыг Та бүхэндээ танилцуулья.

8.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “04” гэснийг “01” гэж өөрчлөн, мөн зүйлд доор дурдсан 27.2 дахь хэсэг нэмэх:

“27.2.Энэ хуулийн 27.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлалыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

28 дугаар зүйл. Асуулт, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

29 дүгээр зүйл Асуулт, санал байна уу? Байхгүй байна.

Ажлын хэсэг дээр гишүүд саналаа нэгтгэсэн. Хоёр зарчмын зөрүүтэй санал ирсэн.

9.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.1.Энэ хуулийн 27.1 дэх хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан 29.3 дахь хэсэг нэмж, 29.3 дахь хэсгийн дугаарыг “29.4” болгож, мөн хэсгийн “25.1-д” гэснийг “25.1, 29.3-т” гэж өөрчлөх.

“29.3.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө дараалсан зургаа, долоон жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний хүсэлтэд үндэслэн энэ хуулийн 20.1-д заасны дагуу нэг удаа өөрчлөн бодно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

30 дүгээр зүйл Асуулт, санал байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Уншиж танилцуулья.

11.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Одоо уг хуулийг дагасан хууль буюу хамт өргөн мэдүүлсэн 24 хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Түрүүн 50 дагасан хууль байсан.

Дагасан хуулийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай.

Гишүүд ээ, нэг зүйл дээр Б.Пүрэвдорж гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулах шаардлагатай байна. Мөн ажлын хэсэг дэмжсэн. Ажлын хэсэг Б.Пүрэвдорж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн.

Б.Пүрэвдорж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулья.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийг суурь болгож Б.Пүрэвдорж нарын гишүүдээс өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгтгэн хэлэлцэх.

Энэ томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар Б.Пүрэвдорж гишүүний гаргасан санал Байнгын хороогоор дэмжигдлээ.

Дагасан хуулиуд руугаа орьё. Гишүүд ээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсон тооцох тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

Нэг.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай

1.Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,” болон “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар дэмжигдлээ.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

Хоёр.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай

1.Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/”, гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байна уу?

Цэндийн Мөнх-Оргил гишүүн уг зүйлтэй холбоотойгоор зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байна.

Саналыг Та бүхэндээ уншиж танилцуулья.

Саналын томъёолол. Хуулийн төслийг төсөл санаачлагчид буцаах гэсэн зарчмын зөрүүтэй саналыг гаргасан байна. Хуулийн төслийг уншаад танилцуулчихья.

“Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнд өндөр насны тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тогтоож, олгоно.”

Үүн дээр яамны тайлбарыг сонсьё. 4 номерын микрофонд А.Хишигбаяр дарга хариулья. Ц.Мөнх-Оргил гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал.

Энэ цэцийн асуудалтай холбоотойгоор яамны саналыг сонсьё. Хууль санаачлагч. 4 номыер микрофон А.Хишигбаяр дарга хариулт өгье.

А.Хишигбаяр: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулья.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дээр Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн тэтгэврийг 60 хувиар тооцно гэж оруулж ирсэн. Батлагдаад хэрэгжээд явж байгаа.

Нийгмийн даатгалын тогтолцоо, хуулийн гол концепцийг бүгд ижилхэн, тэгш эрхтэй байх ёстой гэдэг агуулгаар бүгд ижилхэн хувь хэмжээнээс тэтгэвэрээ тогтоолгох нь зүйтэй гэдэг байдлаар өөрчлөн оруулж ирж байгаа.

П.Анужин: Ц.Мөнх-Оргил гишүүн саналаа тайлбарлая.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Тийм санаа байгаа. Би тэрийг ойлгож байгаа. Ер нь дэмжиж байгаа.

Тэгэхдээ энэ дээр ийм юм байгаа байхгүй юу. Монгол төр чинь өөрөө төрийн эрх мэдлийг гурав хуваагаад салгаад хэрэгжүүлж байгаа байхгүй юу. Гурвуулаа яг адилхан эрхтэй. Хууль тогтоох нь Улсын Их Хуралдаа, шүүх эрх мэдэл нь шүүхдээ, гүйцэтгэх засаглал нь Засгийн газар нь. Ингээд гурав тусдаа явж байгаа юм.

Тэгээд шүүх эрх мэдэл дотор чинь шүүх нь ороод, цэц нь ороод, тэгээд үндсэндээ прокурор бас ингээд ороод явчихаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр эд нарт тогтоосон тэр онцгой, арай өөр дэг байна шүү дээ. Прокурор, шүүхийн байгууллага дээр 25 жил ажилласан бол өөрөө хүсэлтээр гарч болно гэсэн ерөөсөө л тэр зохицуулалт байгаа шүү дээ. Өөр бусад ялгаад байгаа юм байхгүй.

Тэгэхээр үүнийг яг хууль тогтоох эрх мэдэл, шүүх эрх мэдэл хоёр яг ижил тэнцүү хоёр байхгүй юу. Тэгээд энэ тэтгэврийн онцгой нөхцөл тогтооно гэдэг чинь энэ хоёр хоорондоо ярьж тохирч хийдэг асуудал байхгүй юу. Түүнээс биш одоо юу гэдэг ингээд л танайх заавал тэгнэ гээд л Улсын Их Хурал дангаараа шийдчихдэг асуудал бас биш байхгүй юу. Харилцан хүндэтгэлтэй ханддаг.

Ялангуяа бие биенийхээ эрх мэдэл рүү нь орж байгаа, бие биенийхээ одоо юу гэдэг юм, харилцан ойлголцож тогтоосон тэр хувилбар бид барьж үлдэж байх ёстой байгаа юм.

Төрийн алба мөн. Тэгэхдээ төрийн тусгай алба байхгүй юу. Тэр утгаар нь

харж, ойлгож үзэх хэрэгтэй байгаа юм. Гишүүд ээ.

Тэгээд одоо яг өнөөдрийнхтэй адилхан 45 хувиар цэцийн гишүүдийг тогтоолгоод явна гэх юм бол цэцтэй тохирсон тохиролцоо чинь, прокурортой тохирсон тохиролцоо, тэр баланс барьж энэ хуулиудыг чинь хийж байгаа шүү дээ. Энэ тэнцвэр чинь алдагдах гээд байгаа юм.

Тийм учраас энэ гурван байгууллагын хувьд онцгой тэр субъектынх нь хувьд харж үзэх ёстой гэж би бодоод байгаа юм.

П.Анужин: Хууль санаачлагч өөрийнхөө тайлбарыг хийлээ.

Цэндийн Мөнх-Оргил гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/ Саналыг дэмжих эсэх дээр санал хураалт явуувж байна.

Ц.Мөнх-Оргил гишүүний гаргасан санал дэмжигдсэнгүй.

Дагасан хууль танилцуулья. Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

3 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй саналтай.

Гурав.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар” гэж, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-т” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д” гэж, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж, 24 дүгээр зүйлийн “нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн “3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас

олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/" гэснийг "4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө." гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Дагасан хууль. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйлтэй холбоотойгоор Ц.Мөнх-Оргил гишүүн зарчмын зөрүүтэй саналыг оруулж ирсэн байна.

Ц.Мөнх-Оргил гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулья.

Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах.

2 дугаар зүйлийг Та бүхэндээ уншиж танилцуулья. Нийтэд нь юм байна. Нийтэд нь хууль санаачлагчид буцаах гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасан байна.

Санал хураалт. /алх цохив/

Энэ санал хураалтыг түр түдгэлзүүлье. Тайлбар хийе.

Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай дагасан хуультай холбогдуулж Цэндийн Мөнх-Оргил гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан. Зарчмын зөрүүтэй санал нь хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасан. Энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. Гишүүд ээ.

Цэндийн Мөнх-Оргил гишүүний зарчмын зөрүүтэй гаргасан санал 55.6 хувиар дэмжигдлээ.

3 дугаар зүйлтэй холбоотой санал байна уу? Байхгүй байна.

Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн. Зарчмын зөрүүтэй саналыг Цэндийн Мөнх-Оргил гишүүнээс

ирүүлсэн. Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулья.

Хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай

1 дүгээр зүйл дээр асуулт, санал байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр асуулт, санал байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн.

Дөрөв. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай

1.Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/”, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт, санал байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйлтэй холбоотой асуулт, санал байна уу? Байхгүй байна.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга байна.

Зарчмын зөрүүтэй ажлын хэсгээс оруулж ирсэн нэг санал байна.

Тав. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хуульд” гэснийг “хуулийн” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/”, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга байна.

Монгол Улсын Их Хурлын тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга
байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга
байна.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын
зөрүүтэй санал байна.

Зургаа. Монгол Улсын Их Хурлын
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

**1. “Монгол Улсын Их Хурлын
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”
хуулийн төслийг төсөл санаачлагчид
нь буцаах.**

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Эрүүл мэндийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга
байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга
байна.

Зарчмын зөрүүтэй санал мөн
ирээгүй.

Өршөөл үзүүлэх тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга
байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга
байна.

Өршөөл үзүүлэх тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга
байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга
байна.

Нийгмийн халамжийн тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Асуулт, санал алга
байна.

2 дугаар зүйл. Асуулт, санал алга
байна.

3 дугаар зүйл. Асуулт, санал алга
байна.

4 дүгээр зүйл. Асуулт, санал алга
байна.

Зарчмын зөрүүтэй санал байна.
Уншиж танилцуулья.

Долоо. Нийгмийн халамжийн
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай

1. Төслийн 2, 3 дугаар зүйлийг
нэгтгэн холбогдох техникийн засварыг
хийж, төслийн 2 дугаар зүйлийн “дараах
заалтыг” гэснийг “дараах хэсэг, заалтыг”
гэж, “өөрчилсүгэй.” гэснийг “өөрчлөн
найруулсугай.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Алдар цолтон ахмад настанд
төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр асуулт, үгтэй
гишүүн байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр мөн байхгүй
байна.

3 дугаар зүйл. Санал, асуулт, үг
ирээгүй.

Төрийн хяналт шалгалтын тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Үг, саналтай
гишүүн байхгүй байна.

2 дугаар зүйл. Үг, саналтай
гишүүн алга байна.

Тэтгэврийн хуультай
холбоотойгоор Бөхчулууны Пүрэвдорж
гишүүнээс зарчмын зөрүүтэй санал
ирсэн.

Зарчмын зөрүүтэй саналыг уншиж
танилцуулья.

Энэ хуулийг дагаж мөрдөхөөс
өмнө дараалсан 6, 7 жилийн цалин хөлс,
түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр
авагчийн тэтгэврийг түүний хүсэлд
үндэслэн энэ хуулийн 20.1-д заасны дагуу
нэг удаа өөрчлөн бодож, зөрүүг буцаан
олгоно гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал
оруулж ирж байна.

Санал гаргасан Бөхчулууны
Пүрэвдорж гишүүн өөрөө тайлбараа
хийе. Б.Пүрэвдорж гишүүн гаргасан
зарчмын зөрүүтэй санал дээрээ тайлбараа
хийе.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Олон
Улсын Валютын Сан 2016 онд манай
Засгийн газар Валютын сангийн
хөтөлбөрт хамрагдаж хэд хэдэн үүрэг
авсан.

Тэгээд 2018 онд Олон Улсын
Валютын Сан Монголоос хөтөлбөрөө
зогсоогоод гарсан.

Тэгээд тэр хөтөлбөрийн дагуу
нэлээн олон асуудлуудыг шийдэж байсан,
санхүүгийн асуудал дээр үүрэг хүлээн
боловч түүнээсээ гарангуут больсон.

Тэндээс ерөөсөө ганцхан үлдсэн
зүйл нь энэ тэтгэврийг 7 жил, цаашлаад
10 жил хүртэл бодуулах энэ заалт байсан
юм.

Энэ заалтын уршгаар өнөөдөр 7
жилээр бодуулсан хүмүүс тэтгэвэр
авахдаа ойролцоогоор 250-иас 300 мянган
төгрөгийн зөрүү алдаад байгаа.

Тийм учраас 2018 оноос хойш
тэтгэвэрт гарсан, 7 жилээр бодуулсан тэр
хүмүүсийг түрүүн санал хураагаад нэг
удаа нөхөж бодохоор ажлын хэсгийн
санал дэмжигдсэн байгаа.

Түүн дээр би юу нэмсэн бэ гэхээр
нэг удаа нөхөн бодож, зөрүүг буцаан
олгоно гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ
төрийн буруутай үйл ажиллагаанаас болж
хохирсон иргэд энэ зурвас хугацаанд
өөрсдийнхөө авах ёстой тэр тэтгэврийг
авч чадахгүй хохирсон нь тэдний буруу
биш юм. Энэ буруу бодлогоо Нийгмийн
даатгалын багц хуулиараа засаж байгаа.

Тэгэхээр энэ засаж байгаа учраас
тэр хүмүүс энэ хэсэг хугацаанд хохирч
үлдэх ёсгүй учраас энэ зөрүүг нь заавал
буцааж олгох ёстой гэдэг ийм зүйлийг
хэлж байгаа.

Хөдөө орон нутгаар П.Анужин
гишүүн Нийгмийн даатгалын багц
хуулиар иргэдтэй уулзалт хийгээд нэлээн
явсан.

Ер нь Их Хурлын гишүүд хөдөө,
орон нутагт очиход ер нь энэ 7 жилийг 5
жил болгох тухай ярьдаг. Тэгээд тэр 7
жилээр бодуулаад хохирсон хүмүүс энэ
зөрүүгээ буцааж авах тухай л хамгийн
гол нь ярьдаг байхгүй юу даа.

Тэгэхээр энэ асуудлыг нь энэ
заалтыг оруулж өгснөөр, зөрүү олгоно
гэж шийдэж өгснөөр асуудлыг бүрэн,

одоо ямарваа нэгэн асуудалгүй, иргэд гомдолгүй, ахмад буурлууд маань Нийгмийн даатгалын багц хууль дээр сэтгэл хангалуун үлдэх ийм боломжийг бүрдүүлж байгаа юм.

Тийм учраас Байнгын хорооны гишүүд та бүхэн энэ зөрүүг олгох энэ заалт дээр дэмжиж саналаа өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

Ц.Анужин: Байнгын хорооны гишүүд ээ,

Б.Пүрэвдорж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал нь түрүүн бид хураагаад дууссан. Нэг удаа бид тэтгэврийнх нь зөрүүг гаргаж бодно гээд тэр хүртэл нь бид хураачихсан байгаа.

Б.Пүрэвдорж гишүүний оруулж ирж байгаа дээр зөрүүг буцааж олгоно гэсэн байгаа. Хэрвээ Б.Пүрэвдорж гишүүний санал дэмжигдвэл түрүүний бидний хураасан санал унана гэсэн үг. Хүчингүй болно гэсэн үг.

Санал хураалт. Зөрчилдөж байгаа юм. Энэ хоорондоо. Ажлын хэсгийн оруулж ирсэн санал байхгүй юу.

Санал хураалт явуулья. Гишүүд ээ. /алх цохив/

Б.Пүрэвдорж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмааг томилж байна.

Хоёр дахь хуулийг хэлэлцэж дууслаа.

**Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох
тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**
/Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Багц хуулийн маань гурав дахь хэсэг. Одоо гурав. Цаана нь дөрөв, тав гээд хоёр хууль байгаа.

Одоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Зарчмын зөрүүтэй 9 санал байгаа.

Би ахин хэлье. Ялангуяа энэ хуулийг бичсэн, өргөн барьсан энэ хүмүүс маань, ялангуяа мэргэжлийн

яамны мэргэжилтнүүд маань энэ хууль дээр 2006 оноос хойш ажиллаж байгаа.

Тэгээд ерөөсөө хэлэлцэгдээд л, орж ирээд дэмжигдэхгүй. Хамгийн гол зүйл нь ерөөсөө л энэ санхүү, төсвийн эх үүсвэр байсан. Энэ шийдэгдэх боломжгүй гээд буцаагдаад байсан.

Тэгэхдээ эдгээр хүмүүс маань 2006 оноос тууштай ажиллаж байгаа ийм баг байгаа. Тийм ч учраас найруулгын шинж чанартай санал, засвар маш бага.

Ер нь олон жил харьяа яам маань яг хуулийн бичилтийн хувьд, концептын хувьд сайн бичсэн. Үүнийг ажлын хэсгийн ахлагчийн хувьд хэлэхээр байна.

Тийм учраас нэг доор хэлэлцэж байгаа олон хууль учраас урт боловч яг хуулиар нь аваад үзвэл ийм том найруулгын шинжтэй, утга санаа эвдсэн ийм зүйл бага байна гэдгийг Та бүхэн мэдэж байгаа байх.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй нэг санал ирүүлсэн.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрх үүсэх нөхцөл, хэмжээ, хугацаа,” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг. Цаашид “Ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

2 дугаар зүйлийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж, хөнгөлөлт, шимтгэлийн хөтөлбөр гэсэн байгаа. Энэ зүйлтэй холбоотой асуулт, санал байна уу? Байхгүй байна.

Ажлын хэсгээ зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн.

2.Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн “хөнгөлөлт” гэсний дараа “, шимтгэлийн төлбөр” гэж нэмж, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн “тэтгэмжийг” гэснийг “тэтгэмж, шимтгэлийн төлбөрийг” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.1.4 дэх заалт нэмэх:

“2.1.4.гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн төлбөр.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

3 дугаар зүйл.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх. Үг, санал байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй.

4 дүгээр зүйл.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж гэсэн ийм зүйл байгаа. Энэ зүйтэй холбоотой санал, үг байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн. Зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулья.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, мөн хэсгийн “3-60” гэснийг “3-59” гэж, “61-120” гэснийг “60-119” гэж, “121-180” гэснийг “120-179” гэж, “181” гэснийг “180” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

5 дугаар зүйл дээр асуулт, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал ажлын хэсэг, гишүүдээс ирээгүй.

6 дугаар зүйл дээр асуулт, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

7 дугаар зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн байна. Үг хэлж, асуулт асуух гишүүн байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй саналаа уншиж танилцуулья.

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

8 дугаар зүйлтэй холбоотой үг хэлж, асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй болно.

9 дүгээр зүйлтэй холбоотойгоор санал байна уу? Асуулт байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн. Зарчмын зөрүүтэй саналаа уншиж танилцуулья.

5.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Энэ зүйлийн 9.1-д заасан нөхцөлийг” гэснийг хасаж, мөн хэсгийн “нөхцөлийг” гэснийг “эрхийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

10 дугаар зүйлтэй холбоотой асуулт байна уу? Үг байна уу? Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн. Зарчмын зөрүүтэй саналаа уншиж танилцуулья.

6.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан” гэснийг “Даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмжийг түүний шимтгэл төлсөн хугацааг харгалзан ажилгүй болохын өмнөх шимтгэл төлсөн” гэж, мөн хэсгийн “24-60” гэснийг “24-59” гэж, “61-120” гэснийг “60-119” гэж, “121-180” гэснийг “120-179” гэж, “181” гэснийг “180” гэж, мөн зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

11 дүгээр зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй хоёр саналаа танилцуулья.

7.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хүсэлтээ” гэснийг “хүсэлт, ажил идэвхтэй хайж байгаа тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын тодорхойлолт болон” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

12 дугаар зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

13 дугаар зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

14 дүгээр зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

15 дугаар зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

16 дугаар зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

17 дугаар зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

18 дугаар зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

19 дүгээр зүйл дээр асуулт, үг байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн. Уншиж танилцуулья.

9.Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Одоо хуультай хамт өргөн мэдүүлсэн болон дагасан хуулийн төслийг зүйл хэлэлцэнэ.

Дагасан хуулийг танилцуулья. Хамт өргөн мэдүүлсэн хуулийг.

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай

1 дүгээр зүйл дээр асуулт, үг байна уу? Уншиж сонсголоо.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль Шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Асуулт, санал байхгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

3 зүйлтэй. 1 дүгээр зүйл дээр санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр санал алга байна. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Уншиж танилцуулья.

Нэг.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

3 дугаар зүйлтэй холбоотой санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй болно.

Тэтгэмжийн доод хэмжээг тогтоох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай

1 дүгээр зүйл. Асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл. Асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат гишүүнийг томилж байна.

Тав.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

/Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Багц хуулийн маань дөрөв дэх хуулийг хэлэлцье. Гишүүд ээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Нийт 21 санал, найруулгын 1 санал байгаа.

Хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй.

Хуулийн 2 дугаар зүйтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй.

Хуулийн 3 дугаар зүйтэй холбоотой үг хэлэх, асуулт асуух гишүүн байна уу? Нэрээ өгөөрэй. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй хоёр саналыг танилцуулья.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дахь хэсэг, мөн зүйлийн 3.1.3, 3.1.5 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1. Даатгуулагч дараах нөхцөл байдалд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:”

3.1.3. ажлын цагаар ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд ажил үүргээ гүйцэтгэхээр явж байх үед;

3.1.5. ажилдаа ирэх, буцах зам, ажил үүргийн дагуу сургалтад оролцох болон Хөдөлмөрийн тухай хуулийн 93.1.1-д заасан амрах, хооллох завсарлагын үед;”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг. Цаашид “Ажлын хэсэг” гэх. Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “ноцтой” гэснийг хасаж, 3.1.8 дахь заалтын “зэрэглэлтэй дотоодын спортын тэмцээн, уралдаанд” гэснийг “хэмжээний спортын тэмцээнд” гэж, 3.2 дахь хэсгийн “тохиолдолд үйлдвэрлэлийн осолд тооцохгүй” гэснийг “нь нотлогдсон тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй” гэж, 3.3 дахь хэсгийн “ослыг” гэснийг “осол, хурц хордлогыг” гэж, 3.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

4 дүгээр зүйлтэй холбоотойгоор үг хэлэх, санал хэлэх гишүүд нэрсээ өгөөрэй. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

5 дугаар зүйлтэй холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй хоёр саналыг ирүүлсэн байгаа.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас” гэснийг “дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос” гэж, 5.3 дахь хэсгийн “Эрүүл мэндийн магадлалын” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан” гэж, мөн зүйлийн 5.4 дэх хэсгийн, 5.4.1, 5.4.2, 5.4.3 дахь заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, 5.4.1 дэх заалтын “дундаж” гэснийг “нийлбэрийг 12-т хуваасан” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.5.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд хөдөлмөр эрхэлж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар, 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 0.167 хувиар тооцон тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

6 дугаар зүйлтэй холбоотой үг хэлэх гишүүдийн нэрсийг авья. Санал, үгтэй гишүүн байхгүй байна. Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн байгаа. Уншиж танилцуулья.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “6 сарын дотор” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

7 дугаар зүйл дээр үг хэлж, санал хэлэх гишүүдийн нэрсийг авья. Саналтай гишүүн байхгүй байна. Зарчмын зөрүүтэй нэг саналыг ажлын хэсгээс ирүүлсэн. Уншиж танилцуулья.

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “17.1-д” гэснийг “16.1-д” гэж, мөн зүйлийн 7.3, 7.4 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж, 7.7 дахь хэсгийн—“тэтгэврийн ердийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

8 дугаар зүйлтэй холбоотой санал, үг байвал нэрээ өгье. Байхгүй бол зарчмын зөрүүтэй нэг санал ажлын хэсгээс оруулж ирсэн. Ажлын хэсгийн саналыг танилцуулья.

7.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “6.1.1-д заасан хэмжээтэй” гэснийг “21.1.1, 21.2-г заасан хэмжээтэй тус тус” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

9 дүгээр зүйл дээр үг, саналтай гишүүд байна уу? Байхгүй бол зарчмын зөрүүтэй нэг санал ажлын хэсэг оруулж ирсэн. 9 дүгээр зүйлийг уншиж танилцуулья.

8.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсгийн, 9.3.2, 9.3.3 дахь заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, 9.3.1 дэх заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “дундаж цалин хөлс” гэж, мөн заалтын “дундаж” гэснийг “нийлбэрийг 3-т хуваасан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн “Даатгуулагчийн” гэсний дараа “тэтгэмж бодох” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

10 дугаар зүйл дээр үг хэлж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй. Зарчмын зөрүүтэй санал мөн ажлын хэсгээс ирээгүй байна. Тийм ээ.

11 зүйл. Санал, үг байна уу? Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн байна. Уншиж танилцуулья.

9.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “/байцаагч/-д” гэснийг, 11.2 дахь хэсгийг “/байцаагч/ гэснийг тус тус хасаж, 11.1.3 дахь заалтын “мэргэжлийн” гэснийг “хөдөлмөрийн” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

12 дугаар зүйл дээр үг хэлэх гишүүдийн нэрсийг авья. Нэрс ирээгүй байна. Зарчмын зөрүүтэй нэг саналтай. Саналыг уншиж танилцуулья.

10.Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “Шимтгэлийн” гэснийг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн” гэж өөрчилж, мөн хэсгийн “хэмжээгээр тооцож” гэсний дараа “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

13 дугаар зүйл дээр үг хэлж, санал хэлэх гишүүдийн нэрсийг авья. Байхгүй бол зарчмын зөрүүтэй ирсэн нэг саналыг танилцуулья.

11.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “даатгалын” гэсний өмнө “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмж, 13.3 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

14 дүгээр зүйлтэй холбоотой үг хэлэх гишүүдийн нэрсийг авья. Алга байна. Зарчмын зөрүүтэй хоёр санал ирсэн байна. Уншиж танилцуулья.

12.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7, 14.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно:”

14.7.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.9.Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар дэмжигдлээ.

13.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний” гэснийг “сэргээн засах болон” гэж, 14.1.3 дахь заалтын “рашаан,” гэснийг “сэргээн засах төв болон” гэж, мөн зүйлийн 14.2 дахь хэсгийн “Даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг нийгмийн даатгалын” гэснийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас

олгох протез, ортопедийн жишиг үнийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж, 14.3 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид протез” гэснийг “Протез” гэж, мөн зүйлийн 14.5 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч” гэснийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч” гэж, 14.6 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид” гэснийг “Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас сэргээн засах төв болон” гэж, мөн зүйлийн 14.8 дахь хэсгийн “Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний” гэснийг “Сэргээн засах болон” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

15 дугаар зүйлтэй холбоотой үг хэлэх гишүүд байвал нэрс авья. Байхгүй бол зарчмын зөрүүтэй нэг саналыг Та бүхэндээ уншиж танилцуулья.

14.Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн” гэснийг “хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан” гэж, мөн хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 15.7 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

44.4 хувиар унасан байна.

Би өөрөө горимын санал гаргая. Миний товчлуур ажиллаагүй байна. Саяын саналыг хүчингүй болгох

томьёоллоор санал хураалт явуулж өгнө үү. Санал хураалт.

Миний гаргасан горимын санал 77.8 хувиар дэмжигдлээ.

Түүний санал хураалтаар ахин санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар санал дэмжигдлээ.

16 дугаар зүйлтэй холбоотой гишүүд санал, нэрээ өгнө үү. Байхгүй бол зарчмын зөрүүтэй хоёр саналыг Та бүхэнд танилцуулья.

15.Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бөгөөд” гэсний дараа “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмж, 16.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 16 дугаар зүйлийн 16.3.2 дахь заалтыг хасах:

“16.3.1.ажил олгогчийн шимтгэл төлөлт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон ажил олгогчид үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо, холбогдох бусад мэдээллийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 16 дугаар зүйлийн 16.3.3 дахь заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “хөдөлмөр, халамж үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, мөн зүйлийн 16.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын болон

мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

17 дугаар зүйл дээр үг хэлж, санал хэлэх, асуулт асуух гишүүдийн нэрсийг авья. Байхгүй байна. Мөн зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

18 дугаар зүйл дээр үг хэлж, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй.

19 дүгээр зүйлтэй холбоотой санал хэлж, үг хэлэх гишүүн байна уу? Нэрээ өгье. Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулья.

17.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын 2 санал байна. Найруулгын саналыг уншиж танилцуулья.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “биелүүлэх үед” гэснийг “гүйцэтгэх явцад” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “авах өргөдөл

гаргахад” гэснийг “тогтоолгоход” гэж, 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийн “авах өргөдөл гаргахад” гэснийг “авахад” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “/байцаагч/” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Одоо хуулийн хамт өргөн мэдүүлсэн 3 хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Дагасан хууль.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Дагасан хуулийг гишүүддээ танилцуулья.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль хүчингүй болсон тооцох тухай

1 дүгээр зүйл. Санал, үгтэй гишүүн байна уу?

2 дугаар зүйл. Байхгүй байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй ажлын хэсгийн нэг санал танилцуулья.

Нэг.ХӨДӨЛМӨРИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ

1.Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Дагасан хуулийг танилцуулья.

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйлтэй холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр үг хэлж, асуулт асуух гишүүн байхгүй байна. Зарчмын зөрүүтэй нэг санал ирсэн.

Хоёр.ТӨРИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1.Төслийн нэрийн “ХУУЛЬД” гэсний дараа “НЭМЭЛТ,” гэж, 2 дугаар зүйлийн ““хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж” гэсний дараа “, ““тахир дутуугийн тэтгэвэр” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр” гэж тус тус” нэмж, 1 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “заасныг хэрэгжүүлнэ” гэснийг “заасан мэдээллийг бүрдүүлнэ” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

3 дугаар зүйл дээр асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй бол 3 дугаар зүйлтэй холбогдуулж ажлын хэсэг зарчмын зөрүүтэй санал ирүүлсэн байгааг танилцуулья.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутыг томилж байна.

Ц.Мөнх-Оргил гишүүн горимын санал гаргасан. Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ багц хуультай холбоогүй.

Тэгэхдээ манай Байнгын хороогоор эхний асуудал болгоод

өнөөдөр Хянан шалгах түр хороо байгуулах тогтоолын төслийг хэлэлцсэн юм байна.

Тэгээд яах вэ, Хянан шалгах түр хороо байгуулж болно. Тэгэхдээ үүнийг протоколд тэмдэглүүлээд янзалчихмаар байх юм. Ийм үг, үсэгтэй, ийм монгол хэлтэй, ийм найруулгатай тогтоол манай Байнгын хороо баталж болохгүй ээ. Г.Нямсүрэн, П.Анужин.

Энэ чинь зүгээр нэг дөнгөж хэлд орж байгаа юм уу, бичиг үсэгтэй болж байгаа хүн хоёрдугаар анги юм уу, гуравдугаар ангийн хүүхэд хэдэн санаа нийлүүлээд ингээд биччихсэн ийм Их Хурлын тогтоол гарч болохгүй ээ. Үүнийгээ засмаар байна.

Тэгээд нэгдүгээрт энэ байна шүү дээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33.3 дээр чинь үндэслэлийг нь гарга гэсэн байгаа байхгүй юу.

Хөөе. Би Та хоёртой юм яриад байна шүү дээ.

Үндэслэлийг гарга гэсэн байгаа байхгүй юу. Энэ чинь ямар ч үндэслэл алга. Зүгээр байгуул гээд. Ямар үндэслэлээр байгуулах гээд байгаа юм бэ? Яагаад заавал үнийн асуудал ярих гээд байгаа юм бэ гэдгээ энэ дээрээ тусгаж өгөх ёстой шүү дээ. Энэ чинь Улсын Их Хурал дээр очоод Их Хурлын тогтоол болоод гарна шүү дээ. Үндэслэлээ нэгдүгээрт тусгамаар байна.

Хоёрдугаарт, зөвхөн эмийн үнийн өсөлтийн шалтгаан гээд байх юм. Юу гэж зөвхөн эмийн үнийн өсөлтийг шалгаж байх юм бэ. Зарим үед эмийн үнэ өсөж байх ёстой шүү дээ. Чанартай сайн эмтэй болохын тулд эмийн үнэ өсөж байх ёстой. Тэгэхгүй бол нийт хүлээлт нь.

Үүнийг чинь уншсан хүн ямар хүлээлттэй болох вэ гэвэл эмийн үнийг буулгах гэж байгаа юм байна гээд ойлгочих байхгүй юу.

Тэгэхээр эмийн үнийн өсөлтийн шалтгаан биш эмийн үнэ гэдэг ерөнхий том сэдвээр нь явуулах хэрэгтэй.

Тэгээд нөхцөл байдалтай холбогдуулаад энэ хүрээ хязгаарыг нь зөвхөн эмийн үнийн өсөлт биш эмийн үнийн нөхцөл байдал, харьцуулсан судалгаа, тэгээд эмийн үнэ, чанар гэсэн ийм юмтай холбож. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, нэг, хоёр, гурав, дөрвөн заалтаар зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, чанар, хадгалж байгаа байдал гээд ингээд шал хачин юм бичээд байх юм.

Зайлшгүй шаардлагатай эмийг зүгээр бүгдийг нийлүүлээд л 2 дугаар зүйл болгоод л оруулчих л даа.

Гуравдугаарт, энэ хуулиар чинь бид хугацаатай даалгавар өгөх ёстой байхгүй юу. Хэзээ хариугаа өгөх юм гэдэг чинь байх ёстой шүү дээ. Тийм ч юм байхгүй. Зүгээр л нэг юу байгуулчихлаа гээд хаячих юм.

Та нар, Г.Нямсүрэн чи энэ Байнгын хороог хариуцаж байгаа ахлах мэргэжилтэн байж байна. П.Анужин чи энэ Байнгын хорооны дарга байж байна. Энэ юмнуудаа харж бай л даа. Ийм юм батлаад байх юм бол бид энд сууж Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэж байх ямар ч утга байхгүй байна шүү дээ. Арай л хариуцлагагүй байна шүү дээ.

Тэгээд би хэдэн санал цохчихлоо. Үүнийг засаад тэгээд Улсын Их Хуралд оруулахаасаа өмнө үүгээр нь янзлаад оруулмаар байна.

П.Анужин: Ц.Мөнх-Оргил гишүүнтэй санал нэг байна.

Бид тогтоолын төслийг нь аваад Ж.Чинбүрэн гишүүнд удаа дараа яг энэ хуулийн үндэслэлийг хэлээд нийцэхгүй байна гэдэг саналыг өнөөдөрхөн хэлээд, бид нар бүр өнгөрсөн долоо хоногт хэлээд, өнөөдөр сүүлд хэлэлцэх байсан үгийнхээ өмнө нь бүр эдгээр бүх зүйлийг нь нарийн оруулчихсан байсан юм.

Тэгээд таны хэлсэн саналыг Улсын Их Хуралд танилцуулахдаа бид саналдаа тусгаж хэлэхээр бодож байна. Санал нэг байна. Байнгын хороо.

Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ яараад байх асуудал биш ээ. Чуулган завсарлахаас өмнө л энэ Хяналт шалгалтын түр хороогоо байгуулчихад хангалттай байхгүй юу.

Тийм учраас Г.Нямсүрэн зөвлөх, П.Анужин дарга аа, үүнийгээ янзлаад

гишүүддээ урьдчилж тараагаад, саналыг нь аваад монгол хүн уншаад ийм түр хороо байгуулж байгаа юм байна. Энэ түр хороо нь ийм юм хийх юм байна, ийм үндэслэлтэй юм байна, ийм хугацаанд ийм тайлан ирүүлэх юм байна гээд энэ чинь төрийн албан ёсны хэлж байна, төрийн бичиг хэрэг хөтлөлтийн дүрэм, журам гэж байна. Эсвэл ерөөсөө сэхээтэн хүний нэг албан тоот бичдэг арга зам байна шүү дээ. Түүнд нь нийцүүлээд гишүүдэд тараагаад дараагийн Байнгын хороогоор дахиж оруулаад, үүнийгээ биш, янзалсан текстээ Байнгын хороогоороо батлуулаад нэгдсэн хуралдаанд оруулна.

Тэгэхгүй бол наад дэгээр чинь Байнгын хороогоор баталсан, дэмжсэн төсөл чинь нэгдсэн хуралдаанд.../минут дуусав/

П.Анужин: Одоо сүүлийн хууль. Тийм. Засгийн газрын гишүүд Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль шүү. Энэ дээр Байнгын хороо өдөр шөнөгүй маш их ажилласан. Тийм.

**Зургаа.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн
хуулийн төслүүд**

/Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл.

Ням-Осорын Учрал нарын 5 гишүүнээс 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Улсы Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн

тухай хуулийн төсөл нэгтгэсэн анхны хэлэлцүүлгийг хийе.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? 1 дүгээр зүйл дээр. Үг хэлэх гишүүн байхгүй байна. Ажлын хэсгээс нэг саналтай.

1.Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг суурь болгож, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нараас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг нэгтгэх.

Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар Т.Доржханд, Ц.Идэрбат, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг. Цаашид “Ажлын хэсэг” гэнэ. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хөтөлбөр хэрэгжүүлэх” гэсний дараах “хувийн нэмэлт тэтгэврийн” гэснийг хасаж, “талуудын” гэсний өмнө “оролцогч” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “хууль тогтоомжоос” гэснийг “хууль тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “даатгалд хамрагдсан” гэснийг “даатгалын санд шимтгэл төлж, даатгуулсан” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтын “31.1.3-т заасан урт хугацааны даатгал эрхэлж буй этгээдийг” гэснийг “4.1.2-т заасан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан урт хугацааны даатгал эрхэлж байгаа компанийг” гэж, 5.1.10 дахь заалтын “хөрөнгө эзэмших” гэснийг “хөрөнгө өмчлөх” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 5.1.16 дахь заалтын “бүрэн” гэснийг болон 5.1.17, 5.1.18 дахь заалтыг төслөөс тус тус хасаж, 5.1.21 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.21.“хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.33-т заасан этгээдийг;”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

6.Төслийн 6 дугаар зүйлийн гарчигийн “үйл ажиллагаа” гэснийг “түүнийг” гэж, 6.3 дахь хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагааг” гэснийг “хөтөлбөрийг” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “хүртэл хувь хүний” гэсний өмнө “нэмэлт тэтгэврийн хөрөнгийг зарцуулж дуусах” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “тогтоолгохоор хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох” гэснийг “тогтоолгох” гэж өөрчилж, “хүртэл ажил олгогчийн” гэсний өмнө “нэмэлт тэтгэврийн хөрөнгийг зарцуулж дуусах” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “мөнгөн дүн ба төлөх” гэсний дараах “давтамж,” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “шимтгэл төлөх” гэснийг дараах “давтамж,” гэснийг хасаж, 10.4 дэх хэсгийн “хамрагдсан ажилтны” гэсний дараа “сард” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 дахь хэсгийн “сар бүр тооцож,” гэсний дараа “хагас жил тутамд” гэж, 11.7 дахь хэсгийн “Баталгаат өгөөжийн” гэсний дараа “жилийн” гэж нэмж, “Төв банкны” гэснийг “Төв банк /Монголбанк/-ны” гэж /цаашид тохиолдол бүрд/ өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

12 дугаар зүйлтэй холбоотой саналтай үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. 12 дугаар зүйлтэй холбоотой зарчмын зөрүүтэй санал мөн ирээгүй.

12.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “энэ хуулийн 13.1-д” гэсний өмнө “эрх залгамжлагч, өвлөгч” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагаа” гэснийг “хөтөлбөрийг” гэж, 14.3 дахь хэсгийн “санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг” гэснийг “санд төвлөрүүлсэн нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хэмжээ, төлбөрийн чадварын эрсдэлийг” гэж тус тус өөрчилж, 14.7.5 дахь заалтын “зүйл” гэснийг болон 14.7.2 дахь заалтыг тус тус хасаж, 14.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 14.2.6 дахь заалт нэмэх:

“14.2.6.Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “сангийн удирдах зөвлөл” гэснийг “сангийн төлөөлөн удирдах зөвлөл, бусад эрх бүхий албан тушаалтан” гэж, 15.6 дахь хэсгийн “гүйцэтгэх удирдлага, холбогдох этгээд” гэснийг “бусад эрх бүхий албан тушаалтан” гэж, 15.9.7 дахь заалтын “үйл

ажиллагааг эрхлэх” гэснийг “бүртгэлийн” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 16 дугаар зүйлийн гарчгийн “олгох” гэсний дараа “, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх эрх бүхий этгээд” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 17 дугаар зүйлийн гарчгийн “зөвшөөрөл олгох үйл ажиллагаа” гэснийг “зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох” гэж, 17.3 дахь хэсгийн “45 хоногийн” гэснийг “21 өдрийн” гэж, 17.4 дэх хэсгийн “баримт бичиг, мэдээллийг” гэснийг “мэдээлэл, баримт бичиг, тодруулга, тайлбар” гэж, “60 хоногийн” гэснийг “45 өдрийн” гэж тус тус өөрчилж, 17.5.4 дэх заалтыг “худал, төөрөгдүүлсэн, алдаатай, эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл тусгасан.” гэж өөрчлөн найруулж, 17.1 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, 17.1.7 дахь заалтыг хасаж, 17.3 дахь хэсгийн “ирүүлэхийг шаардах,” гэсний дараа “тодруулга, тайлбар авах” гэж нэмж, 17.6 дахь хэсгийн “хүсэлт гаргагчид” гэсний дараа “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан хугацаанд” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.8, 17.9, 17.10, 17.11, 17.12, 17.13, 17.14, 17.15 дахь хэсэг тус тус нэмэх:

“17.8.Хороо дараах тохиолдолд гишүүн, эрх залгамжлагч, өвлөгчийн эрх,

ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

17.8.1.эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн;

17.8.2.баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

17.8.3.хуульд заасан хугацаанд тайланг ирүүлээгүй, эсхүл худал, зөрүүтэй тайлагнасан;

17.8.4.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.

17.9.энэ хуулийн 17.8-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тогтоосноос хойш хувийн тэтгэврийн сан, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 5 өдрийн дотор албан бичгээр болон цахимаар мэдэгдэнэ.

17.10.Хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 17.9-д заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

17.11.Хороо энэ хуулийн 17.10-д заасан тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын 5 өдрийн дотор хувийн тэтгэврийн санд хүргүүлнэ.

17.12.Хороо энэ хуулийн 17.10-д заасан тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, тусгай

зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар хувийн тэтгэврийн сан, харьяалах татварын алба, кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 2 өдрийн дотор бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

17.13.Энэ хуулийн 17.8-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сангийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

17.14.Хороо дараах тохиолдолд хувийн тэтгэврийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

17.14.1.хувийн тэтгэврийн сан энэ хуулийн 5.1.7-д заасан гишүүн болон Хороонд хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг дуусгавар болгохоос ажлын 90 өдрийн өмнө бичгээр, эсхүл цахимаар мэдэгдсэн;

17.14.2.нэмэлт тэтгэврийн бүх хөтөлбөр Хорооны бүртгэлээс хасагдсан;

17.14.3.энэ хууль болон бусад хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн;

17.14.4.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;

17.14.5.Зөвшөөрлийн тухай хуульд заасан бусад.

17.15.Хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл шаардлагыг тогтоосон журмыг Хороо батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Д.Батлут гишүүн санал гаргая.
Горимын санал.

Д.Батлут: Би дэмжиж санал өгсөн боловч эсрэг гарчихлаа. Төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөч. Ахин санал хураалгаж өгнө үү.

П.Анужин: Д.Батлут гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулья. Саяын саналыг хүчингүй болгох тухай санал хураалт. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар дэмжигдлээ.

17 дугаар зүйл дээр ахин санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цаасан, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, 18.1.3 дахь заалтын “гэрээний санал” гэснийг “гэрээ” гэж, 18.2 дахь хэсгийн “30 хоногийн” гэснийг “20 өдрийн” гэж тус тус өөрчилж, 18.1.4 дэх заалтын “; бусад баримт бичгийн загвар” гэснийг болон 18.1.5 дахь заалтыг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 19 дүгээр зүйлийн гарчиг болон 19.1 дэх хэсгийн “хөтөлбөрийн үйл ажиллагаа” гэснийг “хөтөлбөрийг” гэж өөрчилж, 19.2 дахь хэсгийн “; Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасах

20.1.Хороо дараах тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлнэ:

20.1.1.баталгаат өгөөж, эсхүл баталгаат өгөөжөөс давсан гэрээгээр тохирсон дүнг төлөөгүй;

20.1.2.энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан маркетинг болон зар сурталчилгааны шаардлагыг зөрчсөн;

20.1.3.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл байгаа тухай Хороо тогтоосноос хойш хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 5 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

20.3.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 20.2-т заасан мэдэгдлийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хариу тайлбарыг Хороонд хүргүүлнэ.

20.4.Хороо энэ хуулийн 20.3-т заасан тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд нэмэлт тэтгэврийн

хөтөлбөрийг түдгэлзүүлэхгүй тухай албан бичгийг ажлын 5 өдрийн дотор хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид хүргүүлнэ.

20.5.Хороо энэ хуулийн 20.3-т заасан тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл тайлбар ирүүлээгүй бол хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг 1 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, кастодиан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид ажлын 2 өдрийн дотор бичгээр эсхүл цахимаар мэдэгдэнэ.

20.6.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл арилсан тохиолдолд Хороо хувийн тэтгэврийн сан, урт хугацааны хүсэлтийг үндэслэн хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг сэргээнэ.

20.7.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч хуульд заасан хугацаанд залруулаагүй тохиолдолд Хороо хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэлээс хасна.

20.8.Энэ хуулийн 17.12-т заасан шийдвэр гарсан бол хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлэх үндэслэл болно.

20.9.Нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “дуусгавар болгох” гэснийг “хүчингүй болгох, бүртгэлээс хасах” гэж, 21.3.1 дэх заалтын “тайлан тэнцлийг” гэснийг “санхүүгийн тайлан” гэж, 21.3.4 дэх заалтын “саналд” гэснийг “шийдвэрт” гэж тус тус өөрчилж, 21.3.2 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрт” гэсний дараа “нэмэлт тэтгэврийн нэрийн” гэж, 21.3.5 дахь заалтын “тэтгэврийн хөтөлбөрийн” гэсний дараа “зарим” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 21.1, 21.2, 21.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан мэдэгдлийг хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь хүлээн авснаас хойш шимтгэл авах, гишүүн шинээр элсүүлэхийг хориглоно.

21.2.Хороо энэ хуулийн 21.1-д заасан мэдэгдлийг кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компанид мэдэгдэж, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн шилжүүлгийг нэн даруй зогсооно.

21.3.3.хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн үйл ажиллагаа, нэмэлт тэтгэврийн хөрөнгийн үнэлгээг хараат бус, хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэх;”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.3.4 дэх заалт, 21.5, 21.6, 21.7 дахь хэсэг тус тус нэмэх:

“21.3.4.гишүүдийн хадгалагдсан эрхийн бүх төлбөрийг бүрэн барагдуулах хөрөнгө хүрэлцэхгүй

тохиолдолд, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч өөрийн хөрөнгөөр барагдуулах тухай хүсэлтийг санхүүгийн тайлангийн хамт Хороонд хүргүүлж, энэ тухай бүх гишүүдэд мэдэгдэх;

21.5.Тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг Хороо түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассан тохиолдолд хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч нь энэ хуулийн 21.3-д заасан арга хэмжээ авна.

21.6.Урт хугацааны даатгагчийн эрхэлж буй нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн бүртгэлийг хассан тохиолдолд энэ хуулийн 22.1-22.11-д заасан арга хэмжээг авна.

21.7.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн тусгай зөвшөөрөл, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, бүртгэлээс хассаны дараа авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг Хороо батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар дэмжигдлээ.

22.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн” гэснийг “тэтгэврийн сангийн” гэж, “дуусгавар болгосон” гэснийг “бүртгэлээс хассан” гэж, 22.3 дахь хэсгийн “өмчлөгч болно” гэснийг “өмчлөгч байна” гэж, 22.4 дэх хэсгийн “зөвшөөрөл авсны дагуу” гэснийг “зөвшөөрөл авсны үндсэн дээр” гэж, 22.5 дахь хэсгийн “биечлэн мэдэгдэл хүргүүлнэ” гэснийг “цахимаар хүргүүлж биечлэн уулзалт зохион байгуулна.” гэж, 22.6 дахь хэсгийн “тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчаас” гэснийг

“тэтгэврийн сангаас” гэж, 22.6.2, 22.7 дахь хэсгийн “тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчийн” гэснийг “тэтгэврийн сангийн” гэж, 22.12 дахь хэсгийн “дүрэм, төлбөр барагдуулах журмыг” гэснийг “дүрмийг” гэж тус тус өөрчилж, 22.5 дахь хэсгийн “30 хоногийн өмнө” гэсний дараа “мэдэгдлийг” гэж, 22.6.2 дахь заалтын “цалин хөлс,” гэсний дараа “төлөгдөөгүй” гэж, мөн зүйлд “Энэ хуулийн 22.6-д заасан өр төлбөр барагдуулах журмыг Хороо батална.” гэсэн 22.13 дахь хэсэг тус тус нэмж, 22.6.1, 22.10 дахь хэсгийн “бүх” гэснийг, 22.4, 22.10, 22.11, дэх хэсгийн “урт хугацааны даатгагч,” гэснийг, 22.10 дахь хэсгийн “хуваарилах төлөвлөгөө” гэсний өмнөх “гишүүдэд” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Энэ хуулийн 22.1-д заасан комиссын бүрэлдэхүүнд дараах этгээдийг томилохгүй.

22.1.1.хувийн тэтгэврийн сангийн удирдах зөвлөлийн гишүүн;

22.1.2.хувийн тэтгэврийн сангийн бусад эрх бүхий албан тушаалтан;

22.1.3.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлага;

22.1.4.хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх бүхий албан тушаалтан;

22.1.5.Хорооноос тогтоосон болон бусад холбогдох этгээд.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “бүх” гэснийг хасаж, 23.3

дахь хэсгийн “удирдамжийг” гэснийг “журмыг” гэж, 23.4 дэх хэсгийн “үнэн зөв бус,” гэснийг “худал,” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “олон улсын зээлжих зэрэглэл тогтоож буй байгууллагаас гаргасан үнэлгээний ангилалд үндэслэн” гэснийг “Хороо” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

25 дугаар зүйл дээр асуулт, санал гараагүй болно.

25.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “шаардлагыг хангах” гэсний дараа “хөрөнгө оруулалтын” гэж, 26.2 дахь хэсгийн “Бодлогод оруулсан нэмэлт, өөрчлөлтийг” гэсний дараа “Хороо болон” гэж тус тус нэмж, 26.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.1.2.Хорооноос тогтоосон нэмэлт тэтгэврийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн төрөл, дээд хязгаар, тухайн хөрөнгийн ангилал бүрийн нэг этгээд, эсхүл хэд хэдэн этгээдэд хөрөнгө оруулалт хийх дээд хязгаар;”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын “авагдаагүй” гэснийг “аваагүй,” гэж, 27.3 дахь хэсгийн “үнэт цаасанд” гэснийг “үнэт цаас, банкны хадгаламж, хадгаламжийн сертификатад” гэж тус тус өөрчилж, 27.3 дахь хэсгийн “Засгийн газраас гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулахад хязгаар тогтоохгүй.” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн “хөрөнгөөр аливаа” гэснийг “хөрөнгөөр бүх” гэж өөрчилж, 28.1.1, 28.1.2, 28.1.3, 28.1.4, 28.1.7 дахь заалтыг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 30 дугаар зүйлд “Нэмэлт тэтгэврийн хөрөнгийг кастодианы хөрөнгөөс тусгаарласан байна.” гэсэн 30.8 дахь хэсэг нэмж, 30.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.4.Кастодиан нь нэгээс дээш тооны хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагчид кастодиан үйлчилгээ үзүүлж болно. Энэ тохиолдолд нэмэлт тэтгэврийн хөтөлбөр бүрийн хөрөнгө, үйл ажиллагаа, бүртгэл мэдээллийг тус тусад бүртгэнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.1.2.хөрөнгө оруулалтын менежментийн компани, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч, тэдгээрийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч холбогдох этгээд байх;”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32.1.3 дахь заалтыг төслөөс хасах:

“32.1.Кастодианы гэрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 50.1-д зааснаас гадна доор дурдсан зүйлийг тусгана:”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “ноцтой” гэснийг хасаж, 33.1.1 дэх заалтын “мэдэгдлийг” гэснийг “мэдэгдлийг ажлын хоёр өдрийн дотор хүргүүлж” гэж, 33.1.2 дахь заалтын “яаралтай” гэснийг “ажлын хоёр өдрийн дотор” гэж, 33.3 дахь хэсгийн “ноцтой доголдлын” гэснийг “доголдол үүссэн” гэж тус тус өөрчилж, 33.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.2.Хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч энэ хуулийн 33.1.1, 33.1.2-т заасан хугацаанд арга хэмжээг яаралтай аваагүй тохиолдолд Хорооноос кастодианыг өөрчлөхийг даалгана.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.4 дэх хэсгийн “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд” гэснийг “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 44.8, 47.2-т” гэж өөрчилж, 34.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.9.Хороо нэмэлт тэтгэврийн хөрөнгийг удирдах харилцааг зохицуулсан журмыг батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 35 дугаар зүйлд “сүүлийн нэг жилээс доошгүй хугацаанд сангийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу удирдсан байх.” гэсэн 35.1.3 дахь заалт нэмж, 35.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.2.Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь кастодиан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээд, ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хувьд ажил олгогчид зээл олгох, тэдгээрээс зээл авахыг хориглоно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 36 дугаар 36.1 дэх хэсгийн “дараах агуулгыг” гэснийг “доор дурдсан зүйлийг” гэж, 36.2 дахь хэсгийн “Хөрөнгө оруулалтын менежментийн”

гэснийг “Энэ хуулийн 36.1-д заасан” гэж, “зөвхөн сонгогдсон” гэснийг “гэрээ байгуулсан” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

44.4 хувиар дэмжигдсэнгүй.

Миний төхөөрөмж ажилласангүй. Саяын саналыг хүчингүй болгож өгнө үү гэж санал хураалгахыг хүсэж байна. Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Дахин санал хураалт. Гишүүд ээ, санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн 37 дугаар зүйлийн гарчгийн “Нэмэлт тэтгэврийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэснийг хасаж, 37.1.1 дэх заалтын “дундаж үнэд” гэснийг “үнэ ханшид” гэж, 37.1.3 дахь заалтын “болон эдийн засгийн харилцаанд” гэснийг “, үйл ажиллагааны чиглэлд” гэж тус тус өөрчилж, 37.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37.2.Хөрөнгө оруулалттай холбоотой зөрчил илэрсэн өдөр, хөрөнгө оруулалтын ангилал бүрт хөрөнгийн үнэлгээ хийж тухайн зөрчил илэрснийг тогтоосон өдрөөс хойш гурван сар хүртэл хугацааны дотор энэ хуульд нийцүүлэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өөрчлөлт оруулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 38 дугаар зүйлийн гарчгийн “зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага” гэснийг хасаж, 38.1 дэх хэсэг, 38.1.1, 38.1.2, 38.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.Хороо хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианд дараах тохиолдолд энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авна:

38.1.1.энэ хууль болон бусад хууль тогтоомж, зааварчилгаа зөрчсөн;

38.1.2.эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хоёр ба түүнээс дээш удаа зөрчсөн;

38.1.3.энэ хуулиар зөвшөөрөөгүй үйл ажиллагаа эрхэлсэн;”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

37.Төслийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.5, 38.1.6 дахь заалт нэмэх:

“38.1.5.хуульд заасан хугацаанд тайланг ирүүлээгүй, эсхүл худал, зөрүүтэй тайлагнасан;

38.1.6.нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулаагүй зөрчил илэрсэн.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн “ТАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрний “ХУВИЙН” гэсний өмнө “ГИШҮҮН” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

39.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийн “гишүүн шилжих,” гэсний дараа “хадгалан үргэлжлүүлэх, дуусгавар болгох” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

40 дүгээр зүйл дээр асуулт, санал гараагүй болно. Санал ирээгүй.

40.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “зааж болох” гэснийг “заах” гэж өөрчилж, 41.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.7.Гишүүн насан туршийн тэтгэвэр авах бол урт хугацааны даатгагчтай гэрээ байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

41.Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “нэмэлт тэтгэвэр олгох” гэснийг “хадгалагдсан эрх, хөрөнгийг шилжүүлэх” гэж, 42.3, 42.4 дэх хэсгийн “шилжүүлэх, эсхүл нэг удаагийн тэтгэвэр хэлбэрээр авах сонголт олгоно” гэснийг “шилжүүлнэ.” гэж, 42.5 дахь хэсгийн “тэтгэврийг эрх залгамжлагчид олгоно” гэснийг “хөрөнгийг залгамжлагчийн тэтгэврийн нэрийн дансанд шилжүүлнэ.” гэж, 42.6 дахь хэсгийн “тэтгэврийг

даатгалын компанитай байгуулсан гэрээнд тодорхойлсноор олгоно” гэснийг “үлдэгдэл хөрөнгийг даатгалын компанитай байгуулсан гэрээнд тодорхойлсноор түүний тэтгэврийн нэрийн дансанд шилжүүлнэ.” гэж, 42.7 дахь хэсгийн “төлбөрийг өвлөгчид олгоно” гэснийг “үлдэгдэл хөрөнгийг өвлөгчид шилжүүлнэ.” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

43 дугаар зүйтэй холбоотой үг хэлэх гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

42.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “бэлэн бусаар олгоно” гэснийг “бэлэн бусаар шилжүүлнэ” гэж, 44.5 дахь хэсгийн “гомдол шийдвэрлэх” гэснийг “гомдол шийдвэрлэх, үлдэгдэл хөрөнгийг шилжүүлэх” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

43.Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “үүсгэн байгуулсан” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн “Үнэлгээг өдрөөр, эсхүл сараар тооцож гаргана.” гэснийг, 46.2 дахь хэсгийн “тухай бүр”, “гаргаж,” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

45.Төслийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсгийн “хөрөнгө оруулалтад нөлөөлөх” гэснийг “хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах” гэж өөрчилж, мөн хэсгийн “гишүүнд” гэсний дараа “тухай бүр” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

46.Төслийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “үйлчилгээтэй” гэснийг “үйл ажиллагаатай” гэж өөрчилж, 48.2.3 дахь заалтын “тус тусад нь, мөн ажил олгогчийн төлсөн шимтгэлд холбогдох хадгалагдсан эрхийн мэдээлэл” гэснийг, 48.2.5 дахь заалтын “өвлүүлэх” гэсний дараах “зэрэг” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

47.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсгийн “тэрхүү” гэснийг, 49.8 дахь хэсгийн “аливаа” гэснийг, 49.9 дэх заалтын “үүдэн” гэснийг тус тус хасаж, 49.9.2 дахь заалтын хууль зүйн арга хэмжээ” гэснийг “хууль зүйн туслалцаа” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

48.Төслийн 50 дугаар зүйлийн 50.7 дахь хэсгийн “нэмэлт тэтгэврийн

хөрөнгийг гаргуулах, эсхүл бусад арга хэмжээ авахуулахаар” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

51 дүгээр зүйлтэй холбоотой асуулт байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ажлын хэсгээс ирээгүй.

49.Төслийн 52 дугаар зүйлийн 52.2.3 дахь заалтын “хууль зүйн арга хэмжээ” гэснийг “хууль зүйн туслалцаа” гэж өөрчилж, 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Гишүүн, эрх залгамжлагч, өвлөгч, хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч ажил олгогчийн төлөөгүй шимтгэлийг төлүүлэхээр шүүхэд гомдол гаргаж болно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

53 дугаар зүйлтэй холбоотой асуулт, үг байна уу? Зарчмын зөрүүтэй санал ирээгүй.

50.Төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийн “Цаг хугацаандаа тайлагнаагүй тохиолдолд Хороо холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна.” гэснийг, 54.3 дахь хэсгийн “хариуцлагын” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

55 дугаар зүйл дээр асуулт асуух гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн.

Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ажлын хэсгээс ирээгүй.

51.Төслийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийн “эрх бүхий байгууллагаар” гэснийг “Хороогоор” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар санал дэмжигдлээ.

57 дугаар зүйл дээр асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу? Зарчмын зөрүүтэй санал гишүүдээс болон ажлын хэсгийн гишүүдээс ирээгүй.

52.Төслийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсгийн “нэг жилийн” гэснийг “нэг жил хүртэлх” гэж, 58.2 дахь хэсгийн “ажлын 100 хоногийн дотор” гэснийг “зургаан сар хүртэлх хугацаанд” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар санал дэмжигдлээ.

59 дүгээр зүйлтэй холбогдуулж үг хэлж, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал ажлын хэсэг, гишүүдээс ирээгүй.

53.Төслийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“60.1.Энэ хуулийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

55.6 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын хоёр санал байна. Санал хураая. Ажлын хэсгээс орж ирсэн найруулгын хоёр саналыг уншиж танилцуулья.

1.Төслийн 9.3 дахь хэсгийн “ба” гэснийг “бөгөөд” гэж, 10.4 дахь хэсгийн “тавин” гэснийг “50” гэж, “хорин” гэснийг “20” гэж, 11.1 дэх хэсгийн “3” гэснийг “гурван” гэж, 11.7 дахь заалтын “Төв банкны” гэснийг “Төв банк /Монголбанк/-ны” гэж, 27.1.2 дахь заалтын Төв банкны үнэт цаас гэснийг Төв банк /Монголбанк/-ны үнэт цаас гэж,

34.4 дэх хэсгийн “ба” гэснийг “бөгөөд” гэж, 45.2 дахь хэсгийн “хуулийн” гэснийг “хуульд заасны” гэж, 46.2 дахь хэсгийн “аудитлан” гэснийг “аудит хийж,” гэж, 47.5 дахь хэсгийн “гаргаж” гэснийг “гаргах,” гэж, 50.3 дахь хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж өөрчлөх.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, ишлэлийг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар санал дэмжигдлээ.

Одоо хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн 19 хуулийн төслийг зүйл тус бүрээр нь хэлэлцэнэ.

Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

1 дүгээр зүйл дээр байхгүй байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулж үг хэлэх, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

3 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

4 дүгээр зүйл дээр санал хэлэх гишүүн байхгүй байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр үг хэлж, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

3 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

4 дүгээр зүйл дээр. Байхгүй байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр. Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр санал хэлж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

3 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

4 дүгээр зүйл дээр. Байхгүй байна.

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

1 зүйл. Санал хэлэх гишүүн байхгүй байна. Үг хэлэх гишүүн алга байна.

2 дугаар зүйл дээр мөн байхгүй байна.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр санал байна уу? Алга байна.

2 дугаар зүйл дээр үг хэлэх гишүүн байхгүй байна.

3 дугаар зүйл дээр үг хэлэх гишүүн байхгүй байна.

4 дүгээр зүйл дээр үг хэлэх гишүүн байхгүй байна.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Үг хэлэх гишүүн, санал. Байхгүй байна.

2 дугаар зүйл. Байхгүй байна.

3 дугаар зүйл. Байхгүй байна.

Нэг.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 25 дугаар зүйлийн “25.7” дахь хэсгийн “хуульд заасны дагуу” гэснийг “хуулийн 41.2.1, 41.2.2-т заасан” гэж өөрчлөх.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “нийгмийн даатгалын” гэснийг “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн 41.2.1, 41.2.2-т зааснаас бусад” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр санал байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр. Уншиж танилцууллаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Үг хэлэх гишүүд байхгүй байна.

2 дугаар зүйл дээр санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй.

3 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

4 дүгээр зүйл дээр. Байхгүй байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

3 дугаар зүйл дээр. Байхгүй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай

1 дүгээр зүйл дээр асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

2 дугаар зүйл дээр асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны гишүүд ээ,

Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл, Ням-Осорын Учрал нарын 5 гишүүнээс 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбатыг томилно.

Хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлын дараагийн асуудалд орьё.

**Долоо.Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын
Чингис хаан банкинд байршиж буй сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах
үйл ажиллагааны талаар болон Капитал банкны эрх хүлээн авагчийн
мэдээлэл**

Чингис хаан банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар тайлан сонсох байгаа. Мэдээлэл сонсоно.

Чингис хаан банканд байршиж буй нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулах үйл ажиллагааны талаар Капитал банкны эрх хүлээн авагчийн мэдээллийг сонсоно.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулж ирье. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Мэдээллийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

Х.Булгантуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн болон Чингис хаан банканд байгаа нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг төлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Та бүхэндээ танилцуулж байна.

Капитал банк дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг төлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, капиталын эрх хүлээн авагч томилогдсон хугацаанаас хойш төлбөр нэхэмжлэх, нэхэмжилсэн төлбөрийг төлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний дүнг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар 11 удаа хэлэлцэж, 6 тогтоол батлагдаж гарсан.

Гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд хандаж төлбөр барагдуулах дарааллыг Банкны тухай хуулийн 73.1.8-д хамаарах талаар шийдвэрлүүлсэн ба Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд капиталын эрх хүлээн авагчид төлбөрийг барагдуулахыг даалгах нэхэмжлэл гаргаж, 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 182/ШШ/2020/02/419 тоот шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн.

Капиталын эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн 104.2 тэрбум төгрөгөөс 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 10.14 тэрбум төгрөг нь мөнгөн

хэлбэрээр, 25.06 тэрбум төгрөг нь хөрөнгөөр, нийт 35.2 тэрбум төгрөгийн авлага барагдаж, 69.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Холбогдох эрх бүхий байгууллагуудаас өгсөн зөвшөөрлийн дагуу 25.06 тэрбум төгрөгийн 78 ширхэг хөрөнгө хүлээн авснаас 8.4 тэрбум төгрөгийн үнэтэй 33 ширхэг хөрөнгийг 8.6 тэрбум төгрөгөөр борлуулж, 16.6 тэрбум төгрөгийн 45 ширхэг хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Хөрөнгүүдийг худалдан борлуулахаар 10 удаагийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулсан.

Үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байсан 34 аж ахуйн нэгж, иргэнтэй түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж, 256.6 сая төгрөгийн түрээсийн орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж, хөрөнгийн ашиглалт хамгаалалттай холбоотой 44.2 сая төгрөгийн зардал гаргаад байна.

Капиталын эрх хүлээн авагчаас хүлээн авсан хөрөнгүүдийг үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагуудтай хамтран ажиллаж, гэрээгээр борлуулах талаар хэлэлцэн холбогдох шийдвэр гаргах, тус банкны удирдлага болон хөрөнгийн маргааны улмаас хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа асуудлууд шийдвэрлэгдэхэд сангийн нэхэмжилсэн өр төлбөрт тухайн хөрөнгүүдийг тооцоо авах зэрэг саналтай байгаа болно.

Саяхан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл Нийгмийн бодлогын байнгын хороонд тайлангаа танилцуулахад ижил төстэй тулгамдаад байгаа асуудлуудынхаа талаар Байнгын хорооны гишүүдэд, Байнгын хорооны даргад танилцуулсан байгаа.

Чингис хаан банкны хувьд Чингис хаан банкнаас нэхэмжилсэн Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг төлүүлэх чиглэлээр бид 2019 оны 10 дугаар сараас нийгмийн даатгалын төлбөр тооцоог тухайн өдөрт нь гүйцэтгэж чадахгүй болсон тул Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2020 оны 9 дүгээр сард Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатын шүүхэд Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг гаргуулах тухай нэхэмжлэл гарган, шүүгчийн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 181/ИШХ2020/02/624 дүгээр захирамжаар нэхэмжлэлийг бүрэн хангаж Чингис хаан банкнаас 101.7 тэрбум төгрөгийг гаргуулж Нийгмийн даатгалын ерөнхий газарт олгохоор шийдвэрлэсэн.

Энэхүү нэхэмжилсэн дүнгээс 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийтдээ 6.57 тэрбум төгрөг төлөгдөж, төлбөрийн үлдэгдэл 65.2 тэрбум төгрөг авч чадаагүй байна.

Чингис хаан банкны хувьцаа эзэмшигч “Нью Стандарт Финанс” ХХК нь 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр “Баянмөнх техник дэвшил ХО” гадаадын хөрөнгө оруулалттай хувьцаат компанитай худалдах, худалдан авах гэрээ байгуулж уг банкны энгийн хувьцааг “Баянмөнх техник дэвшил ХО” гадаадын хөрөнгө оруулалттай хувьцаат компани худалдан авахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авахаар холбогдох баримт бичгийг Монголбанканд хүргүүлсэн тухай мэдээллийг гэрээ байгуулсан талууд болон Монголбанкнаас тус тус ирүүлээд байгаа.

Худалдан авагч тал болох “Баянмөнх техник дэвшил ХО” гадаадын хөрөнгө оруулалттай компани нь үндсэн төлбөр болох 64.3 тэрбум төгрөгийг 2023

оны 7 дугаар сараас 2025 оны 6 дугаар сар хүртэл 24 сарын хугацаанд хүү болох 30.9 тэрбум төгрөгийг үндсэн төлбөрт төлөгдөж дууссаны дараа буюу 2025 оны 6 дугаар сараас 2027 оны 6 дугаар сар хүртэл 24 сарын хугацаанд нийтдээ 48 сарын хугацаанд төлөх саналыг гаргасан байгаа.

Чингис хаан банкнаас нэхэмжилсэн төлбөр 95.2 тэрбум, капиталын эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн төлбөр 69.0 тэрбум, нийтдээ 164.2 тэрбум төгрөг байгаа бөгөөд энэ төлбөрийн барагдуулалт удаашралтай.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн даатгалын ерөнхий газар дангаараа шийдвэр гарган хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байгаа учраас өнөөдөр Нийгмийн бодлогын байнгын хороо, холбогдох Байнгын хороондоо танилцуулж байгаа юм.

Иймд дээрх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, капиталын эрх хүлээн авагчаас хүлээн авсан хөрөнгүүдийг үл хөдлөхийн хөрөнгө зуучлалын байгууллагуудтай хамтран ажиллаж борлуулах, Чингис Хаан банкныг худалдан авахаар гэрээ байгуулсан “Баянмөнх техник дэвшил ХО” гадаадын хөрөнгө оруулалттай хувьцаат компанитай төлбөр төлөх хуваарийг баталсан гэрээ байгуулах зэрэг холбогдох шийдвэрийг гаргуулах саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.

Тус яамнаас Засгийн газрын хуралдаанд танилцуулж, өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд танилцуулаад цаашид Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэр гаргуулан

хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа юм.

Тэгээд холбогдох Байнгын хорооныхоо хорооныхоо гишүүдэд танилцуулж байна.

Тэгээд энэ асуудлыг Та бүхэн маань хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

П.Анужин: Х.Булгантуяа сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Цагаанхүүгийн Ц.Идэрбатгишүүнээр асуулт асуух гишүүдийг тасалъя.

Бадарчийн Б.Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Зарим нэг санал байна.

Уг нь нийгмийн даатгалын өр авлагыг нэхэх, эргэн төлүүлэх, хохиролгүй болгох асуудал маш том сэдэв.

Өнөөдөр нийгмийн даатгалын сан улайчихсан, ганц ч төгрөггүй гэдэг мэдээлэл байгаа энэ цаг мөчид бид яаж нийгмийн даатгалын сангаа арвижуулах вэ, мөнгөжүүлэх вэ гэдэг асуудлыг өнөөдөржингөө л нийгмийн даатгалын багц хуульдаа бид шинэчлэлээ хийхийн тулд ярьж хэлэлцэж байгаа.

Гэтэл өнөөдөр яг танхимд сууж байгаа гишүүдээ харах юм бол ингээд тавуулаа сууж байна. Бид нар.

Энэ чухал асуудлыг хэлэлцэж байхад уг нь Байнгын хорооны бүхий л гишүүдийг уг нь байлцуулах зайлшгүй шаардлагатай байх гэж би бодож байна.

Гишүүдийн ирцийн асуудал дээр Байнгын хорооны зүгээс, ажлын албанаас анхаарна биз ээ.

Ер нь 164.2 тэрбум төгрөг гээд. Яах вэ би саналаа хэлчихье.

164.2 тэрбум төгрөгийн авлага гэдэг бол би ингээд тооцохоор өнгөрсөн хугацаанд хэрвээ сандаа эргэж байсан бол энэ сангийн хөрөнгийг мөнгөжүүлэх гэдэг юм уу. Тийм ээ. Ямарваа нэгэн хохиролгүй байх тэр боломж байсан.

Тэгэхээр ер нь Засгийн газраас ямар шийдвэр авахаар шийдвэрлэсэн юм бэ? Засгийн газар шийдвэрлэнэ л гэдэг бүрхэг мэдээлэл сая өгч байна л даа.

Тэгэхээр ер нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд ажиллаж байгаа төлөөллүүд маань энэ асуудлыг хохиролгүй болгох тал дээр ямар үр дүнтэй ажлыг хийж чадав гэдэг зүйлийг асуух гэсэн юм.

Бид үндэсний байгуулсан	Нийгмийн зөвлөлийг байгаа.	даатгалын шинэчлэн Зөвлөлийг шинэчилсэн байгаа.
-------------------------	----------------------------	---

Тэгэхээр хариуцлагатай байлгах тал дээр ямар боломж бидэнд байдаг юм. Өнөөдөр бид нийгмийн даатгалын багц хуулиа хэлэлцэж байх явцдаа арилжааны банкнуудтай хэрхэн харьцах вэ гэдэг гэрээний асуудлыг ч гэсэн бас ярилаа л даа.

Хариуцлагагүй байлгах. Өмнө нь ч гэсэн хуулиар бид хариуцлагатай байх, хариуцлагыг хэрхэн тооцох вэ, өр авлагын асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг зүйлийг ярьж л байсан байж таарна.

Тэр алдааг бид давтахгүйн тулд дахиад бид хуулийг шинэчилж байна.

Тэгэхээр яг Үндэсний зөвлөлийн гишүүдийн зүгээс ер нь юуг олж харж байна вэ? Яах ёстой юм байна?

Алдагдалгүй байх, арилжааны банкнуудаа хариуцлагатай байх, эргээд хариуцлага тооцох тэр тогтолцоогоо бид авах тэр боломж нь ер нь хэр байна гэж Та бүхэн харж байгаа бол. Засгийн газар дээр ямар шийдвэр гарсан юм бол?

П.Анужин: Б.Жаргалмаа гишүүний асуултад 2 номерын микрофонд Ц.Ганцэцэг дарга хариулна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын үүрэгт ажлыг орлон гүйцэтгэгч.

Ц.Ганцэцэг: Сайд сая хоёр банктэй холбоотой өр төлбөрийн талаар маш дэлгэрэнгүй мэдээлэл өглөө.

Засгийн газрын хуралдаанаар манай яамнаас асуудал оруулсан. Энэ дээр ер нь Капитал банктэй холбоотой өр төлбөр бараг 6, 7 жил үргэлжилж байна.

Энэ өөрөө маш хүндрэлтэй. Бид авсан хөрөнгөө мөнгө болгож чадахгүй. Цаана нь өчнөөн өр төл төлбөр. 69 тэрбум төгрөг Капитал банктэй холбоотой өр төлбөр байгаа.

Чингис хаан банктэй холбоотой 6.5 тэрбум төгрөг төлөгдсөн боловч дахиад 95.0 тэрбум төгрөгийн өр төлбөр үлдчихсэн. Бидэнд хүч үндсэндээ мөхөстөөд байна л даа.

Тэгээд яам Засгийн газрын хуралдаанаар оруулаад үндсэндээ ялангуяа Чингис банктэй холбоотой тэр хувьцааг нь худалдаж авч байгаа гадаадын хөрөнгө оруулалттай “Баянмөнх” компани Монголбанктэй

хийсэн гэрээний дагуу 4 жилийн хугацаанд энэ төлбөрийг барагдуулъя.

Эхний хоёр жилд нь үндсэн төлбөр болох 67.0 тэрбум төгрөг. Дараагийн хоёр жилд нь хүүд нь ногдох 28 тэрбум төгрөгийг бид ямар нэг байдлаар энэ хугацаандаа барагдуулъя гэсэн асуудлыг тавиад бид сайддаа уламжилсан байгаа.

Чингис хаан банктай холбоотойгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай бид хамтарч ажиллаж байгаа.

Хэрвээ энэ өр төлбөрийг барагдуулах хуваарийг та нөхөд үндэсний зөв төлөөрөө хэлэлцүүлээд гэдэг юм уу, тэр эрх бүхий байгууллагаараа хэлэлцүүлээд хуваарь гаргаад явбал хуваарийн хэрэгжилтэд бид хяналтаа тавиад мөнгийг нь төлүүлэх дээр онцгой анхаарч ажиллана гээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас бид нартай хамтран ажиллаад явж байна.

Тэгээд энэ дээр тодорхой шийдвэрийг бид нарт чиглэл өгөөч ээ гэсэн энэ асуудлыг л тавьж байна.

П.Анужин: 2 номерын микрофон хариултаа гүйцээгээд хариулъя. 2 номерын микрофоныг нээе.

Ц.Ганцэцэг: Нийгмийн бодлогын байнгын хороогоор энэ асуудал ингээд шийдэгдээд Улсын Их Хурлын гишүүдийн түвшинд яригдвал бид дараагийн процесс, үйл ажиллагаа маань Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл буюу удирдах дээд байгууллагаар энэ асуудлыг хэлэлцүүлээд, Нийгмийн даатгалын ерөнхий газарт тодорхой чиглэл өгөөд, энэ хуваарийг маань батлаад, тэгээд хуваарийн биелэлтдээ хяналт тавиад явбал Нийгмийн даатгалын

ерөнхий газрын зүгээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартайгаа хамтраад энэ ажлыг зохион байгуулахад бэлэн байгаа.

П.Анужин: Нэмэлт хариултыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд Х.Булгантуяа өгнө.

Х.Булгантуяа: Байнгын хороо маань энэ асуудлыг нь шуурхай оруулж шийдвэрлэж өгч байгаад маш их баярлалаа.

Нийгмийн даатгалын сангийн төсвийг бид Улсын Их Хурал төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгож баталдаг.

Тийм учраас ийм их өглөг, авлагын асуудлыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл ганцаараа шийдвэрлэхэд хэцүү.

Тийм учраас Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороон дээр бид асуудлыг Та бүхэнд танилцуулж, Засгийн газрын хурлаар оруулж бид ингэж шийдвэрлүүлж байгаа нь яваа яваандаа тэгээд 4 жилийн хугацаанд бид энэ авлагыг л барагдуулахаас өөр аргагүй болж байгаа юм.

Капитал банкны хувьд бид бас нэг ийм үл хөдлөх хөрөнгө гээд нэг барьцаа хөрөнгө байлаа гэхэд Чингис Хаан банкны хувьд үнэхээр хэцүү. Одоо энэ худалдан авч байгаа компаниас нь л бид авлагаа барагдуулна уу гэхээс өөр арга байхгүй болчихоод байгаа.

Тэгэхээр үүнийг дараагийн 4 жилийн хугацаанд бид Нийгмийн даатгалын сан дээр авлага гэж бүртгээд. Үүнтэй холбоотойгоор манай нийгмийн даатгал, манай сангууд дээр аудитын дүгнэлт хязгаарлагдмал гарч байгаа.

Сая Улсын Их Хурлаар манай гүйцэтгэлийн тайлан ороход бас ийм байдалтай гарч байгаа.

Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулахад сая бид нарын санал хураасан нийгмийн даатгалын багц хууль дээр дахин ийм асуудал гаргахгүйн үүднээс бид Нийгмийн даатгалын сангийн “Хөрөнгө оруулалтын удирдлага” гэдэг хэсэг дээр бид бүр Монголбанкнаас тогтоосон банкны системдээ нөлөө Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан гээд ийм л арилжааны банканд байршуулахаар бид тусгаж өгсөн байгаа.

Өмнө нь ингэдэггүй байсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл шийдвэрлээд л байршуулчихдаг байсан.

Тэгээд эрсдэлтэй банканд байршуулаад, эцэс сүүлд нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн мөнгийг алдчихсан. 100 гаруй тэрбум төгрөгийн авлага үүсчихсэн байж байна гэсэн үг.

Тэгэхээр бидний оруулж ирж, Улсын Их Хурлаар батлуулж байгаа нийгмийн даатгалын багц хууль дээр дахин ийм асуудал үүсэхгүй байх дээр анхаараад, дээрээс нь Монголбанк эдгээр банкнууд дээр давхар нэлээдгүй хяналт тавьдаг байх зохицуулалтуудыг бид хийж өгч байгаа.

П.Анужин: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Капиталтай, нийгмийн даатгалын хөрөнгөтэй холбоотой асуудлыг миний хувьд Их Хурлын гишүүн болсон цагаасаа хойш л яриад байгаа.

Нэгдүгээрт, Монголбанкны эрх хүлээн авагч байгаа байх. Энэ одоо яригдаж байгаа хуулийн шинэчилсэн

найруулга дээр ерөнхий хуулийн 13.1.4 дэх заалт дээр Монголбанкнаас тогтоосон системийн ач холбогдол бүхий гэснийг Банкны тухай хуулийн 3.1.20-д заасны дагуу гэж зааж өгч байгаа.

Энэ бол ирээдүйд үүсэх эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын хөрөнгө өнөөдрийнх шиг ийм нөхцөл байдалд орохыг хааж чадах уу гэж би танаас тодорхой асуумаар байгаа юм.

Яагаад би үүнийг асууж байна вэ гэвэл Хөгжлийн банкны шүүхийн шууд дамжуулалтууд явж байгаа. Энэ дээрээс харахад бас л Чингис хаан банктай холбоотой Хөгжлийн банкны хөрөнгийг аваачаад тавьчихсан.

Яагаад аваачаад тавьчихсан бэ гэсэн. Монголбанкнаас энэ банк бол систем нөлөө бүхий, ач холбогдол бүхий банк мөн юм. Үйл ажиллагаа нь хэвийн явж байгаа юм гэсэн ийм тодорхойлолт өгсний үндсэн дээр байршуулсан гэсэн зүйлийг тэр хэрэгт өнөөдөр шүүх хуралдаанд орсон тэр ажилтнууд ярьж байгаа байхгүй юу.

Тэгэхээр би тэндээс юу гэж хараад байна вэ гэхээр Монголбанк маань энэ системд нөлөө бүхий гэдэг юм уу, энэ банкныхаа тодорхойлолтуудыг тухайн арилжааны банктай харилцах гэж байгаа субъект рүү явуулахдаа бас тийм тодорхой хэлж өгдөггүй, бөөрөнхийлсөн байдалтай юм өгчихдөг юм болов уу.

Хэрвээ 3.1.20 гэсэн энэ заалтыг бариад явахад ирээдүйд эрсдэл үүсэхгүй байх уу гэдэг дээр та энэ эрх хүлээн авагч, яг энэ зовлонг туулж байгаа хүний хувьд хэлээд өгөөч гэж хэлэх гэж байгаа юм.

Дараагийнх нь, Капитал бол одоо зарагдах юмнууд нь зарагдаад дуусаад.

Одоо ер нь яг л би түрүүчийн хуралдаан дээр ч бас хэлж байсан яг л хүнд үе рүүгээ ирж байгаа байх. Тэр нь овоо төлбөртэй юм.

Сайдын саяын мэдээллээр та бүхэн хуулийн дагуу баахан худалдан авалт зарласан юм байна. Ороогүй юм байна. Одоо үл хөдлөх зуучлалын компаниудтай хамтарч ажиллах ийм юм руугаа орох гэж байгаа юм байна гэж ойлголоо.

Чингис хаан дээр тэр гаднын хөрөнгө оруулалттай компани хоёр хуваагаад 67, 28-аар нь хоёр хувааа гэж байна.

Магадгүй эдний үйл ажиллагаа 2027 он гэхэд хэвийн болж чадахгүй. Бизнес юм чинь янз янзын эрсдэл гараад, эргээд төлж чадахгүй болно гэсэн ийм эрсдэл үүсвэл энэ Чингис хааны өрийг одоо яг хэн эцсийг нь барагдуулах вэ юм бэ? Энэ дахиад шинэ харилцагч гарч ирсэн Баянмөнх юу гэлээ. Энэ маань барагдуулах юм уу, Чингис хаан нь барагдуулах юм уу?

Энэ хоёрын хоорондох гэрээ контракт дээр энэ өр зээлийн асуудлыг яаж тусгасан байгаа юм бэ гэсэн үндсэндээ нэг ийм хоёр асуулт асууя гэж бодож байна.

П.Анужин: Хэн хариулах вэ? Ц.Идэрбатгишүүний асуултад.

2 номерын микрофонд Ц.Ганцэцэг дарга хариулья.

Ц.Ганцэцэг: Монголбанкны эрх хүлээн авагч ирээгүй байна.

Тэгэхээр Ц.Идэрбатгишүүний хоёр дахь асуултад.

Нэгэнт Хятадын хөрөнгө оруулалттай компани Чингис хаан банкны хувьцааг авахаар Монголбанктэй гэрээ хийчихсэн.

Бидэнд ирсэн мэдээллээр зөвхөн манай нийгмийн даатгалын биш, эрүүл мэндийн даатгалын бусад төрийн байгууллагад бас өр төлбөртэй байгаа. Тэгээд энэ бүх өр төлбөрөө үндсэндээ бид хариуцна гэсэн байдлаар энэ гэрээг хийчихсэн гэж бид ойлгож байгаа.

Тийм учраас энэ хувьцаа эзэмшээд, бүрэн асуудал шийдвэл “Баянмөнх” гадаадын хөрөнгө оруулалттай компани л үндсэндээ энэ өр төлбөрийг хариуцаад явна гэж ойлгож байгаа.

П.Анужин: Ц.Идэрбатгишүүн тодруулья.

Ц.Идэрбат: Тийм ээ. Би жоохон болгоомжлол төрөөд эхэлчихлээ.

Яг үнэнийг хэлэхэд татвар төлөгчдийн энэ их хөрөнгийн асуудлыг бид энэ оройн цагаар, ийм цөөхөн бүрэлдэхүүнтэй зүгээр нэг сонсоод өнгөрөх биш.

Тэгээд Монголбанкны эрх хүлээн авагч нь байхгүй. Яг энэ асуултад Ц.Ганцэцэг дарга бол хариулах хүн биш шүү дээ.

Тийм учраас миний санаа бол одоо Байнгын хороон даргад юу хэлж байна гэхээр үнэхээр яг энэ Байнгын хорооны хуралдаан дээр энэ асуудлыг оруулж ирэхэд Байнгын хорооны гишүүдэд яг эргэлзээтэй байгаа энэ төлбөр мөнгөтэй холбоотой асуудлыг хариулж чадахгүй байгаа учраас би хойшлуулах саналтай байна. Горимын санал гэсэн үг.

НДҮЗ^[Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл]-ийн гишүүд та бүхэн шинэ орсон хүмүүс. Яг энэ гэрээ контрактыг үзсэн харсан Монголбанкны эрх бүхий хүмүүс биш байгаа байхгүй юу.

Би Монголбанкны эрх бүхий хүн байгаа гэж ойлгоод.

П.Анужин: Ц.Идэрбат гишүүний микрофоныг нээж өгье.

Ц.Идэрбат: Өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлын хоёрт орсон энэ асуудал олон жил ужгирсан, маш их хэмжээний мөнгө төгрөгтэй холбоотой ийм асуудлууд байгаа учраас өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлаас хойшлуулаад, Байнгын хорооны гишүүдийн ирц ч өргөн баймаар байна. Ажлын хэсэг тэр Монголбанкны эрх хүлээн авагчийн асуудлууд ч баймаар байна.

Дээрээс нь Чингис хаан банкны хувьцааг нь худалдаж авч байгаа тэр компаниудын хоорондох гэрээ контракт юмнуудыг ч гэсэн бас үзэж харах нь зүйтэй болов уу.

Тэгэхгүй бид ингээд шөнө оройн цагаар иймэрхүү байдлаар үүнийг шийдвэрлэнэ гэхэд хэцүү байгаа учраас зарчмын зөрүүтэй санал.

Горимын санал нь юу гэхээр энэ удаагийн хурлаар үүнийг хэлэлцэхийг

хойшлуулъя. Дараагийн тайланг нь ч хойшлуулъя гэсэн ийм санал гаргаж байна.

П.Анужин: Ц.Идэрбат гишүүн горимын санал гаргаж байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэгдэх Чингис хаан банкны Нийгмийн даатгалын сангийн өр барагдуулах үйл явцын тайлан, мэдээлэл, мөн өнөөдөр НДҮЗ-ийн тайлан сонсох энэ асуудлуудыг хойшлуулах горимын санал гаргаж байна. Санал хураана. Гишүүд ээ.

Ц.Идэрбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

Ц.Идэрбатын гишүүний гаргасан хоёр асуудлыг хойшлуулж, дараагийн Байнгын хороогоор оруулах санал 55.6 хувиар дэмжигдлээ.

Дараагийн хурал дээр сонсьё.

Өнөөдрийн Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөлөө.

Байнгын хорооны хуралдаандаа идэвхтэй оролцсон Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдэд баярлалаа.

Хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдэддээ баярлалаа.

Хуралдаан 5 цаг 11 минут үргэлжилж, 20 цаг 21 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД